

БҮЛЭГ 1

Танилцуулга



Танилцуулга

Алхийн аливаа улс оронд Дотоодын Нийт Бүтээгдэхүүнийг (ДНБ) тооцох үүрэг бүхий төрийн статистикийн байгууллагууд эдийн засгийн үйл ажиллагааны зарим хэсгийг хамарч ажиглаж чаддаггүй. Эдийн засгийн энэхүү ажиглагдаагүй байгаа үйл ажиллагааг сүүдрийн эдийн засаг гэж нэрлэдэг бөгөөд НҮБ-аас гаргасан Үндэсний Тооцооны Систем (ҮТС)-93-н аргачлалын дагуу үндэсний тооцоонд хамрагдах ёстой боловч хамрагдахгүй байгаа эдийн засгийн үйлдвэрлэлийг тус тайланд сүүдрийн эдийн засаг гэж тодорхойллоо (НҮБ 1993). Өмнө хийгдсэн судалгаагаар (ЭЗХАХБ, 2002) сүүдрийн эдийн засаг үүсэх хоёр эх үүсвэрийг тодорхойлсон билээ. Нэг эх үүсвэр нь мэдээлэл цуглуулах, бүрдүүлэхэд гарч буй статистикийн сүүдэр, нөгөө эх үүсвэр нь албан ёсны тооцоонд хамрагдах сонирхолгүй аж ахуйн нэгж, өрх, иргэдээс үүдэлтэй эдийн засгийн сүүдэр юм. Тухайлбал, судалгаа, тооллогын түүврийн хүрээг дутуу хамруулан тооцож улмаар хүн ам, өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын зарим хэсгийг орхигдуулах, эсвэл судалгаанд хариулаагүй тохиолдолд уг үйл явцыг зөв зохицуулаагүй, мөн чадавхи дутмагаас мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг дутуу дулимаг алдаатай хийсэн зэргээс үүдэн статистикийн сүүдэр үүсдэг.

Харин эдийн засгийн сүүдэр нь судалгаа тооцоонд хамрагдах хүсэлгүйн улмаас аж ахуйн нэгж, өрхүүд үйл ажиллагаа, үйлдвэрлэлийнхээ талаар буруу ташаа мэдээлэл өгдөгтэй холбоотой. Эдийн засгийн сүүдрийн үйл ажиллагаанд оролцож буй этгээд нь татвар, нийгмийн даатгалын төлбөрөөс зугтах, эсвэл тодорхой дүрэм журмыг өндөр зардал гарган дагаж биелүүлэх явдлаас зайлсхийх зэргээр материаллаг ашиг хүртэх боломжтой. Гэхдээ сүүдрийн буюу далд эдийн

засаг эрхлэх болсоноор тэдний хувьд хууль дүрэм зөрчсөний төлөө ногдох торгууль шийтгэл хүлээх, тэтгэвэр, цагдаа, санхүү зэрэг нийтийн үйлчилгээнд хамрагдахгүй байх зэрэг хохирол амсах эрсдэлтэй тул сүүдрийн үйл ажиллагаа эрхлэх нь өөрийн гэсэн өртөг зардалтай. Дээрх ашигтай болон хохиролтой талуудыг аж ахуйн нэгж, өрх хэрхэн үзэж буйг судлан мэдэх нь сүүдрийн эдийн засаг оролцогчдынхоо сайн сайхан байдал болон улс орны нийт эдийн засагт ямар нөлөөтэй болон ач холбогдолтой болох талаар ойлгоход зайлшгүй чухал.

Эдийн засаг, статистикийн эх сурвалжаас гадна сүүдрийн эдийн засгийг албан болон албан бус үйл ажиллагаа эрхэлж буйгаар нь ангилж болно.⁷ Хэдийгээр албан бус секторыг тухайн орны нөхцөл байдалд уялдуулан олон янзаар тодорхойлсон байдаг ч албан болон албан бус секторыг ялгахдаа сүүдрийн эдийн засгийг тооцож судлах явдлыг төөрөгдүүлж, ойлгомжгүй болгох ёсгүй. Энэ тайланд албан бус секторын сүүдрийн үйл ажиллагааг нарийвчлан тооцохын тулд хуулийн дагуух бүртгэлийн шаардлагатай уялдуулан албан болон албан бус секторуудыг ялган авч үзэв.⁸ Эдгээр салбар нь маш өөр шинж төлөвийг агуулсан байдаг тул ийнхүү ангилан ялгаж судалгаа хийхдээ нэлээд өөр өөр аргачлал ашиглах шаардлагатай байдаг. Албан секторыг судлах статистикийн арга хэрэглэгдэхүүн илүү сайн хөгжсөн байдаг тул энэ салбар дахь сүүдрийн үйл ажиллагаа нь эдийн засгийн шалтгаантай илүү уялдаатай ба бодлогын өөрчлөлт хийхэд илүү үр дүнтэй байх магадлалтай. Харин албан бус секторт статистик судалгааны арга хэрэгсэл сул хөгжсөн, мөн далд байж үйл ажиллагаа эрхлэх эдийн засгийн ашиг сонирхол гэсэн хоёр асуудлыг давхар харгалзан үзэх ёстой.

⁷ Ихэвчлэн далд хэлбэрээр оршдог үйлдвэрлэл нь хууль бус бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл байдаг (ОУЭЗХАХ 2002). Бид тайландаа хууль бус бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг хамруулаагүй, харин хуулийг даган мөрдөхгүй байгаа үйл ажиллагааг оруулсан.

⁸ Албан бус секторт ажиллаж буй боловч зарим талаар албан байдалтай байгаа аж ахуйн нэгжүүдийг ялгаатай авч үзэх хэрэгтэй гэдгийг бид ойлгож байна. Тухайлбал, нэг хэсэг нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчийг ажиллуулж байхад нөгөө хэсэг нь хөлсний ажилчин ажиллуулах, эсвэл бизнес аж ахуйн байршил тогтвортой, тогтворгүй ажиллах зэрэг талууд ажиглагддаг. Монгол Улсын Албан Бус Секторын хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйдад ялгаатай хандах нь чухал. Энэхүү зарим талаар албан байдалтай ажиллаж буй түвшингийн талаар тайлангийн 5-р хэсэгт өгүүлэв.

Социализмаас капитализм руу шилжиж буй эдийн засгийн нөхцөлд албан бус секторын сүүдрийн эдийн засаг чухал үүрэгтэй байдаг болохыг тогтоосон нотолгоо байна (Эйлат, Зиннэс нар, 2002). Улсын үйлдвэр аж ахуйн нэгжид үзүүлэх дэмжлэгийг зогсоон өөрчлөн байгуулалт хийсний дүнд олон хүн ажилгүй болохын зэрэгцээ шилжилтийн эхэн үед зах зээлийн үйл ажиллагааг дэмжигч институциуд сул дорой байдаг. Ийм нөхцөл байдалд албан бус сектор дахь сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагаа хэд хэдэн чиглэлээр чухал үүрэг гүйцэтгэж чадах ба эдгээрийн дундаас хамгийн чухал үүрэг нь олон хүний хувьд ажлын байраар хангагдах сүүлчийн боломж болж тэд ядууралд нэрвэгдэхээс сэргийлэх үүрэг юм. Албан бус сектор дахь сүүдэр үйл ажиллагаанд шилжин орох нь хялбар, саад багатай байх нь тодорхой боловсрол, ажлын ур чадвар эзэмшсэн, гэвч хөрөнгө чинээ багатай хүмүүсийн хувьд таатай боломж байж болох юм. Иймд сүүдрийн эдийн засгийг гол төлөв сөрөг талаас нь хардаг ч түүний динамик байдал нь аж ахуй, бизнес эрхлэх аж ахуйч сэтгэлгээ, ур чадварыг хөгжүүлэн эрчимжүүлж, албан сектор дахь цочрол, хямралаас зайлсхийх боломж олгож, жижиг бизнес эрхлэх инкубаторын үүрэг гүйцэтгэх зэрэг чухал үүрэг гүйцэтгэх боломжийг олгодог.

Хэдийгээр албан бус сектор дахь сүүдэр үйл ажиллагаа нь ялангуяа богино хугацаанд ийм эерэг талуудтай ч, урт хугацаанд уг салбарт оролцох нь нийт дүнгээрээ сөрөг үр дагавартай байж болох юм. Хөрөнгийн зах зээл, санхүүгийн үйлчилгээнд хамрагдахгүйн улмаас хөрөнгө оруулалт, ажлын хүч хөлслөн авах шийдвэрийг гажуудуулж, улмаар бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь капитал давамгайлсан бус байх ба оновчтой бус богино хугацаанд төлөвлөгддөг. Эдгээр саад тотгорын улмаас аж ахуйн нэгж байгууллагууд эдийн засгийн үйл ажиллагаагаа өргөжүүлж хэмжээнээс үүдэлтэй хэмнэлтийг ашиглаж чадахгүйд хүргэж, улмаар бүтээмж, үр ашгийг бууруулна. Түүнчлэн албан бус секторын сүүдэр үйл ажиллагаанд оролцох нь албан секторт оролцохтой холбоотой байр суурь, хандлага, нийгмийн хэм хэмжээг ч өөрчилж болох үр дагавартай. Үүний дүнд албан бус сектор дахь сүүдэр үйл ажиллагаа нь материаллаг, хүний нөөц, нийгмийн капиталтай холбоотой гарах байр суурь, хандлага, чадавхийн өөрчлөлтийг даган үр дагавар нь урт удаан

хугацаанд оршин тогтнож болох юм. Хэдийгээр эдийн засгийн үр дагаврын талаарх үзэл бодол, төсөөлөлдөө үндэслэн албан байдалтай ажиллаж буй аж ахуйнууд эдийн засгийн сүүдэр үйл ажиллагаа эрхлэх буюу эрхлэхээ зогсооход харьцангуй хялбар байдаг ч албан бус секторт сүүдэр эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх нь илүү урт хугацаатай байх магадлалтай. Тиймээс ч албан бус секторын сүүдрийн үйл ажиллагааг багасгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхэд илүү хүндрэлтэй байж болзошгүй.

Албан бус сектор дахь сүүдэр эдийн засгийн үргэлжилсэн буюу нөлөөнд удаан автах бололцоо их байгаа нь бодлого боловсруулагчдын хувьд шийдвэрлэхэд бэрхшээлтэй хэд хэдэн асуудлуудын нэг юм. Магадгүй хамгийн шууд бэрхшээл нь албан болон албан бус секторын аж ахуйд татвараас зугтан зайлсны улмаас татварын орлогын эх үүсвэрээ алдах, ингэснээр нийгмийн хамгаалал, халамжийн бодлогоо хэрэгжүүлэх, нийтийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах төрийн боломж, чадавхийг хязгаарлана. Нийтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар муу байвал татвар төлсний үр ашгаа хүртэж чадахгүй байгаа аж ахуйн нэгж албан бус сектор дахь сүүдэр хэсэг рүү шилжиж, ингэснээр улсын татварын эх үүсвэр багасах зэрэг гарцгүй тойрог үүснэ гэсэн үг. Түүнчлэн сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагаа нь мэдээллийн хомсдолыг үүсгэн шийдвэр гаргах явцыг хүндрүүлнэ. Эдийн засгийн бодит хэмжээ, бүтцийн талаар мэдээлэл байхгүй тул хөрөнгө нөөцийг салбар, бүс нутгуудаар хуваарилан олголт нь үр ашиг муутай байх магадлалтай. Цаашилбал, макро эдийн засгийн түвшинд мөнгөний болон сангийн дэмжлэг үзүүлэх бодлогын талаарх шийдвэр нь ДНБ, түүний өсөлтийн хувиас ихээхэн хамаардаг. Гэтэл эдгээр үзүүлэлтийн талаар үнэн бус мэдээлэл дээр үндэслэсэн бодлогыг итгэл төгс болосвруулах боломжгүй ба гарах нөлөө үр дүн нь тодорхойгүй байна.⁹

Энэхүү судалгаа нь Монголын албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хэмжээ буюу хамрах хүрээ, шалтгаан, эдийн засаг, нийгмийн үр дагаврыг тооцох, улмаар бодлогын ямар үр дагавар гарах зэрэг нарийн түвэгтэй олон асуудлыг хамарсан юм. Монголын Нээлттэй Нийгмийн Форум (ННФ), Үндэсний Статистикийн Газар (ҮСГ), Мэрилэндийн Их Сургуулийн ИШАБС-ын Төв, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн

⁹ Сүүдрийн эдийн засагтай холбоотой бодлогын асуудлуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Эйлат, Зиннэс нарын бүтээлээс харна уу (2002).

Агентлаг (ОУХА)-н Эдийн засгийн бодлогын шинэтгэл ба өрсөлдөх чадварын төслөөс хамтран хэрэгжүүлсэн судалгааны өгөгдөл мэдээллийн эх үүсвэр дээр үндэслэн дүгнэлтүүдийг хийсэн болно. Монголын бүх бүс нутгийн нийт 19,000 өрхийг хамруулан судалгааг 2004 оны 10 ба 11 дүгээр саруудад явуулсан нь энэхүү төслийн гол үйл ажиллагаа байв. Судалгааны явцад албан болон албан бус аж ахуйн нэгж, байгууллагын санхүү, зохион байгуулалт бүтцийн орчин, мөн тэдгээрийн болон орлого бүхий иргэдийн хувийн болон өрх бүлийн шинж тэмдгийн талаарх мэдээллийг цуглуулсан. Хэдийгээр судалгаагаар түүвэрт хамарсан албан сектор дахь аж ахуйн нэгжийн талаар мэдээлэл цуглуулсан ч албан секторын сүүдрийн эдийн засгийн хэмжээг тооцох зорилгыг дэвшүүлээгүй болохыг анхаарна уу.

Судалгааны тайлангийн бүтцийг танилцуулбал энэ хэсэгт судалгааны хамрах хүрээ, зорилго, түүндээ хүрэх зорилгоор хэрэглэсэн аргачлалын талаар, 2-р хэсэгт судалгааны хэрэгсэл, мөн хувилбаруудыг боловсруулах арга зүйн талаар дэлгэрэнгүй дурьдсан. Эцсийн судалгаанд ашигласан аргачлал нь Монголын нөхцөлд шинэлэг байсан тул өргөн хүрээний туршилт судалгаа хийх шаардлагатай байв. Судалгааны тайлангийн 2.1-р дэд хэсэгт хоёр удаа явуулсан туршилт судалгааны зорилго, үр дүн болон эдгээрийг ашиглан аргачлалыг хэрхэн эцэслэн боловсруулсан талаар танилцууллаа. 2.2-р дэд хэсэгт асуултуудын төрөл, агуулга зэргийг тайлбарласнаас гадна судалгааны хэрэгслүүдийг төрөл бүрээр ашиглан туршилтын хувилбаруудыг хэрхэн боловсруулсан талаар дурьдав. Зардлын хувьд хямд төсөр, гэхдээ төлөөлөхүйц хэмжээний түүврийг сонгоход зарим сонирхолтой асуудлууд тулгарч байв. Эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар 3-р хэсэгт дурьдсан буюу 3.1, 3.2, 3.3-р дэд хэсгүүдэд түүврийн хэмжээ, түүврийн сонголт, судалгааны дүнг нийт хүн амд хэрхэн тархаан тооцсон талаар тус бүр нарийвчлан өгүүлсэн. 4-р хэсэгт албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хэмжээг тооцсон үндсэн дүнг, мөн албан бус секторын сүүдэр хэсгийг тооцоход шинээр туршиж хэрэгжүүлсэн хувилбаруудын үр дүнг танилцуулав. 5-р хэсэгт албан бус секторын судалгааны үр дүн бодлогод хэрхэн нөлөөлөх, бодлогын үр дагаварын талаар дурьдсан. 5.1-р дэд

хэсэгт 4-р хэсэгт танилцуулсан албан бус секторын хамрах хүрээний тооцоог нарийвчлан дэлгэрүүлж, албан болон албан бус секторын үйл ажиллагааны талаар судалгаанаас гарсан тоо мэдээлэлд үндэслэн сүүдрийн эдийн засгийн дүр зургийг тодорхойлсон болно. 5.2, 5.3-р дэд хэсгүүдэд дүрслэл дүн шинжилгээг албан бус сектор дахь сүүдрийн үйл ажиллагаа эрхлэх шалтгаан, үр дагаврын талаар судлаж баяжуулсан бол 6-р хэсгийн эхэнд судалгааны дүгнэлт, бодлогын үр дагаврын талаар тус тус танилцуулав. Үүний дараагаар судалгааны арга хэрэгсэл, дүн шинжилгээн дэх сул дутагдалтай талуудын талаар өгүүлж, эдгээр дутагдлыг арилгахад чиглэсэн өртөг багатай үйл ажиллагаа, аргуудыг санал болгосноо толилуулав. Уг хэсгийн төгсгөлд цаашид хэрэгжүүлэх албан бус секторын судалгааг хэрхэн бодит боломжид тулгуурлан явуулах, түүнчлэн албан тооцоонд хамрагдахгүй байгаа сүүдрийн эдийн засгийн бусад хэсгийг хамруулахад чиглэсэн хэд хэдэн үйл ажиллагааг санал болголоо.

Хамтран хэрэгжүүлсэн уг төслийн үндсэн үйл ажиллагаа нь албан бус секторын өрхийн судалгаа байв (АБСӨС). Монгол Улсын эдийн засгийн үйлдвэрлэл дэх албан бус секторын эдүгээ болон цаашид эзлэх хувь хэмжээг тооцоход шаардлагатай суурь мэдээллийг шинээр бүрдүүлэх замаар ҮСГ-аас ДНБ-ийг илүү бодитой тооцох боломжийг нэмэгдүүлэхэд тус судалгааны зорилго оршиж байв. Энэ утгаараа АБСӨС-ны дүн нь 1999 онд АНУ-ын ОУХА/ЭЗБДТ-ийн хийсэн судалгааны (Бикалес нар, 2000) дүнг орлон, нөхөн шинэчлэх ач холбогдолтой юм. ДНБ-ийг тооцох зохистой арга барил болохын хувьд АБСӨС нь албан бус секторын сүүдрийн эдийн засгийн статистик болон эдийн засгийн эх үүсвэрийг аль алийг нь авч үзсэн. Үүнд статистикийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд өрх аж ахуйн хосолсон судалгааны Монголын нөхцөлд тохируулан өөрчилсөн хувилбарыг АБСӨС-гаар хэрэгжүүлсэн. Хосолсон судалгаа нь НҮБ-ын үзэж буйгаар албан бус секторын талаар бүхэлд нь мэдээлэл цуглуулах “хамгийн тохиромжтой арга” юм (НҮБ, 2000, 1-р боть).¹⁰ Энэ аргачлалын үндсэн давуу тал нь өрхийн жагсаалтанд үндэслэн түүврийн хэмжээг харьцангуй бүрэн тодорхойлон

¹⁰ Ийнхүү өрх, аж ахуйн хосолмол судалгааг тохируулан хэрэглэснээр албан секторт оролцогчдын тадаар ч мэдээлэл цуглуулах давуу талтай ба НҮБ-н судлаачдын санал болгосон загварчлалыг бодвол өртөг багатай. Манай хэрэгжүүлсэн хандлагын зарим анхаарах зүйлсийн талаар энэ тайлангийн 6-р хэсэгт өгүүлсэн.

сонгодогт оршино. Тайлангийн 2-р хэсэгт дурьдсанчлан ингэж өрхийг түүвэрлэн авах нь Албан Бус Секторын хуулинд үндэслэн түүврийн хүрээг тогтоохоос илүү оновчтой байх юм.¹¹ Урьд нь явуулж байсан зарим судалгаа тухайлбал саяхан хийгдсэн Ажиллах хүчний судалгаа (АХС)-гаар хосолсон судалгааны аргын нэг бэрхшээлтэй тал илэрч гарсан. Үүнд АХС-ны дүнгээс үзэхэд албан бус секторт оролцоогүй өрхийн тоо олон тул нийт өрхийн зөвхөн багахан хэсгийн үйл ажиллагааг сонирхох шаардлагатай байсан ба үүнийг шийдвэрлэхийн тулд НҮБ-аас зөвлөмж болгосны дагуу хоёр шатлалт түүвэрлэлт хийх, тухайлбал эхний шатанд албан бус секторт ажиллаж буй аж ахуй, өрхийг эхний товчхон ярилцлагаар тодруулж, дараачийн шатанд тодруулсан аж ахуй, өрхөөс бүрдсэн түүвэртэй ажиллаж болох аж. Гэвч энэ аргачлал нь үнэ өртөг ихтэй, цаг зарцуулсан ажил болох тул ганц шатлал бүхий тохиргоог хийж, үүнд албан бус секторт оролцоогүй олон өрхийг түүвэрлэн авахаас шууд зайлсхийж, түүврийн хүрээг харьцангуй бага зардлаар тодорхойлох боломжтой болсон юм. Энэхүү сонгох протокол дүн шинжилгээд хэрхэн нөлөөлөх талаар 3.3-р дэд хэсэгт, түүнчлэн цаашид сайжруулж болох сонголтуудын талаар 6.2-р дэд хэсэгт танилцуулав.

АБСӨС-г загварчлахдаа албан бус секторын сүүдэр хэсгийн эдийн засгийн эх үүсвэрийн асуудлыг дараахь хэд хэдэн аргачлалыг ашиглан шийдвэрлэсэн. Судалгааг хэрхэн загварчлах талаар өмнө хийгдэж байсан судалгаанууд асуулгад хариулахгүй байх, ялангуяа орлого, бусад эмзэг асуултанд хариулахгүй байх явдлыг бууруулахад голчлон анхаарчээ. Тэдгээрийн зарим дүгнэлтээс харахад нэлээд энгийн аргаар асуултуудад илүү бүрэн хариулт авах боломжтой байна. Тухайлбал, хууль ёсоор мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, мэдээлэл цуглуулахын ач холбогдлын талаар хариулагчдад тайлбарлах зэрэг нь үр дүнтэй арга болох нь тогтоогдсон (Муур нар, 2001). Түүнчлэн дугтуйнд хариултаа хийж наах зэргээр тоологчдод мэдэгдэлгүйгээр хариулт авсанаар хариулт нь шууд тайлбарлах боломжгүй ба хувь хүний хариултад статистик алдаа үүсгэж байгаа ч нэгдсэн дүнг тайлбарлах бүрэн боломжтой байх юм. Дээрх хоёр аргыг ашиглах нь хариулагчийн

зүгээс санаа зовниж буй хоёр өөр төрлийн асуудлыг шийдвэрлэж байгааг анхаарах хэрэгтэй. Дугтуйн арга ашигласнаар хариулагч нь тоологчид шууд амаар хариулахаас эвгүйцэх байдлаас зайлсхийх ба харин дүн шинжилгээ хийгч түүний хариултыг бүрэн мэдэх болно. Дүн шинжилгээ хийж буй судлаач ч тухайн хувь хүний үнэн хариултыг мэдэх боломжгүй тул нэмэлт статистик алдаа үүсгэж буй энэ арга нь мэдээллийн нууцлалыг чанд сахих боломжийг олгож байна. Харин ерөнхий зан үйлийн талаар тайлбар хийх боломж хэвээр хадгалагдана. 2.2-р дэд хэсэгт мэдээллийн нууцлалыг хадгалах үйл явцын талаар илүү дэлгэрэнгүй тайлбарласан ба тэдгээрийн статистик шинж тэмдгийн талаар Хавсралт 1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

ДНБ дэх албан бус секторын сүүдрийн эдийн засгийн эзлэх хувийг улсын хэмжээнд тооцоноос гадна таван бүс нутаг болох Баруун, Хангай, Төв, Зүүн бүс ба Улаанбаатар хотын түвшинд, мөн аймгийн төв, сумын төв, хөдөө орон нутаг гэсэн 3 байршлаар тооцон гаргав. Эдгээр тооцооны нэгж нь Өрхийн Орлого, Зарлагын Судалгаа (ӨОЗС), АХС зэрэг ҮСГ-аас цуглуулдаг бусад өгөгдөлтэй үр дүнг харьцуулах боломжийг олгож байгаа юм. Мөн нэмэгдэл өртгийн эзлэх хувь хэмжээг салбаруудаар Эдийн Засгийн Үйл Ажиллагааны Олон Улсын Стандарт Ангилал (ЭЗҮАОУСА)-н нэг оронгийн түвшинд нэгтгэн тооцож гаргасан.

Хамрах хүрээ, хэмжээг тооцохоос гадна АБСӨС-гаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй, өрхүүд албан болон албан бус секторт шилжих талаар шийдвэр гаргаж буй нөхцлийг зохион байгуулалт бүтцийн үндсэн асуудлуудтай уялдуулан тооцох замаар албан бус секторын сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааны шалтгаан, нийгмийн үр дагаврыг тодорхойлоход чиглэсэн асуултуудыг агуулсан. Татвар төлөх, засгийн газрын байгууллагуудаас үзүүлж буй “дарамт шахалт”, хээл хахууль, бэлэг сэлт өгсөн давтамж, тооны талаарх мэдээлэл болон төрөөс үзүүлж буй нийтийн үйлчилгээ, тухайлбал шүүх байгууллагын үйлчилгээний чанар, ашиг орлогод зохицуулалтын дэглэм нөлөөлж буй байдал зэргийн талаарх үзэл бодол, туршлагын талаар асуусан. Түүнчлэн хувийн секторын байгууллагууд, тухайлбал санхүүгийн зуучлагчид,

¹¹ Албан Бус Секторын хуулинд албан бус секторын сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааны зөвхөн зарим хэсэг л тусгагдсан. Гэтэл туршилт судалгаагаар бүртгэл хамрагдаагүй, үлэмж хэсэг энэ хэсгүүдэд байгаа нь харягдсан.

бизнесийн холбоодын үйл ажиллагааны талаар ч асуусан. Эдгээр мэдээллийг авснаар тухайн салбар нь гол төлөв ядуурлаас гарахын тулд ажил эрхлэх сүүлчийн боломж төдий байна уу эсвэл баялаг хуримтлуулах чадвартай илүү эрчтэй бизнес аж ахуйн үйл ажиллагаа бүрэлдэн хөгжиж байна уу гэдэг талаар тодорхой ойлголт өгөх болно.¹² Эцэст нь татвар, дүрэм журам зэрэг асуудлаарх байр суурь, хандлагад албан бус сектор ямар нөлөө үзүүлж байгааг судласны дотор тухайлбал хээл

хахууль өгч, авах, татвараас зайлсхийх, хууль бусаар бараа хил давуулах зэрэгт албан ба албан бус секторын аж ахуйд ямар харилцаанд орж буй талаар тодруулах зорилтыг агуулсан. Энэ бүх мэдээллийн үндсэн дээр бодлогын хувилбаруудын талаар дүгнэлт гарган, аль нь Монголын ард түмний сайн сайхан байдалд эерэг, сөрөг нөлөө үзүүлэх, эсвэл нөлөө үзүүлж чадахгүй байх талаар тодруулах боломжтой. Эдгээр дүгнэлтүүдийн тоймыг 6.1-р хэсэгт танилцуулав.

¹² Үүнтэй холбоотой авч үзсэн бас нэг асуудал бол албан бус сектор албан үйл ажиллагааг орлож байна уу, нөхөж байна уу гэсэн асуудал юм. Албан секторыг нөхөх үүднээс албан бус пүүсүүд гэрээлэгч, өөрсдийн хөрөнгө мөнгө, нарийн технологи хүрэхгүй үйлдвэрийн үйл явцад орцыг нийлүүлэгч байдаг. Албан секторыг орлох үүднээс албан секторын пүүсүүдтэй шууд өрсөлдөөнд ордог.

БҮЛЭГ 2

Судалгааны аргачлал, арга зүй



Судалгааны аргачлал, арга зүй

Энэ бүлэгт 2004 оны 3, 4-р сард туршилт судалгаануудыг явуулсны дараагаар эцэслэн боловсруулсан судалгааны асуулгын талаар дэлгэрэнгүй тайлбарлав. Судалгаанд ашиглах асуулга авах аргуудын зарим нь туршилтын шинжтэй, том судалгаанд хэрэглэх үндэслэл хир бодитой байгаа эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай байсан зэргийн улмаас туршилт судалгаанууд нь судалгааны асуулгыг эцэслэн боловсруулахад маш чухал ач холбогдолтой байв. Асуулгыг хэрхэн эцэслэн боловсруулсан талаар ойлголт өгч, цаашид өөр судалгаануудад эдгээр асуулга авах аргуудыг ашиглах боломжийг бүрдүүлэхийн тулд зохих мэдээллээр хангах зорилгоор эхлээд туршилтын хоёр судалгаа, тэдгээрээс гарсан дүгнэлтүүдийг тайлбарлах замаар судалгааны асуулгын загварыг хэрхэн боловсруулсан талаар танилцуулав.

2.1. СУДАЛГААНЫ ЭХЛЭЛ ҮЕ ШАТ: ТУРШИЛТ СУДАЛГААНУУДЫН 1, 2-Р ШАТ

Туршилт судалгааны эхний шатанд 2004 оны 4-р сарын 13, 14-ний өдрүүдэд ҮСГ-ын 20 тоологчоос бүрдсэн баг Улаанбаатар хотоос санамсаргүй аргаар түүвэрлэгдсэн нийт 240 өрхийг бүрэн хамруулан мэдээлэл цуглуулсан. Энэ шатанд хэд хэдэн зорилтыг дэвшүүлсний дотор нэгдүгээрт мэдээллийн нууцлалын асуудал нь хариулагчдын хувьд хэр чухал байгааг мэдэх явдал байв. Эмзэг, хувийн шинж чанартай мэдээллийг илүү хэмжээнд авч чадахгүй бол зардал өртөг ихтэй энэ аргуудыг ашиглах нь онцын шаардлагагүй байдаг. Эдгээр аргыг бусад оронд ашиглахад үр дүнтэй байсан ч (Сивасан, 2003) Монголын нөхцөлд үр дүнтэй эсэхийг нь туршиж үзэх хэрэгтэй байлаа. Хоёрдугаарт, бидний мэдэж байгаагаар бусад оронд судлаагүй асуудал бол итгэлцэл, эрсдэл зэрэгтэй холбоотойгоор харилцан адилгүй зан ааштай хариулагчдын хувьд мэдээллийн нууцыг

хадгалах хэрэгцээ хэрхэн өөрчлөгдөн хэлбэлзэж байгааг мэдэх явдал юм. Нийгмийн болон хувь хүний байр суурь, хандлагыг судлах нь зөвхөн арга зүйн асуудал төдий бус. Туршилт судалгаа болон үндсэн судалгааны үеэр тооцон тодорхойлсон шинж чанар сүүдрийн эдийн засаг эрхлэх, өрхийн орлого болон бусад зан үйлтэй хэрхэн уялдаж байдаг талаар ойлголт, мэдлэг авахыг зорьсон. Туршилт судалгаа нь түүнчлэн ҮСГ-ын тоологчдыг шинэ аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулахад суралцуулахад чухал алхам болсон юм. Сургалтанд хамрагдсан тоологчдын дийлэнх нь үндсэн судалгааны үеэр ахлагчаар ажилласан ба туршилт судалгааны эхний шатанд тэдний хуримтлуулсан мэдлэг туршлага 2-р шат болон үндсэн судалгаанд өөрчлөлт засвар хийхэд ихээхэн ач холбогдолтой байсан.

Туршилт судалгааны эхний шатанд хариулагчийн мэдээллийн нууцлалыг хадгалах зэрэглэл нь харилцан адилгүй гурван хувилбарыг ашигласан ба хариулагчдыг гурван хувилбарын нэгд нь санамсаргүй байдлаар хамааруулав. Эдгээр хувилбаруудын хоорондын гол ялгаа нь ялгаатай түвшний мэдрэмж бүхий хоёр хариултын нэгийг сонгох (тийм/үгүй) асуултуудад статистик алдаа өөр байгаа явдал юм.¹³ Гурван хувилбарын хоёрт нь оруулж өгсөн статистик алдааг санамсаргүй хариултын протокол гэж нэрлэдэг ба анх Уорнер (1965)¹⁴ танилцуулсан юм. Нэгдүгээр хувилбарт санамсаргүй хариултын протоколыг ашиглаагүй ч эмзэг, хувийн шинж чанартай асуултуудыг судалгаанд нийтлэг хэрэглэдэг байдлаар буюу хариулагчид шууд хариулах хэлбэрээр асуултыг тавьсан. Гэхдээ уг хувилбарын хариултыг дугтуйнд хийн нааж авснаар тоологч нарын өмнө хариулагч эвгүй байдалд орохоос сэргийлсэн. Хоёр, гуравдугаар хувилбарт эмзэг, хувийн шинж чанартай бус асуултыг нэмж оруулж өгсөн ба хариулагч нь шоо хаяж эмзэг, эсвэл эмзэг бус

¹³ Туршилт судалгаа болон үндсэн судалгаанд ашигласан тийм/үгүй асуултын дүнгийн талаар дэлгэрэнгүй танилцуулав. Хавсралт 1-д шууд бус аргуудын статистик тайлбарыг оруулав.

¹⁴ Шууд бус аргын талаар нарийвчлан тайлбарласныг Чаудхури, Мухэржээгийн (1983) бүтээлээс харна уу.

асуудлын аль нэгэнд нь л хариу өгч байв. Шооны буусан дүн буюу аль асуултад хариулж байгааг хариулагч өөрөө л мэдэж байсан. Хоёрдугаар хувилбарт хариулагч эмзэг асуултад хариулсан байх магадлал 75 хувь байсан бол, гуравдугаар хувилбарт эмзэг асуултад хариулах магадлалыг 50 хувь болгон бууруулж, хариулагчийн мэдээллийн нууцлалыг бүр илүү хамгаалсан. Үүний дүнд санамсаргүй хариултын хувилбаруудад тоологч, судалгааны дүн шинжилгээ хийгчийн аль аль нь өгсөн хариултаудын талаар тодорхой нарийвчлан мэдэх боломжгүй байв.

Мөн 1-р шатны судалгааны хэрэгсэл нь хоёр хариултаас сонгох асуултын хувьд санамсаргүй хариултын протоколыг туршиж үзсэнээс гадна эрсдэлд хандаж буй хандлага, итгэл хүлээсэн зан үйлийн талаар асуулт асуух туршилтын протоколыг агуулсан. Эрсдэлд хандах хандлагыг судлахын тулд бэлэн мөнгөний хонжвортой төрөл бүрийн сугалаануудаас сугалах боломжийг хариулагчдад олгосон ба тэдний сонголтын мөн чанар нь эрсдэлд хандах хандлагыг нь илтгэж байв.¹⁵ Энэ асуултуудад өгсөн хариултауд нь агуулгын болон арга зүйн аль алины хувьд ихээхэн ач холбогдолтой юм.

Туршилт судалгааны 1-р шатанд судалгааны бусад шатанд ач холбогдолтой хэд хэдэн чухал үр дүн гарсан. “Хос асуулт”-ыг асуулгад загварчлаж өгсөний хувьд нууцлалыг дунд түвшинд хадгалсан 2-р хувилбараар хариулсан дүн ерөнхийдөө эмзэг асуулт хамгийн олон агуулсан, гэхдээ өртөг харьцангуй бага 1-р хувилбараар хариулсан дүнтэй тун ойролцоо гарсан. Тухайлбал “Та өнгөрсөн сард бүртгүүлж, патентын (албан бус секторын) татвараа төлсөн үү” гэсэн асуултыг 1, 2, 3-р хувилбараар асуухад хариулагсдын 80%, 78% 44% тус бүр тийм гэж хариулсан байна. Иймд туршилт судалгааны 2-р шат болон үндсэн судалгааны үеэр хамгийн бага зардал бүхий 1-р хувилбар, мөн хамгийн их мэдээлэл өгөх 3-р хувилбарын дагуу асуултуудыг асууж байв.

Туршилт судалгааны дүнгээс харахад санамсаргүй хариултын протоколыг боловсруулахад энгийн асуултад хариулах сонголт нь уг аргыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Хариулагсдын нууцлалыг хангах үүднээс энгийн асуултанд “тийм” гэж хариулсан хувь эмзэг асуултанд “тийм” гэж

хариулагсдын хувиас нэг их хол зөрөх учиргүй. Түүнчлэн эдгээр хувь хэмжээ нь хоорондоо бага зэргийн зөрүүтэй байх нь тооцооны үүднээс уг аргыг утгатай болгоно.¹⁶ Хос асуултын загварыг боловсруулахад туршилт судалгааны 1-р шатыг эхлэхээс өмнө тоологчдоос асууж туршин боловсронгуй болгосон. Түүнчлэн хос асуултын арга нь нь тоогоор илэрхийлсэн хариулт авах нөхцөлд тохирмжгүй байсан ба энэ нь өмнө хийгдсэн судалгаануудын дүнтэй нийцэж байв (Эйкорт, Хэйр, 1983). Албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хэмжээг тооцоход тоогоор илэрхийлсэн хариулт шаардсан асуулт олныг асуух тул үржүүлэх аргыг туршилт судалгааны 2-р шатанд туршиж, улмаар үндсэн судалгаанд ашигласан ба уг аргын талаар 1-р хавсралтад дэлгэрэнгүй танилцуулав.

Эрсдэл, итгэлийн талаарх хандлагыг асууж мэдэх нь судалгааны аргачлал болон агуулгын хувьд чухал ач холбогдолтой байв. Агуулгын асуудлын хувьд бусад итгэх итгэл өндөр хүмүүс буюу итгэлийн талаарх гурван асуултад дундаж онооноос илүү өндөр оноо авсан хүмүүс төр засгийн түшмэдэд хээл хахууль өгөх явдалд оролцох нь харьцангуй бага магадлалтайг бид олж мэдлээ. Мөн эрсдэл хүлээх сонирхолгүй байх нь үүний ойролцоо үр дагавартай байсан, гэхдээ дүнгийн хэлбэлзэл харьцангуй бага байсан. Арга зүйн хувьд итгэх чанар илүү өндөртэй хүмүүсийн хариулт аргачлалаас хамааран хэлбэлзэх нь бага байсан.

Туршилт судалгааны 2-р шат судалгааг гурван чухал чиглэлээр өргөжүүлэн баяжуулсан. Үүнд, газар зүйн байршлын хамрах хүрээг өргөтгөж, аймаг, сумын төв, түүнчлэн хөдөө орон нутгийн цөөн өрх, мөн Улаанбаатар хотод өрхийн тоог нэмж хамруулсан байна. Өөрөөр хэлбэл ҮСГ-ын удирдлага, мэргэжилтэнгүүдтэй ярилцсаны үндсэн дээр сум болон хөдөөгийн алслагдмал газруудыг нэмж хамруулах нь албан бус секторын хамрах хүрээг илүү бодитой тооцоход чухал ач холбогдолтой гэж үзсэн. Газар зүйн хувьд өргөтгөсөн судалгааг явуулах үүднээс туршилт судалгааны 2-р шатанд нийт 600 өрхийг түүвэрлэн авсан ба Хүснэгт 2.1-т түүврийн хэмжээг байрлал бүрээр үзүүлэв. Туршилт судалгааны 2-р шатыг 2004 оны 6-р сарын 14-18-ны хооронд хэрэгжүүлэв.

¹⁵ Туршилт судалгааны 1, 2-р шатанд эрсдэлийн тоглоом тоглуулах замаар хариулагчид зарим мөнгөн хэлбэрийн урамшуулал авч байв. Гэвч энэ урамшууллын хэмжээ тун бага байсан тул үр дүнг нь үндсэн судалгаанд харгалзан үзээгүй.

¹⁶ Асуултуудыг муу боловсруулсан бол тооцооноос сөрөг хэмжээтэй дүн гарч болох юм. Хавсралт 1-д энэ талаар дэлгэрэнгүй дурьдав. Туршилт судалгааны 1-р шатанд эзлэх хувь сөрөг хэмжээтэй гарсан бол 2-р шатанд ийм дүн гараагүй.

ХҮСНЭГТ 2.1 Туршилт судалгааны 2-р шатны түүвэрлэгдсэн өрхийн тархаалт

Аймгийн төв	Сумын төв	Хөдөө орон нутаг	Хотын дүүрэг
Дорноговь	Замын Үүд <i>n=100</i>		
Хөвсгөл	Мөрөн <i>n=143</i>	Хатгал <i>n=60</i>	Алаг-Эрдэнэ <i>n=17</i>
Сэлэнгэ	Мандал <i>n=120</i>		
Улаанбаатар			Баянзүрх <i>n=160</i>

Туршилт судалгааны 2-р шатанд нэмэгдсэн хоёрдахь зүйл бол хувиараа хөдөлмөр эрхлэгч бизнесийн нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл цуглуулах хувилбар аргуудыг туршсан явдал юм. Үүнд орлого, тайлан тэнцлийн хоёр төрлийн асуулгын хуудсыг боловсруулсан ба нэг нь товч асуулгын хуудас буюу нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийн талаар асуусан таван асуултаас бүрдэж, нөгөө нь дэлгэрэнгүй асуулга буюу нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг бүрдүүлэгч зүйлсээр нарийн задласан дэд ангиллыг агуулсан. Жишээ нь, зардлын хувьд товч асуулга ганц асуултыг оруулсан байхад дэлгэрэнгүй хуудсанд 10 асуултыг зардлын зүйл ангиар асуусан. Бизнесийн нарийн нийлмэл байдал нь ийм дэлгэрэнгүй асуулга авахаар хэмжээнд байгаа эсэхийг урьдчилан хэлэх боломжгүй байв. Тиймээс оновчтой чиг хандлагыг тодорхойлох үүднээс 3 хувилбарыг ашигласан. Орлого, тайлан тэнцлийн талаар шууд асуусан асуултууд бүхий асуулгын дэлгэрэнгүй хуудсыг 1-р хувилбараар, шууд асуултууд бүхий асуулгын товч хуудсыг 2-р хувилбараар, эмзэг болон тоогоор хариулах асуултын аль алины хувьд санамсаргүй хариултын протоколыг агуулсан товч хуудсыг 3-р хувилбараар бөглөсөн. 1, 2-р хувилбарын дагуу шууд асуултуудыг тавин, хариултуудыг нь дугтуйд хийлгүүлэн наалгаж байв. Туршилт судалгааны 1-р шатны үр дүнгийн талаарх тоологч нарын мэдээлэлд үндэслэн асуулгын хос асуултыг бөглүүлэх заавар, эрсдэлийг тодорхойлох болон бизнесийн тойм тайлбарыг бөглөх хэсгийг шинэчлэн боловсронгуй болгосон бөгөөд

хариултуудыг зөв ойлгон тайлбарлахад нийгмийн байр суурь, хандлага гүйцэтгэх үүрэг их гэдгийг харгалзан үзэж туршилт судалгааны 2-р хэсэгт энэ талаар илүү дэлгэрүүлж оруулсан.¹⁷

Туршилт судалгааны 2-р шатны нэн чухал үр дүн нь орлого, тайлан тэнцлийн хуудсыг загварчлахтай холбоотой байв. Үүнд товч асуулгын дүнг тооцон үзэхэд албан бус секторын хэмжээ үлэмж өндөр тооцогдсон байх ба хэрвээ 1-р аргыг суурь болгон авч үзвэл 50 хувиар хэтрүүлэн тооцох магадлалтай байв. Ингэж өндөр тооцогдсон нь товч асуулгад зардлын дүн бага гарсантай холбоотой. Зардлын жагсаалтыг асуулгын дэлгэрэнгүй хуудсанд оруулснаар хүмүүс гаргасан зардлуудаа санаж, бодитой бөглөх боломжтой байж болзошгүй.¹⁸

Туршилт судалгааны 2-р шатны дүнд үндэслэн тоологч нар судалгаанд хамрагдах ёстой хариулагчдыг зөв тодорхойлж, албан болон албан бус сектор дахь тэдний байр суурийг нэн даруй тодруулахуйц байдлаар асуулгын загварыг ихээхэн засварласан. Ингэснээр аль болох холбогдох бизнесийн эзний талаар хувийн шинж чанартай асуултуудыг авах боломжтой болсон. Түүнчлэн уг өөрчлөлт нь судалгааны гол объект байгаагүй албан секторт ажиллаж буй хариулагчтай хийх ярилцлагыг цаг сунжралгүй даруй дуусгаж, зардал хэмнэх боломжтой болгосон. Тайлангийн дараачийн хэсэгт судалгааны асуулгын эцсийн хувилбарыг хэрхэн загварчилсан талаар дэлгэрэнгүй тайлбарлав.

Эцэст нь тэмдэглэхэд хэдийгээр түүврийн

¹⁷ Тайлангийн 2-р ботид судалгааны бүх хэрэгслүүдийн талаар танилцуулсан.

¹⁸ Аж ахуйн нэгжүүд зардлын зүйл анги ихтэй, харин орлогын эх үүсвэр бага байсныг харгалзан үзэж асуулгын дэлгэрэнгүй хуудсанд зардлын талаар нарийвчлан асуусан.

хэмжээ нь бага байсан ч туршилт судалгаануудыг явуулснаар бусад оронд ч, мөн цаг хугацааны хувьд ч ажиглагддаг¹⁹ орлогын хэвийн бус тархалт Монгол Улсад байгаа гэж дүгнэхэд хүргэсэн. Тиймээс гипотез турших, түүвэрлэлт хийх стандарт аргуудыг засварлан ашиглах хэрэгтэй бөгөөд ингэх нь тооцоо хийхэд чухал үр дагавартай тул эдгээр үр дагаврын талаар 4-р хэсэгт гаргасан тооцоог танилцуулахдаа, мөн 6.2-р хэсэгт эргэн авч үзлээ.

2.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Туршилт судалгааны дүнд үндэслэн дараахь 5 чиглэлээр 13 бүлэг бүхий судалгааны асуулгыг АБСӨС-д хэрэглэхээр боловсруулсан. Таван чиглэл нь 1) өрх нь албан бус секторт ажиллаж буй эсэхийг тодорхойлох, 2) хүн ам зүйн үндсэн мэдээлэл, түүнчлэн итгэх, итгэл даах чадвар, эрсдэл зэрэгт хандах хувийн болон нийгмийн хандлага, байр суурь, 3) албан болон албан бус секторт бизнес эрхлэгчдийн бизнес үйл ажиллагааг тодорхойлох, үүнд орлого, тайлан тэнцлийн дэлгэрэнгүй хуудас агуулсан, 4) бизнес эрхлэх институцийн тогтолцоо, орчны талаарх хандлага, зан үйл төсөөлөл ойлголт зэргийг тодорхойлох, 5) судалгааны үйл явцын талаарх үнэлгээ, хариу мэдээлэл зэрэг болно. Хүснэгт 2.2-т 13 бүлгийн талаар дэлгэрэнгүй мэдээлж, бүлэг тус бүр ямар зорилготой, хэн хариулах, ямар асуулт асуусан талаар тайлбарласныг үзнэ үү. Асуултын төрлүүд асуулга авах арга бүрт өөр тул нийт хариулагч бүх асуултын төрлийн талаар мэдэх боломжгүй юм. Жишээ нь 8, 10-р бүлэгт санамсаргүй хариултын хоёр төрлийн асуултыг аль нэгийг, эсвэл хоёуланг нь агуулсан ба энд хос асуултын аргыг Q, үржүүлэх аргын асуулт M гэж тэмдэглэв. Гэхдээ энэ бүлэгт хамрагдсан хариулагчдын зарим нь шууд асуултанд (D) хариулсан, эсвэл шууд асуултны хариултыг

дугтуйнд (E) хийж өгсөн. Түүнчлэн Q, M асуултны хариултуудыг дугтуйнд хийж өгч байсан. Харин туршилтын бага хэмжээний түүвэрт M асуултанд амаар хариулж байв (4-р арга). Асуулга авах аргуудын талаар доор танилцуулсан ба энэ нь Хүснэгт 2.3-тай холбоотой.

Асуултын төрлүүд нь хариулагчийн мэдээллийн нууцлалыг янз бүрийн түвшинд чандлан хамгаалах зориулалттай боловсруулагдсан. Ер нь судалгааг боловсруулахдаа хариулагч нь үндсэн хоёр шалтгааны улмаас өөрийнхөө мэдээллийн нууцлалыг хадгалах сонирхолтой байж болзошгүй гэж үзсэн. Тоологчтой шууд ярилцах үеэр хариулагч нь хууль дүрэм мөрдөөгүй, зөрчсөн тухайгаа хэлэх хүсэлгүй байж болзошгүй. Түүнчлэн өгсөн мэдээллийг нь хууль хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн хариуцлагатай албан тушаалтанд өгч болзошгүй гэж сэрэмжилсэн байж болох юм. Мэдээж ингэж сэрэмжилэх нь асуулт бүрийн агуулгаас хамаарч харилцан адилгүй байж болзошгүй ба бид аль нэгнээс, эсвэл хоёулангаас нь хамгаалах, эсвэл огт хамгаалахгүй хэлбэрээр хувилбар аргуудыг боловсруулсан ба ингэснээр цаашид уг аргачлалыг боловсронгуй болгоход хэрэгцээтэй мэдээлэл цуглуулсан. Асуултын төрлийн талаар илүү нарийн авч үзье. Үүнд:

- Шууд асуултууд (D) судалгааны стандарт асуултууд байх ба хувилбар сонголтын үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийхэд харьцуулах суурь болж өгдөг. Хариулагч асуултанд амаар хариу өгч, хариулагч, тоологч хоёулаа хариултын талаар мэдээлэлтэй байна гэсэн үг.
- Дугтуйн асуултанд (E) хариулагч бичгээр хариулж, хариултыг дугтуйнд хийж наана. Иймд тоологч хариултын талаар мэдэх боломжгүй, харин дүн шинжилгээ хийх хүнд очих тул эдгээр хариултыг дүгнэн шинжлэх арга нь шууд асуултынхтай нэгэн адил.

ХҮСНЭГТ 2.2 Асуултын бүлгүүд

Бүлэг	Зорилго	Хариулагч	Асуултын төрөл
1. Танилцуулга, нүүр хуудас	Тоологч өөрийгөө танилцуулж, судалгааны зорилгын тухай тайлбарлана.	Бүгд	D

¹⁹ Жигд зөв хуваарилалтын талаар харилцан адилгүй онол, хандлага байдаг ч Парето, Логнормалын хуваарилалтын онол нэлээд анхаарал татдаг.

ХҮСНЭГТ 2.2-ын үргэлжлэл

2. Ялган ангилах	Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодруулж, ямар асуултуудыг хариулах ёстойг нь тодорхойлох, эсвэл судалгаанаас хасах	Бүгд	D
3. Нийгэм эдийн засгийн байдал	Эдийн засгийн бодлогод ямар хариу зан үйлдэл хийж байгаад дүн шинжилгээ хийх	Ярилцлаганаас хасагдсан хэсгийн дараа үлдсэн бүх хариулагчид	D
4. Нийгмийн байр суурь, хандлага	Эдийн засгийн бодлогод ямар хариу зан үйлдэл хийж байгаад дүн шинжилгээ хийх	Ярилцлаганаас хасагдсан хэсгийн дараа үлдсэн бүх хариулагчид	D, E
5. Эрсдэлтэй холбоотой байр суурь, хандлага	Эдийн засгийн бодлогод ямар хариу зан үйлдэл хийж байгаад дүн шинжилгээ хийх	Ярилцлаганаас хасагдсан хэсгийн дараа үлдсэн бүх хариулагчид	D
6. Энгийн асуултууд	“Хос асуултын” аргад хариулах түүврийг тодорхойлох	1, 2, 4-р хувилбар (10-р бүлэгт хос асуултын аргад хариулаагүй хариулагчид)	D
7. Үйл ажиллагааны тодорхойлолт	Бизнес үйл ажиллагаа, түүний төлөв байдлыг тодорхойлох	Бүх ажил эрхэлж буй хүн (хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг илүү дэлгэрэнгүй судлана)	D
8. Орлого, тайлан тэнцлийн хуудас	Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн үндсэн үйл ажиллагааны талаарх санхүүгийн мэдээлэл авах	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	D, E, M
8а. Салбарын талаарх тодорхой асуултууд	Алт олборлолт, аялал жуулчлал, ноолуурын үйлдвэрлэлийн талаар мэдээлэл авах	Тухайн салбарт ажиллагсад	D, E, M
9. Эмзэг асуултууд (бага зэргийн)	Бизнес бүртгэл, татвар, бодлогын талаар асуух	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	D, E
10. Эмзэг асуултууд (их)	Хахууль, хууль бусаар бараа хил давуулах, татвар төлөлт, өрхийн орлогын талаар асуух	Бүх ажил эрхэлж буй хүн (хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг илүү дэлгэрэнгүй судална)	D, E, Q, M
11. Хариулагчийн үнэлгээ, хариу мэдээлэл	Асуулт, асуулгуудыг ойлгосон эсэх, хэрхэн үнэлж буй талаар	Ярилцлаганаас хасагдсан хэсгийн дараа үлдсэн бүх хариулагчид	D, E
12. Хариулагчид урамшуулал өгөх	Хариулагчид урамшуулал өгч, өрхийг орхин явах	Ярилцлаганаас хасагдсан хэсгийн дараа үлдсэн бүх хариулагчид	D
13. Тоологчийн үнэлгээ, хариу мэдээлэл	Хариулагчийн талаарх үнэлгээ, хариултуудыг бүрэн бөглөх	Ярилцлаганаас хасагдсан хэсгийн дараа үлдсэн бүх хариулагчид	D

D=шууд, E=дугтуй, M=үржүүлэгч, Q-хос асуулт. Дэлгэрэнгүй тайлбарын дор 8-р хэсгээс үзнэ үү.

- Үржүүлэгч (M) асуултыг тоон мэдээлэл авахад ашигладаг бөгөөд хариултыг авахдаа алдаа оруулж өгсөнөөр түүнийг санамсаргүй болгодог арга юм. Энэ аргыг орлого, тайлан тэнцлийн талаар асуухад хэрэглэсэн ба хариулагч нь шоог тоологчид харуулалгүй хаяж орлого, тайлан тэнцлийн жинхэнэ бодит хэмжээгээ шооны нүхэнд буусан тоогоор үржүүлнэ. Жинхэнэ хариулт ямар байсныг тоологч, дүн шинжилгээ хийгч нарын аль аль нь мэдэх бололцоогүй тул мэдээллийн нууцлал хадгалагдана. Тухайн хариултын хувьд нийт олонлогийн дунджийг тухайн үржүүлэгчийн статистик чанарууд дээр үндэслэн тооцож гаргадаг. Үржүүлэх аргын асуултанд хоёр хэлбэрээр хариулж болно. Үүнд M^D -н хувьд хариулагч үржүүлээд гарсан дүнгээ тоологчид хэлж өгөх, M^E -н хувьд үржүүлээд гарсан хариуг нь дугтуйд хийж наана. Хавсралт 1-д энэ протоколын талаар нэмэлт мэдээллийг танилцууллаа.
- Хос асуултын (Q) хувьд институцийн бүтцийн талаарх бүлэгт “тийм/үгүй” гэсэн хоёр хариулттай эмзэг асуултад хариу авахад ашигласан. Энэ аргын хувьд хариулагчид нь эмзэг эсвэл энгийн, тухайлбал “Та хөгжим тоглож чаддаг уу?” зэрэг асуултын аль нэгэнд санамсаргүй байдлаар хариулна. Бид Q асуултыг хариулагч эмзэг асуултанд хариулах магадлал 50 хувьтай тэнцэхээр сонгож авсан. Үржүүлэх аргатай нэгэн адил шоо орхин аль асуултад хариулахыг шийдэх ба шооны дүнг тоологчид харуулалгүйгэр тохирох асуултын хариуг бичиж дугтуйнд хийж наана. Хавсралт 1-д энэ протоколын талаар нэмэлт мэдээллийг танилцууллаа.

Хүснэгт 2.3-т харуулсанчлан асуултын төрлүүдийг бид таван хувилбар байдлаар янз бүрээр хослуулан хэрэглэсэн.²⁰ Үүнд орлого, тайлан тэнцлийн хуудсыг бөглүүлэхэд асууж буй

асуулт, мөн зан үйлийн талаар асууж буй эмзэг асуултыг заасан хоёр үсгээр хувилбараа тодорхойлсон. 1-р асуулга авах хувилбарын (DD) хариулагч тоологчид шууд амаар хариулах бөгөөд мэдээллийг нууцлахгүй суурь хувилбар болж өгч байгаа. 2-р хувилбар (EE) хариулагч эмзэг асуултанд өгөх хариултаа бичиж дугтуйнд хийх замаар мэдээллийг нууцална. 3-р хувилбар (EQ) хоёр хариултын нэгийг сонгох эмзэг асуултын хувьд мэдээллийн нууцлалыг нэмэлт байдлаар хадгална. 4-р хувилбар (M^DE) үржүүлэх аргын асуултад шууд хариулуудыг авч, 5-р хувилбар (M^EE) бүх эмзэг асуултуудад шоо орхин хариулуудыг тоологчид харуулалгүйгээр дугтуйнд хийж наах замаар мэдээллийн нууцлалыг дээд зэргээр хамгаална.

Судалгааны асуулга авах хэд хэдэн хувилбаруудыг боловсруулах нь хариулагчийн мэдээллийн нууцлалыг хадгалахад хэр их нөлөөтэй байгааг судалж мэдэх нь бидний гол сонирхол байсан ч уг судалгааны хувьд хувилбарууд нь дүн шинжилгээ хийх ажлыг уян хатан болгох ач холбогдолтой байв. Санамсаргүй хариултын аргаар цуглуулсан мэдээллийг хувь хүмүүс хариулагчидтай холбох боломжгүй харин нийтэд нь нэгтгэж тооцдог тул шууд асуулт, хариултын замаар мэдээлэл цуглуулах аргыг бодвол нийт хүн амд тооцсон дүнг гаргах талаар хавьгүй давуу талтай байдаг. Гэхдээ хувь хүмүүс, хариулагчдын үйл ажиллагаа, үйлдлийг институцийн бүтцийн орчинтой уялдуулан судлах зэрэг бодлогын дүн шинжилгээ хийхэд санамсаргүй хариултын арга тохиромжтой бус байдаг. Иймд хийх дүн шинжилгээнээс хамааран төрөл бүрийн асуултуудыг сонгосноос үүдэх давуу талыг ашиглах боломжийг эдгээр хувилбарууд бий болгож байгаа тул нарийвчлал, нууцлалыг хамгаалах болон түүврийн хэмжээтэй холбоотой хязгаарлалтуудыг зохистой түвшинд хүргэж байгаа юм.

²⁰ Хүснэгт 2.3-т үзүүлсэн хувилбаруудын түүврийн хэмжээ нь 5,111 хариулагч (цалинтай хүмүүс болон ажилгүйчүүд)-г хассаны дараахь тоо ба албан бус секторын сүүдэр эдийн засгийн хэмжээг тооцоход эдгээр хариулагчид хувь нэмэр оруулаагүй болно. Гэхдээ зарим цалинтай болон ажилгүй хүмүүсийг харьцуулсан судалгаа хийх үүднээс үлдээсэн болно. Хасах протокол болон түүний түүврийн жинд нөлөөлөх байдлыг 3-р бүлэгт авч үзсэн болно.

ХҮСНЭГТ 2.3 Хувилбарууд, асуултын төрлүүд

Хувилбарууд	Тоон	Хоёр хариулттай	Түүврийн хэмжээ
1	Шууд	Шууд	300
2	Дугтуй	Дугтуй	2301
3	Дугтуй	Хос асуулт	2001
4	Үржүүлэгч/М ^d /	Дугтуй	300
5	Үржүүлэгч/М ^c /	Хос асуулт	8998

Олон хувилбаруудаар цуглуулсан мэдээллийг нэгтгэж ашиглах нь албан бус секторын сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааг бодитой тооцох боломжийг олгохоос гадна нөгөө талаар эмзэг асуултад өгсөн хариултыг

хариулагчийн байдалтай уялдуулан бодлогын дүн шинжилгээ хийх боломжийг ч олгодог. Хэрвээ үржүүлэх аргын болон хос асуултын хоёр аргыг ашигласан бол бодлогын ийм дүн шинжилгээг хийх боломжгүй байдаг.

БҮЛЭГ 3

Түүвэрлэлт



Түүвэрлэлт

Энэ хэсэгт Албан Бус Секторын Өрхийн Судалгааны түүвэрлэлтийг сонгох үйл явцын талаар тайлбарлав. Түүвэрлэлтийг хийхдээ нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг i) Монголын дөрвөн бүс нутаг, Улаанбаатар хотоор, ii) улсын түвшинд хот, хөдөөгөөр, iii) цөөн тооны тодорхой эдийн засгийн салбараар тооцоход хүрэлцэхүйц тоо, тархалт бүхий өрхийг түүвэрлэн авах зорилгыг агуулсан.

Статистикийн эмхтгэлд хэвлэгддэг Өрхийн Орлого Зарлагын Судалгаа (ӨОЗС)-ны орлогын тоо мэдээ, 2002-2003 оны Ажиллах Хүчний Судалгаагаар (АХС) бүсийн түвшинд тооцсон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувийн жин, Сангийн Яамнаас авсан сумын түвшинд лиценз эзэмшин үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт, 2002 оны өрхийн түүврийн хүрээ, 2004 оны 6-р сард явуулсан АБСӨС-ны туршилт судалгааны 2-р шатны тоо мэдээ зэргийг ашиглан түүврийн хэмжээ, тархаалтыг төлөвлөв.

Өрхийн жагсаалтаас түүвэрлэн авсан олон тооны өрхүүд сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх магадлал багатай ба энэ асуудлыг харгалзан үзэж ийм өрхүүдийн дийлэнхийг судалгаанаас даруй хасах судалгааны протоколыг оруулж өгсөн. Түүнчлэн энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс Сангийн яамнаас хөтөлдөг лицензийн бүртгэл мэдээлэлд үндэслэн сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааны тархаалтыг тооцоолон, түүнд үндэслэн түүвэрлэгдэх магадлалыг гарган авах аргыг ашигласан. Албан бус секторын хуулийн дагуу бүртгэлд хамрагдсан иргэд (патент эзэмшигчид)-ийн дундаж тоо болон өрхийн тоонд үндэслэн аймаг, сумын түвшин дэх хэмжээг тодорхойлов. Түүврийн хэмжээг хамгийн бага зардлаар өргөтгөх, түүнчлэн зохих тооны албан бус секторын бизнес эрхлэгчдэд хандах боломжтой байхаар хасалт хийх протоколыг нарийвчлан боловсруулсан ба энэ талаар дор тайлбарлав.

Мал аж ахуйн бус албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хамрах хүрээг тооцохдоо эхний байдлаар “нэмэх” эсвэл “хасах” 5 хувийн нарийвчлалтай байхаар түүвэрлэлтийн төлөвлөгөөг боловсруулсан.²¹ Гэхдээ үр дүнгийн нарийвчлалын энэ түвшинд судалгааны дүнг тооцоход шаардлагатай түүврийн хэмжээ нь албан бус секторт ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийн нэмэгдэл өртгийн үйлдвэрлэл дэх вариациас хамаардаг. Статистикийн эмхтгэлд хэвлэгдэж гардаг ӨОЗС-ны тоо мэдээ нь байршлаар тооцсон өрхийн орлогын дундаж дүнг харуулдаг болохоос вариациар тооцсон дүнг үзүүлдэггүй. ӨОЗС-д орлогын дүнгийн вариацийн тооцоо харамсалтай нь байгаагүй. Иймд бид бусад орны тоо мэдээ болон практик таамаглалд үндэслэн вариацийг тооцож гаргасан. Ийм ч учраас судалгааны үр дүнгийн нарийвчлалын талаар тодорхой хэлэх боломжийг ихээхэн хязгаарласан. Хэрвээ бидний тооцсон вариаци бодит утгаас бага гарсан байх юм бол үр дүнгийн нарийвчлал доогуур байна. Харин бодит утгаас дээгүүр тооцогдож гарсан бол үр дүнгийн нарийвчлал өндөр болохоор байгаа ч энэ тохиолдолд судалгааны зардал шаардлагатай хэмжээнээс их байж болзошгүй.

3.1. ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООСОН НЬ

Судалгааны мэдээллийг Баруун, Хангай, Зүүн, Төвийн дөрвөн бүс нутаг, Улаанбаатар хот, мөн аймгийн төв, Улаанбаатар хот, сумын төв, хөдөө гэсэн дөрвөн байршлаар цуглуулаа. ҮСГ-аас мөрдөж буй ангиллын дагуу Улаанбаатар хот нь “бүс нутаг”, “байршил”-ын аль алинд нь хамрагдаж байгааг тэмдэглэе. Хавсралт 2-т эдгээр бүс нутаг, байршлуудын газрын зургийг өгөв.

Түүврийн хэмжээг тогтоохын тулд ӨОЗС болон АБСӨС-ны туршилт судалгааны дүнг аль алийг нь тусад нь ашигласан. Энэ хоёр аргаар түүврийн хэмжээг тооцоход сумын төв, аймгийн төвүүдэд нэлээд ойролцоо дүн гарч, харин хөдөө

²¹ Монгол улсад ажиглагдсан орлогын хуварилалтан дахь хэвийн бус байдлыг тооцохын тулд зарим өөрчлөлт, тодотголыг хийх шаардлагатай.

орон нутаг, Улаанбаатар хотын хувьд өөр зөрүүтэй дүн гарсан. АБСӨС-ны туршилтанд хамрагдсан өрхийн тоо ялангуяа хөдөөд цөөн байсан тул өрхийн түүврийн хэмжээг ӨОЗС-ны тоонд үндэслэн хийв. Гэхдээ ӨОЗС-ны тоог зөвхөн байршлаар гаргасан тул бүсийн ялгааг нэмж тооцох шаардлагатай болсон ба АХС-ны тоог ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэлт дэх бүсийн вариацийг тооцлоо. Энэ нэмэлт өгөгдлийг ашигласан нь түүврийг бүс нутгаар жигд бус тархаахад хүргэсэн. Түүнчлэн дөрвөн байршлаар түүврийн тархаалтыг хийхдээ АБСӨС-ны туршилт судалгааны дүнтэй харьцуулан шалгасны үндсэн дээр АХС-ны тоо мэдээг ашиглав (хувиараа хөдөлмөр эрхлэгчтэй өрхтэй харьцсан хувь хэмжээнд үндэслэн).

Хувиараа хөдөлмөр эрхлэлтэнд хэлбэлзэл их байгаа тул АХС-ны тоо мэдээг ашиглан хийсэн хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааны тооцоо түүврийн бүтцэд нэлээд нөлөөлсөн. Тухайлбал, Улаанбаатар хот дахь нийт ажил эрхлэгчдийн зөвхөн 22% нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байгааг харгалзан нийслэл хотын түүврийн хэмжээг харьцангуй томоор авах шаардлагатай байв. Харин АХС-ны тоо мэдээнээс үзэхэд бусад бүс нутагт хувиараа хөдөлмөр эрхлэгчид нийт ажил эрхлэлтийн 55-78%-ийг эзэлж байгаа аж. Ийнхүү хувиараа хөдөлмөр эрхлэлт бүс нутгаар их хэлбэлзэж байгаа нь бүсүүдийн хот, хөдөөгийн харьцаа ялгаатай байгаагаас гол төлөв хамааралтай байна. Тухайлбал, АХС-ны тооцоогоор хөдөөд хувиараа хөдөлмөр эрхлэлт бараг 95 хувьтай байхад аймгийн төвд энэ тоо

Улаанбаатар хотынхтой илүү ойролцоо, бага зэрэг өндөр байна. Бизнесийн үйл ажиллагаа нь илүү жигд, өөрөөр хэлбэл мал аж ахуй зонхилон буй хөдөө орон нутагт орлогын вариаци бага байна гэж бид үзэв. Ийнхүү хувиараа хөдөлмөр эрхлэлтийн түвшин болон хүлээгдэж буй орлогын хэлбэлзэл зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр аймгийн төв, Улаанбаатар хотод түүврийн жинг ихээр авсан.

Тодорхой бүс нутаг, байршлаар түүврийн хэмжээг тогтооход дараахь томъёог ашиглав. Үүнд:

$$n_{ij} = z_{ij} * I * \frac{1}{c_{ij}}$$

Үүнд $i=l, \dots, 5$ болон $j=l, \dots, 4$ нь бүс нутаг, байршлыг тус тус илэрхийлнэ. z_{ij} нь орлогын вариацийг тооцсон дүнд үндэслэн гаргасан анхдагч түүврийн хэмжээг илэрхийлэх бөгөөд хязгаарт олонлогийн засварыг агуулсан. I гэдэг нь санамсаргүй хариултын үржүүлэх аргыг ашиглахад үүсэх алдааг засварлах инфляцийн хүчин зүйл бөгөөд утга нь 1.3 байна.²² c_{ij} нь хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхүүдийг хамарсан түвшинг илэрхийлэгч бөгөөд хот суурин газарт 0.32-0.37, сумын төвд 0.6-0.7, хөдөөд 0.89 гэсэн утгатайгаар ашигласан ба утгын зөрүү нь АХС-ны дүнтэй холбоотой. Хөдөөгөөс бусад газарт энэ тоо нь АХС-ны хувиараа ажил эрхлэлтийн түвшингээс өндөр байхаар авсан. Нэгээс илүү ажилтантай олон өрх байгааг тусган энэ тоог ингэж өндөр байхаар авсан. Хүснэгт 3.1-д түүврийн хэмжээг бүс нутаг, байршлаар тооцож гаргасан дүнг харуулав.

ХҮСНЭГТ 3.1 Түүврийн хэмжээ, тархаалт

Бүс нутаг	Байршил				Тархаалт бүс нутгаар			
	Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Бүгд	Түүврийн эзлэх хувь	Патент эзэмшигчдийн эзлэх хувь	Өрхийн эзлэх хувь
Баруун	-	1,632	479	198	2,309	0.12	0.08	0.17
Хангай	-	2,910	520	265	3,695	0.20	0.16	0.23
Төв	-	2,324	733	364	3,421	0.18	0.23	0.19
Зүүн	-	964	272	99	1,335	0.07	0.05	0.09
Улаанбаатар	8,251	-	-	-	8,251	0.43	0.47	0.30
Нийт	8,251	7,830	2,004	926	19,011	1.00	1.00	1.00

²² Өөрөөр хэлбэл үржүүлэх асуултын аргаар мэдээлэл цуглуулахад шууд асуултын аргаар мэдээлэл цуглуулахад шаардлагатай түүврийн хэмжээнээс даруй 30 хувиар их байх ёстой гэсэн үг. Шууд асуултын арга нь өрөөсгөл дүн тооцоо гаргадаг.

3.2. ТҮҮВРИЙН СОНГОЛТ

Түүврийн анхдагч нэгжээр бүс нутгаас аймаг, Улаанбаатар хотоос дүүргүүдийг сонгосон. Аймаг дотроо аймгийн төв, сумын төв, хөдөөг Хүснэгт 3.1-д тооцсон хэмжээгээр түүвэрлэн авсан ба аймаг, сум, Улаанбаатар хотын дүүргүүдийг хэрхэн сонгож авсан талаар дор тайлбарлав. Өрхийг эцсийн байдлаар өрхийн шинэчилсэн жагсаалтыг ашиглан газар дээр нь сонгосон, гэхдээ уг сонголтыг бага зэрэг ялгаатай байдлаар хийсэн. Тухайлбал, Улаанбаатар хотын өрхийг сонгохдоо системчилсэн түүвэрлэлтийн аргыг ашигласан бол зарим аймагт багийг сонгохдоо хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглаад дараагаар нь багуудаас өрхийг системчилсэн түүврийн аргаар сонгосон. Газар зүйн хувьд боломжтой тохиолдолд тухайн баг дахь өрхийн төвлөрлийг багасгах үүднээс хэд хэдэн багийн хувьд системчилсэн түүвэрлэлтийг хийсэн.

Аймгуудын сонголт

Таван бүс тус бүрийн сонгогдох магадлал нэгтэй тэнцүү. Бүс бүрээс сонгох аймгийн тоо нь Хүснэгт 2.3-т тооцсон нийт түүврийн хэмжээнээс

хамааралтай байсан ба нийт 9 аймгийг сонгосон. Үүнд Баруун бүсээс хоёр, Хангай, Төвийн бүсээс тус бүр хоёр, Зүүн бүсээс нэг аймгийг сонгов. Аймгуудын сонгогдох магадлал нь лиценз эзэмшигчдийн болон өрхийн тооны эзлэх хувийн дундаж дүн байв. Хүснэгт 3.2-т сонгогдсон бүс нутаг, аймгийг сонгогдох магадлал болон өрхийн тооны эзлэх хувийн хамт танилцуулж байна.

Бүс дэх аймгуудыг сонгохдоо тухайн бүс нутаг дахь өсөн нэмэгдэх магадлал болгон хувиргасны дараахь сонгогдох магадлалтай холбоотойгоор санамсаргүй тоо гарган ашигласан. Үүнийг илүү ойлгомжтой болгохын тулд жишээ болгон Хүснэгт 3.2-т үзүүлсэн 1-р бүсийн сонгогдох магадлалын хувь хэмжээг ашиглая. Өсөн нэмэгдэх магадлалын аргаар хэрвээ санамсаргүй сонгосон тоо 0-0.29-т хэлбэлзэж байвал Баян-Өлгий аймгийг, 0.29-өөс 0.45-ын хооронд байвал (өөрөөр хэлбэл 0.29+0.16) Говь-Алтай аймгийг сонгоно. Өсөн нэмэгдэх магадлал болон аймгийг сонгох санамсаргүй арга хэрэгслийг хавсралт Excel-н хүснэгтээс үзнэ үү. Нэг бүс нутгаас нэгээс илүү тооны аймаг сонгосон тохиолдолд орлуулах аймгийг нөөцлөхгүй.

ХҮСНЭГТ 3.2 Аймгуудын сонголт, бүс нутгаар

Бүс нутаг 1: Баруун				
Аймаг	Аймгийн код	Ажиглалтын тоо	Сонгогдох магадлал	Сонголт
Баян-Өлгий	2	0	0.29	0
Говь-Алтай	5	0	0.16	0
Ховд	16	0	0.11	0
Увс	15	1000	0.21	1
Завхан	9	1000	0.23	1
Бүс нутаг 2: Хангай				
Аймаг	Аймгийн код	Ажиглалтын тоо	Сонгогдох магадлал	Сонголт
Архангай	1	1000	0.17	1
Баянхонгор	3	0	0.13	0
Булган	4	0	0.12	0
Хөвсгөл	17	1000	0.15	1
Орхон	21	1000	0.27	1
Өвөрхангай	10	0	0.17	0

ХҮСНЭГТ 3.2-ын үргэлжлэл

Бүс нутаг 3: Төв				
Аймаг	Аймгийн код	Ажиглалтын тоо	Сонгогдох магадлал	Сонголт
Дархан-Уул	19	0	0.28	0
Дорноговь	6	933	0.20	1
Дундговь	8	0	0.07	0
Говь-Сүмбэр	22	0	0.03	0
Өмнөговь	11	933	0.09	1
Сэлэнгэ	13	0	0.18	0
Төв	14	934	0.16	1

Бүс нутаг 4: Зүүн				
Аймаг	Аймгийн код	Ажиглалтын тоо	Сонгогдох магадлал	Сонголт
Дорнод	7	0	0.30	0
Хэнтий	18	0	0.29	0
Сүхбаатар	12	1000	0.40	1

Сумдын сонголт

Аймаг дотроос аймгийн төв, сум, хөдөөгийн өрхүүдийг сонгосон. Аймгийн төвүүдийг сонгох магадлал нэгтэй тэнцүү байхаар, мөн нэмэлт гурван сумдыг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар аймгийн сонголтонд тайлбарласан жинг ашиглан тооцож сонгосон. Хүснэгт 3.3-т санамсаргүй сонгогдсон сумдыг бүх

бүсээр харуулав. Аймгийн төвөөс бусад сумдын хувьд түүвэрлэгдэх магадлалт жин нь өрх, лиценз эзэмшигчдийн жингийн дундаж дүн байв. Сонгогдсон аймгийн төвийн хувьд магадлалт жин 1.00-тэй тэнцүү. Сонгогдсон сумдын хувьд Хүснэгт 3.3-т мөн нийт өрхийн тоо, түүврийн хэмжээ, сонгогдох магадлалыг үзүүлэв.

ХҮСНЭГТ 3.3 Сумдын сонголт, бүс нутгаар

Бүс = 1, аймаг = Увс				
Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Ховд	16	651	100	.0465958
Тэс	15	1485	100	.1122324
Цагаанхайрхан	18	763	100	.0728422
Улаангом	19	5910	700	1

Бүс = 1, аймаг = Завхан				
Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Тосонцэнгэл	4	2073	133	.2403779
Идэр	7	823	122	.0387218
Цэцэн-Уул	20	564	121	.0407083
Улиастай	18	4117	932	1

ХҮСНЭГТ 3.3-ын үргэлжлэл

Бүс = 2, аймаг = Архангай

Сумын нэр	дундаж (сумын код)	дундаж (нийт өрх)	дундаж (ажиглалт)	дундаж (сонг. магад)
Эрдэнэбулган	18	4150	700	1
Эрдэнэмандал	6	1725	100	.1034546
Хашаат	13	1028	100	.0423621
Өлзийт	11	986	100	.0388192

Бүс = 2, аймаг = Хөвсгөл

Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Мөрөн	22	7919	955	1
Рэнчинлхүмбэ	9	1068	121	.0440513
Тариалан	10	1457	123	.0792718
Цэцэрлэг	18	1272	125	.0608465

Бүс = 2, аймаг = Орхон

Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Баян-Өндөр	1	18322	1265	1
Жаргалант	2	821	106	.668911

Бүс = 3, аймаг = Дорноговь

Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Айраг	1	881	100	.1021206
Эрдэнэ	12	660	100	.0638731
Сайншанд	13	4552	634	1
Замын-Үүд	14	1703	100	.3965035

Бүс = 3, аймаг = Өмнөговь

Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Даланзадгад	15	3417	830	1
Ханбогд	10	585	117	.1503803
Ханхонгор	11	741	147	.1017098
Номгон	7	755	142	.1025376

ХҮСНЭГТ 3.3-ын үргэлжлэл

Бүс = 3, аймаг = Төв				
Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Алтанбулаг	1	822	135	.0389175
Эрдэнэсант	26	1425	123	.0588547
Заамар	17	1389	133	.0898976
Зуунмод	27	3301	861	1

Бүс = 4, аймаг = Сүхбаатар				
Сумын нэр	Сумын код	Нийт өрх	Ажиглалт	Сонгогдох магадлал
Баруун-Урт	13	3444	864	1
Эрдэнэцагаан	11	1339	122	.1217302
Мөнххаан	4	1096	120	.1205302
Уулбаян	9	880	129	.0857333

Улаанбаатар дахь сонголт

Улаанбаатар хотод мөн л хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглан дүүргүүдийг сонгов. Есөн дүүргийн зургаад нь нийт 5.100 ажиглалт хийхээр сонгон

авсан ба дүүрэг тус бүрд 850 ажиглалт ногдож байна. Шинэчилсэн өрхийн жагсаалтаас системчилсэн түүврийн аргаар дүүргүүдийн өрхийг сонгон авсан.

ХҮСНЭГТ 3.4 Дүүргүүдийн сонголт

Сонгогдсон сумын нэр	Өрхүүд	Ажиглалт	Магадлал	Жин
Багахангай	700	0	0.01	0
Багануур	5,476	0	0.03	0
Баянгол	31,393	1,356	0.15	1
Баянзүрх	35,682	1,388	0.19	1
Чингэлтэй	26,285	1,362	0.22	1
Хан-Уул	16,368	1,399	0.08	1
Налайх	5,469	0	0.02	0
Сонгинохайрхан	35,208	1,384	0.17	1
Сүхбаатар	24,614	1,362	0.15	1

3.3. ТҮҮВРИЙГ НИЙТ ХҮН АМД ТАРХААСАН НЬ

Албан Бус Секторын Өрхийн Судалгаагаар (АБСӨС) цуглуулсан өгөгдөл мэдээллийг ашиглан бага хэмжээний сүүдэр үйл ажиллагааны хамрах хүрээ буюу хэмжээг улсын болон бүс нутгийн түвшинд түүнчлэн хот, хөдөөгөөр тооцон гаргав.

Иймд түүврийг нийт хүн амд (ерөнхий олонлогт) тархаан тооцоход өмнөх хэсэгт тайлбарласан сонгогдох магадлалууд чухал үүрэгтэй юм. Үнэндээ тухайн өрхийн сонгогдох магадлалын урвуу хэмжигдэхүүн нь уг ажиглалтын нийт олонлогт эзлэх хувийн жин юм. Жин нь ерөнхий

олонлогт тухайн ажиглалтын төлөөлж буй өрхийн тоотой ижил болохыг доорхи хэсгээг харна уу.

Загварчлалын арга

Загварчлалын аргын үндсэн зарчим нь өрхүүдийг санамсаргүй аргаар сонгон авч түүвэрлэлтэнд хамруулах явдал юм. Ингэснээр бүх өрх түүвэрлэгдэх тодорхой магадлалтай бөгөөд уг магадлал тэгтэй тэнцүү биш байгаа тохиолдолд олонлогийн бодит утга болон тэдний вариациудын тооцсон утга хазайлтгүй гардаг. Санамсаргүйн процедурыг ашигласнаар ерөнхий олонлогийн утгыг үр дүнгийн тодорхой мэдэгдэх нарийвчлалтайгаар ямар нэгэн нэмэлт нөхцөл тавилгүйгээр тооцож чадах юм.

Түүврийг ерөнхий олонлогт тархаан тооцоход сонгогдох магадлалууд чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүвэр дэх тухайн нэгжийн сонгогдох магадлалын урвуу хэмжигдэхүүн нь жин буюу тухайн нэгж хэдэн өрхийг төлөөлж байгааг үзүүлдэг гэж ойлгож болох юм. Дор дурьдсан томъёонд үндэслэн энэ судалгааны сонгогдох магадлал болон жинг тооцож гаргав.

Судалгааны түүврийн анхдагч нэгж нь бүс нутгаас хэмжээнд нь пропорциональ хамааралт түүврийн аргаар сонгогдсон аймгууд бөгөөд i бүс дэх j аймгийн сонгогдох магадлалыг дараахь томъёогоор тооцлоо:

$$P_{ij} = k_i \frac{n_{ij}}{n_i}, \text{ үүнд } n_i = \sum_{j=1}^J n_{ij}$$

Энэ томъёонд n_{ij} нь аймгийн хэмжээ, k_i нь бүс нутгаас сонгогдсон аймгуудын тоо (Хүснэгт 2.2-т үзүүлсэнчлэн сонгогдсон аймгийн тоо 1-3-ын хооронд хэлбэлзэж байна), J нь тухайн бүс дэх аймгуудын тоог илэрхийлнэ. Аймгийн хэмжээг сонгогдсон нэгж дэх өрхүүд болон бүртгэлтэй лиценз эзэмшигчдийн хувь хэмжээний дунджаар тодорхойлсон ба ингэснээр албан бус секторын үйл ажиллагаа илүүтэй эрхэлж буй гэж үзэж буй газруудын сонгогдох магадлалыг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэхийг зорив. Тиймээс аймгийн хэмжээг доорхи томъёогоор тооцов:

$$n_{ij} = \left(\frac{h_{ij}}{h_i} + \frac{r_{ij}}{r_i} \right) / 2$$

Үүнд h, r нь тухайн газар зүйн байршил дахь өрх, лиценз эзэмшигчдийн тоог илэрхийлнэ.

Аймагт аймгийн төвүүдийг 1-тэй тэнцэх магадлалаар сонгосон. Тэдний сонгогдох магадлал

нь P_{ij} буюу j аймгийг сонгох магадлалтай адил байна. Аймгийн төвийн бус сумын хувьд аймгуудын адил хэмжээнд нь пропорциональ хамааралт түүврийн аргаар сонгов. Сумдыг сонгох магадлал нь дараахь хэлбэртэй байна:

$$P_{ijk} = P_{ij} k_{ij} \frac{n_{ijk}}{n_{ij}}$$

Энэ нь аймгийн сонгогдсон нөхцөлд сумын сонгогдох магадлалыг илэрхийлэх бөгөөд сонгогдсон сумын тоо k_{ij} нь Орхон аймгаас бусдад нь 3-тай тэнцүү байна. Харин жижигхэн (хот маягийн) Орхон аймгийн хувьд төвөөс гаднах сум сонгоогүй болно.

Баг, өрхийн эцэслэн сонгогдох магадлал нь сум тус бүр дэх хөдөөгийн гэж тодорхойлогдсон багуудын тоо болон өрхийн шинэчилсэн жагсаалтан дахь өрхийн тооноос хамаарсан. Баг болон өрхийг сонгохдоо хоёр аргыг ашиглав. Үүнд тоологчдын баг шинэчлэгдсэн өрхийн жагсаалтнаас өрхийн бодит тоог нь авах боломжтой байгаа хөдөөгийн багуудыг хэмжээнд нь пропорциональ хамааралт аргаар түүвэрлэн авсан. Багийг сонгосны дараагаар системчилсэн түүврийн аргаар урьдчилан гаргасан тооны өрхийг сонгов. Хоорондоо ойрхон зайтай багуудын хувьд системчилсэн түүвэрлэлтийн аргыг тухайн багуудад нийтэд нь ашигласан. Сум бүрээс нийт 100 өрх сонгон авахаар төлөвлөсөн ба нийт есөн аймгийн зургаад нь 67 өрх нь сумын төвийнх, 33 нь хөдөөгийнх байв. Албан бус үйл ажиллагаа харьцангуй нилэнхүй бус Улаанбаатар хотод нэмэлт түүвэрлэлтийг түлхүү хийж өгсөн.

Магадлалын засварлалт

Ерөнхий олонлогийн талаар зөв дүгнэлт хийхийн тулд сонгогдох магадлалын хувьд хэд хэдэн засварлалт хийх шаардлагатай. Загварчлал болон түүврийн бус алдаанаас хамааран эдгээр засварыг хийх шаардлагатай болсон. Судалгааны зардлыг хэмнэх зорилгоор зарим өрхөөс мэдээлэл авахгүй хасах протоколтой холбоотойгоор судалгааны загвараас хамаарах засварлалтыг хийсэн. Үүнд цалин хөлстэй ажил эрхлэгчдийн төлөөллийг багасгаж судалгаанд хамруулсан тул ийм бүлгийн жинг хасагдсан хэсгийнх нь хувьд засварлан тооцов. Судалгааны анхны түүвэрт нийт цалин хөлстэй ажил эрхлэгч 3,818 өрх байсны 1,496 (39.18%-)г судалгаанаас шууд хасч, үлдсэн 2,322 өрхөөс судалгаа авсан. Тиймээс энэ бүлгийн өрх тус бүр нийт түүвэрт ойролцоогоор 1.64 өрхийг

төлөөлөх ёстойг бид мэдэж байгаа тул энэ 2,322 өрх тус бүрийн жинг оролцоогоор $\frac{3,818}{2,322} = 1.64$ дахин нэмэгдүүлж тооцох шаардлагатай.²³

Хасалтаас гадна судалгаа болон тодорхой зүйлд хариулаагүй тохиолдолд магадлалын засварлалтыг хийсэн. 1,496 өрхийг судалгаанаас хассанаас гадна 170 өрх асуулгад бүрэн мэдээлэл өгөөгүй, мөн бага тооны хариулагчид зарим асуултанд хариулаагүйгээс шалтгаалан хариулт бүрэн өгсөн бусад өрхийн жинг нийт олонлогийн дүнг төлөөлөхүйц хэмжээнд нэмэгдүүлж тооцов. Энд хэрэглэсэн аргын хувьд хариулаагүй өрхүүд нийт бүлгийнхээ хувьд хариулсан бүлгээс ялгаагүй гэдэг урьдчилсан таамаглалыг ашигласан.

Анхны судалгааны загварчлалын дагуу эдгээр засварлалтыг хийсний дараа шинэ түүврийн хэмжээг зохицуулах зорилгоор жинг засварлан тооцлоо. Хоёрдагч түүвэрт хийгдсэн бүхий л

хасалт нь цалин хөлстэй хүмүүс эсвэл ажилгүйчүүд байсан тул анхны түүврийнхтэй адил тэнцүү хувь хэмжээнд энэ хоёр бүлэг төлөөлөгдсөн гэж үзэж эдгээр бүлгийн анхны түүвэр дэх хариултыг өргөтгөсөн.

Магадлалын жинд хийсэн сүүлийн засварлалтыг хувилбаруудыг харьцуулахтай холбогдон гарах асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор хийв. Судалгааны жинг ашиглан олонлогийн дундаж болон нийт дүнд хувилбараас хамаарах харьцуулалтыг хийхэд тухайн хувилбар нийт олонлогийн дүнг төлөөлөхүйц байх хэмжээнд жинг өргөтгөх шаардлагатай байв. Үүнийг тухайн хувилбар тус бүр дэх жинг

$$\frac{19,011}{N_t}, t = 1, \dots, 5$$

хэмжээгээр үржүүлэх замаар хийсэн ба N_t нь t хувилбар дахь ажиглалтын тоо юм.

²³ Өрхүүдийн жингүүд нь харилцан адилгүй, судалгаанд хамрагдсан болон судалгаанаас хасагдсан өрхүүдийн дундаж жин хоорондоо бага зэргийн ялгаатай байсан тул цалин хөлстэй ажил эрхлэгч өрхүүдийн статистик тооцоонд 1.59 гэсэн илүү нарийвчилсан тооцоог ашиглана.

БҮЛЭГ 4

Албан бус болон сүүдрийн үйл ажиллагааны нэмэгдэл өртөг



Албан бус болон сүүдрийн үйл ажиллагааны нэмэгдэл өртөг

4.1. ТООЦООНЫ АРГАЧЛАЛ

АБСӨС-ны нэг үндсэн зорилт нь сүүдрийн эдийн засгийн хамрах хүрээ буюу хэмжээг тооцоход чиглэсэн билээ. Энэ хэсэгт албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хамрах хүрээг улс, бүс нутгийн түвшинд болон байршлаар, мөн ЭЗҮАОУСА-н нэг оронгийн түвшинд цөөн тооны салбаруудаар тооцож гаргасныг та бүхэнд толилуулав байна. 5.1-р хэсэгт сүүдрийн эдийн засгийн шинж чанар, үзүүлэлтүүдээр гаргасан нэмэлт дүнг танилцуулсан болно. НҮБ-аас зөвлөмж болгон (НҮБ 1993), ҮСГ-аас (2000) мөрдөж буй Үндэсний Тооцооны Систем (ҮТС) аргачлалын дагуу үндэсний орлогыг тооцох үйлдвэрлэлийн аргатай нийцсэн аргачлалаар албан бус секторын сүүдрийн эдийн засгийн нэмэгдэл өртгийг тооцлоо. НҮБ-ын судалгаагаар гаргасан албан бус секторыг тооцоход тавигдах шаардлага (Бекер, 2000)-ыг уг судалгааны өгөгдлийг цуглуулах зорилгуудад харгалзсан болно. Асуулгыг хэрэгжүүлэхээс өмнө ҮСГ-ын аргачлалын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан болно. Нийт нэмэгдэл өртгийг тооцохын тулд 9-р сард хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олсон хариулагчдаас бүгдээс нь орлого (*rev*), борлуулах барааны материалын (*inv*) болон үйлдвэрлэлийн орцын (*invin*) хугацааны эхний болон эцсийн дүн, мөн зардлын (*exp*) талаар асуусан ба хариулагчид бизнесийнхээ бүтээгдэхүүний өөрсдийн хэрэгцээний үнэцэнийг орлогын хамт мэдээлэхээр заавар авсан байсан. Зардлыг хамгийн бүрэн хэмжээнд тооцохын тулд хариулагчдаас долоон ангиллаар дүн мэдээг авсан. Үүнд (1) үйлдвэрлэл эрхлэх ба (2) дахин борлуулах зориулалтаар худалдаж авсан материалын зардал, (3) түлш, цахилгааны зардал, (4) байр, машин тоног төхөөрөмж, өөрөө явагч хэрэгслийн зардал, (5) тээврийн зардал, (6) мэргэжлийн үйлчилгээний зардал, (7) бусад зардал зэрэг орно. Бизнес аж ахуйн нэгж бүрийн сард үйлдвэрлэсэн нийт

нэмэгдэл өртгийг (*gval_add*) дараахь томъёогоор тооцов:

$$gval_add = \text{үйлдвэрлэл} - \text{завсрын хэрэглээ} = rev + inv - exp + invin \quad (4.1)$$

Үүнд үйлдвэрлэл = *rev* + *inv*, завсрын хэрэглээ = *exp* + *invin* байна. Доорхи хүснэгтүүдэд нийт нэмэгдэл өртгийг жилээр нэгтгэн тайлагнав.

Албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хамрах хүрээний дүнг жилээр нэгтгэн тооцохын тулд 2004 оны 9-р сарын тоо мэдээнд улирлын засварлалт хийсэн. Үүнд сарын дүнг жилийнх болгон хувиргахын тулд хариулагчид тухайн сарын дүнгээ бусад улирлынхтай харьцуулсан (q110) ба 9-р сард эерэг дүнтэй нэмэгдэл өртөгтэй байсан бол энэ асуултын хариултад үндэслэн улирлын засварлалтыг хийсэн. Харин нийт хариулагчдын 25.0 орчим хувь нь тэг эсвэл хасах хэмжээтэй нэмэгдэл өртөг 9-р сард гарсан гэж мэдүүлсэн бөгөөд энэ бүлгийн хувьд сарын дүнг тархах боломжгүй байсан тул шууд бус аргыг ашигласан. Түүнчлэн зарим хариулагчид нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийн дүнгээ маш өндөр тооцож гаргасан ба тэднийг өндөр нэмэгдэл өртгийн бүлэг гэж бид нэрлэлээ.²⁴ Энэ бүлгийн хувьд мөн шууд бус аргыг хэрэглэсэн болно. Энэ бүлгийг онцлож байгаа шалтгаан нь нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийн дүн өндөр гарсан төдийгүй орлого, зарлагын хуудсыг бөглүүлэхдээ хоёр аргаар мэдээлэл цуглуулж гаргасан дүнтэй нийцэхгүй байсан зэрэг нь эргэлзээ төрүүлсэн. Нэгдүгээр арга нь хариулагчдаас өрхийн орлогыг асууж жилээр дүнг нь тооцсон, хоёрдугаар арга нь нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг оруулалгүйгээр сарын орлогыг нь асууж, дүнг тооцсон болно.

Ихэнхи хариулагчдын хувьд дээрх гурван эх үүсвэрээс цуглуулсан дүнгүүд хоорондоо уялдаж байв. Тухайлбал нэмэгдэл өртгийн үйлдвэрлэл нь нэмэх хэмжээтэй гарсан гэж хариулагчдын дүнтэй бизнесийн орлогын дундаж дүнгийн харьцаа нь

²⁴ Энэ бүлгийн дүнгээс шалтгаалж нэмүү өртгийн үйлдвэрлэлийн хуваарилалт хэвийн бус тархалттай гарсан.

ойролцоогоор 1.10 байв. Энэ харьцаа өрхийн сарын дундаж орлогын хувьд 1.18 байсан. Харин нэмэгдэл өртгийн үйлдвэрлэл маш өндөр тооцогдож гарсан хариулагчдын хувьд энэ харьцаа тус бүр .31, 7.2 байсан нь нэмэгдэл өртөг маш их зөрөөтэй, өндөр гарч, дүнд тодотгол засвар хийгээгүй тохиолдолд албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хамрах хүрээг хэтрүүлэн тооцоход хүргэх байлаа.

Иймд өндөр болон сөрөг дүнтэй нийт нэмэгдэл өртөг бүхий хоёр бүлгийн хувьд засварлалт хийсэн ба ингэхдээ дээрх хоёр бүлгийн хувьд хамгийн бага квадратын регрессийн аргыг ашиглан нийт нэмэгдэл өртгийн таамагласан дүнг тооцсон. Ингэхдээ нийт нэмэгдэл өртгийн мэдээнээс гарган авсан орлого болон q111-т

мэдээлсэн сарын бизнесийн орлогын хоорондын харьцааг тооцов. E болон M хувилбарын хувьд хамгийн бага квадратын тооцооны дүнг дор танилцуулав. Малчид болон бусад салбаруудад хоёр аргаар тооцсон орлогын хоорондын харьцаа үлэмж ялгаатай байсан тул малчдын хувьд “сул” (*dummy*) хувьсагчийг ашигласан болно. Сарын орлогын хэмжүүр q111 нь нэгтгэгдсэн байдал, тархаалтын хувьд хязгаарлагдмал тул хамгийн тохиромжтой бие даасан хувьсагч болгон авсан. Мөн зөвхөн регрессийн огтлолцол төдийгүй налуу нь малчин бүлгийн хувьд өөр гарч байсантай холбоотойгоор орлогын хэмжүүр болон малчдыг төлөөлсөн сул хувьсагчийн хоорондын уялдааг харгалзсан өгөгдөхүүнийг оруулсан.

ХҮСНЭГТ 4.1 9-р сард сөрөг хэмжээтэй болон хэт өндөр гарсан нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг засварлан тооцсон регресс, хувилбаруудаар

<u>Дугуйн хувилбар</u>						
Эх сурвалж	SS	df	MS	Ажиглалтын тоо = 1365		
Загвар	1.8917e+13	3	6.3057e+12	F(3, 1361) = 115.70		
Үлдэгдэл	7.4177e+13	1361	5.4502e+10	Prob > F = 0.0000		
Нийт	9.3094e+13	1364	6.8251e+10	R-squared = 0.2032		
				Adj R-squared = 0.2014		
				Root MSE = 2.3e+05		
inc_new	Коеф.	Стандарт алдаа	t	P> t	[95%-н Итгэмжлэгдэх зааг]	
_lherder_1	-119717.2	21361.66	-5.60	0.000	-161622.6	-77811.88
q111m	.3180646	.0222857	14.27	0.000	.2743467	.3617826
_lherXq111~1	.6154829	.0819067	7.51	0.000	.4548058	.77616
_cons	140085.9	7898.873	17.73	0.000	124590.6	155581.2
<u>Үржүүлэгчийн хувилбар</u>						
Эх сурвалж	SS	df	MS	Ажиглалтын тоо = 2745		
Загвар	8.8647e+12	3	2.9549e+12	√F(3, 2745) = 74.78		
Үлдэгдэл	1.0847e+14	2745	3.9514e+10	Prob > F = 0.0000		
Нийт	1.1733e+14	2748	4.2697e+10	R-squared = 0.0756		
				Adj R-squared = 0.0745		
				Root MSE = 2.0e+05		
inc_new	Коеф.	Стандарт алдаа	t	P> t	[95%-н Итгэмжлэгдэх зааг]	
_lherder_1	-98952.58	12658.83	-7.82	0.000	-123774.4	-74130.78
q111m	.1149619	.0109455	10.50	0.000	.0934996	.1364242
_lherXq111~1	.4823337	.0634559	7.60	0.000	.3579075	.6067598
_cons	132212.2	4334.041	30.51	0.000	123713.9	140710.5

Хамаарагч хувьсагч *inc_new* нь нийт нэмэгдэл өртгөөс гарган авсан орлогын хувьсагч бөгөөд *rev-exp-comb* гэсэн утгаар илэрхийлэгддэг. Үүнд *comp* нь бизнесийг эзэмшигчээс бусад ажилтанд олгож буй нөхөн олговор, төлбөрийг илэрхийлнэ.

Хоёр хувилбарын хувьд регресс дэх бүх хувьсагчид нөлөөтэй гарсан ба хувилбар хоорондын дүр зураг нэгэн жигд байгаа нь үр дүнд итгэх бидний итгэлийг нэмэгдүүлсэн. Мал аж ахуйн секторын сул хувьсагчийн итгэлцүүр нь ихээхэн сөрөг дүнтэй гарсан. Өөрөөр хэлбэл q111-т мэдээлсэн бизнесийн орлогын түвшнийг хянасны (*control*) дараагаар нийт нэмэгдэл өртгийн протоколоос гарган авсан байдлаар малчид бизнесийн орлогын бага дүнг мэдээлж байсан. q111 болон малчны сул хувьсагчийн харилцан үйлчлэлээс үүсэх мал аж ахуйн секторын налалтын нэмэгдэхүүн бусад салбарынхаас харин илүү дүнтэй байна. Тиймээс q111 дэх хэмжээ нэмэгдэх тусам уг асуултын хариултанд орлого болон тайлан тэнцлийн бодит дүнг бууруулж хариулах явдал буурч байгаа.

Регрессийн аргаар тооцсон дүнг ашиглан регрест оруулаагүй түүврийн хэсгийн орлогын хэмжээг таамаглан тодорхойлсны дараагаар нөхөн олговор, бараа материалын өөрчлөлтийг *inc_new* хувьсагчид нэмэх замаар өндөр болон хасах хэмжээтэй гарсан бүлгийнхний нийт нэмэгдэл өртгийг дахин тооцож гаргасан. Харин бусад бүлгийнхний нэмэгдэл өртгийг хариултанд нь үндэслэн тооцсон болно. Орлогын улирлын ялгааг асуусан q110-т авсан хариултуудыг ашиглан сарын дүнг жилийн болгон хувирган нэгтгэн тооцож гаргасан.

Эцэст нь хоёрдагч хувиараа хөдөлмөр эрхлэлтийн орлоготой өрхүүдийн хувьд засвар хийсэн. Орлого, тайлан тэнцлийн хуудсыг бөглөсөн 7484 өрхийн 10% (748) нь хувиараа хөдөлмөр эрхлэлт давхар эрхэлж байв. Ийм өрхийн хоёрдагч үйл ажиллагааны хувьд орлого, тайлан тэнцлийн хуудсыг бүрэн бөглөөгүй, харин хувиараа хөдөлмөр давхар эрхэлснээс олж буй орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувийн жинд нь үндэслэн нэмэгдэл өртгийг нь тооцсон. Эдгээр хоёрдагч бизнесийн орлого дунджаар өрхийн гол бизнесийн орлогын гуравны нэгтэй тэнцэж байсан. Тиймээс нийт өрхийн 10 хувь нь хоёрдагч бизнес эрхэлдэг гэж мэдэгдсэн тул нэмэгдэл өртөг нь ойролцоогоор гол бизнесийн нэмэгдэл өртгийн $10 \cdot 0.033 = 3.3\%$ гэж гарсан. Дараачийн хэсэгт бид эдгээр тооцооны дүнг танилцуулна.

4.2. АЛБАН БУС СЕКТОРЫН СҮҮДРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ТАРХАЛТ

Бид тооцсон бүх дүнгүүдээ хоёр багцлан танилцуулж байна. Үүнд дугтуйн аргыг ашиглан 2, 3-р хувилбараар цуглуулсан мэдээллийг нэг багцлан, үржүүлэх аргад үндэслэн 5-р хувилбараар цуглуулсан мэдээллийг тусад нь нэг багцлан харууллаа. Хүснэгт болон текстэд энэ хоёр багц дүнг Хувилбар Е, Хувилбар М гэж танилцуулсан болно. Энэ хоёр хувилбарын дагуу (Е, М) хариулагчид орлого, тайлан тэнцлийн хуудсыг өөрсдөө бөглөн, дугтуйнд хийж наан тоологчид өгсөн ба үржүүлэх аргаар энэ хуудсыг бөглөхдөө хариуг 2.2-р хэсэгт тайлбарласны дагуу хувирган хольсны дараа дугтуйнд хийж наасан.

Албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хамрах хүрээ буюу хэмжээг улсын түвшинд нэгтгэж гаргаснаас гадна ажил эрхлэлтийн байдлаар нь хариулагсдыг бүлэглэж, жилийн дүнгээр тооцов. Албан бус секторт малчдыг хувиараа хөдөлмөр эрхлэгч бусад бүлгээс тусад нь авч үзсэн болно. Тооцооны дүнг улс, бүс нутгийн түвшинд, мөн байршлаар ЭЗҮАОУСА-н дээд түвшний нарийвчлалтайгаар гаргасан. АБСӨС-гаар тооцсон үйл ажиллагааны харьцангуй хэмжээний талаар тодорхой ойлголт авах үүднээс гурван харьцааг тооцож гаргасан юм. Эхнийх нь жил тутмын мал тооллого дээр үндэслэн мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг ҮСГ-аас тооцсон дүнг АБСӨС-гаар тооцсон үйлдвэрлэлийн хэмжээтэй харьцуулж гаргасан дүн болно. Үүнийг дараахь байдлаар илэрхийлсэн:

$$\text{Мал аж ахуйн харьцаа} = \frac{MAA^{АБСӨС}}{MAA^{ҮСГ}}$$

Түүнчлэн албан бус секторт мал аж ахуйн бус салбарын үйлдвэрлэлийн нийт үйл ажиллагаанд харьцуулсан харьцаа нь ихээхэн мэдээлэл өгөх учиртай. Үүнд нийт үйл ажиллагаа гэдэгт ДНБ-нээс өмнө хийгдсэн судалгааны дүнг (Бикалес нар, 1999) ашиглан түүнд оруулан тооцож буй сүүдэр үйл ажиллагааны дүнг хассан утга байна. Мал аж ахуйн бус үйл ажиллагааны харьцааг дараахь томъёогоор илэрхийлнэ:

$$\text{Албан бус секторын харьцаа} = \frac{MAA_{\text{бус Албанбус}}^{АБСӨС}}{ДНБ - Албанбус}^{БИК}$$

Эцэст нь ҮСГ-ын тооцож буй албан бус секторын хэмжээтэй харьцуулахад АБСӨС-нд

ажиглагдаж буй нийт нэмэлт нэмэгдэл өртгийн хэмжээг илэрхийлэгч харьцааг бид танилцуулж байна. Нэмэлт нэмэгдэл өртөг (ННӨ)-н харьцаа нь:

$$\text{Нэмэлт нэмэгдэл өртгийн харьцаа} = \frac{\text{Албанбус}^{\text{АБСӨС}} - \text{Албанбус}^{\text{Бик}} - \text{МАА}^{\text{УСГ}}}{\text{ДНБ}}$$

Үүнд $\text{Албанбус}^{\text{АБСӨС}}$ нь бүх албан бус салбаруудыг хамруулж байгаа.

ҮСГ-гаас тооцсон 3 тоо мэдээг ашиглан дээрх харьцаануудыг гаргав. Эдгээрийн эхнийх нь 2004 оны ДНБ-ий тооцоо юм. Үүнд ҮСГ нь 2004 оны ДНБ-ийн үйлдвэрлэлийг 1,807 тэрбум төгрөг²⁵ гэж урьдчилан тооцсон. Харин энэ дүн дэх албан бус секторын үйлдвэрлэлийг Бикалес-н тооцсон дүнд үндэслэн салгаж хараахан тооцоогүй байв. Иймд бид $\text{АлбанБус}^{\text{Бик}}$ -н дүнг 2000-2003 онуудад Бикалес-н аргаар тооцсон тооцоо болон нийт ДНБ-ний дүнд үндэслэн тооцсон. ҮСГ-н тооцоогоор

$\text{АлбанБус}^{\text{Бик}}$ нь 2000 онд 11.37% байснаа 2003 онд 13.73% болж өсчээ. Цаг хугацааны хандлагыг энгийн хамгийн бага квадратын аргаар тооцоход ҮСГ-аас гаргасан 2004 оны ДНБ-ний дүнд албан бус сектоын сүүдэр эдийн засгийн эзлэх хувь 14.34%-тай тэнцүү байна.²⁶ Иймд Монгол улсын албан бус салбарын ДНБ-ний суурь хэмжээ дараахь байдалтай байна:

$$0.1434 * \text{ДНБ} = 259 \text{ тэрбум төгрөг} \quad (4.2)$$

ҮСГ-ын тооцоогоор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2004 онд нийт ДНБ-ий 18.27% буюу 330 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 4.2-оос харахад АБСӨС-гаар тооцсон сүүдрийн эдийн засгийн эзлэх хувийн дундаж дүн нь хувилбараас хамаарч өөр өөр дүнтэй байгаа ба Е хувилбараар тооцсон дундаж дүн 766 тэрбум төгрөг, М хувилбараар тооцсон дүн 584 тэрбум төгрөг байна. Мал аж ахуйн бус салбарын үйлдвэрлэл нь М хувилбараар 63 хувь, Е хувилбараар 60 хувьтай тэнцүү байна.

ХҮСНЭГТ 4.2 Албан бус секторын нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг улсын түвшингээр тооцсон нь (тэр бум төгрөг), хувилбараар

<u>Дугуйн (Е) хувилбар</u>					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. алдаа.	[95% итгэмжлэх зааг]		D эффект
Албан бус	462658	36713.69	390661.4	534656.1	.8170159
МАА	302916	58317.46	188553.1	417280.0	5.918508
Нийт	765575	67974.99	632272.9	898877.6	2.204294
<u>Үржүүлэгчийн (М) хувилбар</u>					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. алдаа.	[95% итгэмжлэх зааг]		D эффект
Албан бус	368776	61792.17	247633.9	4899205	.471972
МАА	214723	26795.97	162190.4	2672573	.874433
Нийт	583500	67089.85	451971.5	715029.7	5.308699

Хүснэгт 4.3-т сүүдрийн эдийн засгийн үйлдвэрлэлийг гурван харьцаагаар улсын хэмжээнд гаргав. Е хувилбараар АБСӨС-ны мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 303 тэрбум төгрөг байгаа нь ҮСГ-ын тооцооны 92

орчим хувьтай тэнцэж байна. Харин М хувилбараар харьцангуй бага нэмэгдэл өртөг буюу 215 тэрбум төгрөг байгаа нь ҮСГ-ын дүнгийн 65 хувьтай тэнцүү байгаа нь бусад салбарын хувьд ч энэ хувилбарын дүн харьцангуй доогуур байгаатай

²⁵ 1995 оны зэрэгцүүлэх үнээр 2003 онтой харьцуулахад 10.4 хувь өссөн байна.

²⁶ ҮСГ-ын 2004 оны ДНБ-ий жинхэнэ гүйцэтгэлийн тооцоогоор энэ тоо 10.1 хувьтай тэнцэж байна.

нэгэн адил байна. Албан бус, мал аж ахуйн бус салбарын сүүдрийн эдийн засгийн үйлдвэрлэл нь Е болон М хувилбарын хувьд *АлбанБус*^{Бик}-н дүнг хасаж тооцсон ҮСГ-ын ДНБ-ний тооцооны дүнгийн 30%, 24%-тай тус бүр тэнцэж байгаа бөгөөд өмнөх Бикалесийн судалгааны тооцооны дүнг үндсэндээ орлох тул албан бус секторын хамрах хүрээг тооцоход ихээхэн ач холбогдолтой тоо гэж бид үзэж байна. Судалгаанд салбаруудыг нэмж оруулсан, мөн зарим гол салбарт ДНБ-тэй уялдаатай өсөлтөөс хамааран нэмэлт үйл ажиллагаа гарч байгаа тул эдгээр шинэ тооцооны дундаж утга нь 2004 онд 14 хувьтай тэнцүү байсан Бикалесийн судалгааны дүнг тархаасан дүнгээс илүү өндөр байгаа билээ. Нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийн хэмжээг салбаруудаар тооцсоныг

Хүснэгт 4.6-д үзүүлсэн ба үүнийг дор дэлгэрүүлэн авч үзнэ.

Хүснэгт 4.3-т танилцуулсан сүүлчийн харьцаа бол АБСӨС-гаар шинээр тооцсон нэмэлт нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг хэмжиж буй ННӨ-н харьцаа юм. Өмнөх хүснэгт болон харьцаануудаас харахад Е хувилбараар 9.7 хувийн нэмэлт эдийн засгийн үйл ажиллагаа илэрч байгаа бол М хувилбараар ямар нэгэн өөрчлөлт гарахгүй байна. Үйл ажиллагааны салбарын тархац ихээхэн өөрчлөгдсөн байдалтай гарч байгаа ба ННӨ-н харьцаа нь ҮСГ-н тооцоотой харьцуулахад бага хэмжээтэй мал аж ахуйн сектор болон илүү том хэмжээтэй мал аж ахуйн бус албан бус сектор дээр үндэслэн тооцогдсон.

ХҮСНЭГТ 4.3 ДНБ дэх сүүдрийн үйл ажиллагааны эзлэх хувийн жин

Хувилбар	МАН харьцаа	Сүүдрийн харьцаа	ННӨ харьцаа
Дугтуй Е	.9171901	.2987361	.0973704
Үржүүлэгч М	.6501542	.2381171	-.0033354

Жич: Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн харьцаа нь АБСӨС-аар гарсан дүнг ҮСГ-ын дүнд хуваасантай, Сүүдрийн эдийн засгийн харьцааг албан бус секторын мал аж ахуйн бус үйлдвэрлэлийн хэмжээг ДНБ-ээс Бикалесийн дүнг хассан дүнд хуваасантай, нэмэлт нэмэгдэл өртөг нь тус судалгаанаас тооцсон мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл дээр албан бус секторын мал аж ахуйн бус салбарын үйлдвэрлэлийг нэмж, дүнгээс нь Бикалесийн тооцоог хассан ДНБ-д хуваасан мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хэмжээтэй тэнцэнэ.

ХҮСНЭГТ 4.4 Сүүдрийн эдийн засгийн нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг бүс нутгаар тооцсон нь (тэр бум төгрөг)

Дугтуйн (Е) хувилбар, бүсийн тооцоо					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. алдаа.	[95% итгэмжлэх зааг]		D эффект
Баруун албан бус	67613.01	10656.59	46714.91	88511.11	0.508205
Баруун МАН	64036.89	17538.14	29643.72	98430.06	2.261788
Хангай албан бус	72989.94	10143.54	53097.96	92881.92	0.594998
Хангай МАН	109675.1	50571.5	10501.9	208848.4	7.955758
Төв албан бус	80732.64	21466.64	38635.5	122829.8	2.432345
Төв МАН	87708.94	22584.53	43419.55	131998.3	4.460202
Зүүн албан бус	13243.54	5258.843	2930.688	23556.39	0.817808
Зүүн МАН	33991.43	7153.453	19963.16	48019.71	2.126052
УБ албан бус	228079.6	26636.47	175844.1	280315	0.646969
УБ МАН	7504.15	2270.255	3052.067	11956.23	0.556174

ХҮСНЭГТ 4.4-ийн үргэлжлэл

Үржүүлэгчийн (М) хувилбар, бүсийн тооцоо					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. алдаа.	[95% итгэмжлэх зааг]		D эффект
Баруун албан бус	33616.65	6370.422	21127.48	46105.81	0.736947
Баруун МАА	44515.95	11260.33	22440.16	66591.75	1.386683
Хангай албан бус	94409.63	60280.71	-23770.22	212589.5	8.795584
Хангай МАА	69999.98	12416.94	45656.67	94343.29	7.885287
Төв албан бус	44090.66	6691.523	30971.98	57209.34	1.196376
Төв МАА	70603.54	18232.55	34858.77	106348.3	6.687613
Зүүн албан бус	9990.853	1937.482	6192.435	13789.27	0.684057
Зүүн МАА	24581.44	10063.19	4852.639	44310.23	5.39251
УБ албан бус	186669.1	10733.99	165625.2	207713	0.55798
УБ МАА	5022.811	3291.728	-1430.596	11476.22	0.813074

Хүснэгт 4.4 болон Хүснэгт 4.5-д сүүдрийн эдийн засаг бүс нутаг, байршлаар хэрхэн ялгаатай буйг харууллаа. Албан бус сектор дахь мал аж ахуйн бус үйлдвэрлэл Улаанбаатар хотод давамгайлж байгаа буюу нийт үйл ажиллагаанд дунджаар E хувилбараар 47%, M хувилбараар 49%-ийг эзэлж байна. Энэ үзүүлэлтээр дараачийн байранд Хангайн бүс орж, Төв, Баруун, Зүүн бүсийн нутгууд удаалж байна. Албан бус секторын үйл ажиллагааны төрөл бүс нутгийн түвшинд хэрхэн тархаж байгаа нь хувилбар аргуудаас хамааран бага зэрэг ялгаатай гарч байна. Ялангуяа мал аж ахуйн салбарын ихэнх хэсэг төвлөрсөн дүн гарсан

Хангайн болон Төвийн бүсийн нутагт үржүүлэх хувилбарыг ашиглан мэдээлэл цуглуулж тооцоход албан бус секторын үйл ажиллагаа ихээхэн бага хэмжээтэй гарсан. Энэ нь энэ хувилбар малчин өрхөд тийм ч тохиромжтой бус байсантай холбоотой байж болох юм. Түүнчлэн хөдөө орон нутагт албан бус сектор дахь мал аж ахуйн бус салбарын үйлдвэрлэл бага ажиглагдсан. Харин албан бус секторт мал аж ахуйн салбарыг оруулж тооцоход хөдөө орон нутаг нийт албан бус секторын үйлдвэрлэлийн хэмжээгээр Улаанбаатар хотын дараа орж байна.

ХҮСНЭГТ 4.5 Албан бус секторын нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг байршлаар тооцсон нь (тэрбум төгрөг)

Дугтуйн (E) хувилбар, байршлын тооцоо					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. алдаа.	[95% итгэмжлэх зааг]		D эффект
УБ албан бус	228079.6	26636.47	175844.1	280315	0.646969
УБ МАА	7504.15	2270.255	3052.067	11956.23	0.5561744
Аймгийн төв албан бус	128707.2	12489.91	104213.9	153200.6	0.3916935
Аймгийн төв МАА	14813.85	4764.767	5469.905	24157.8	0.2891107
Сумын төв албан бус	89999.1	22540.31	45796.44	134201.8	2.396606
Сумын төв МАА	7339.272	4104.227	-709.3203	15387.86	1.653525
Хөдөө албан бус	15872.82	6087.233	3935.449	27810.18	6.630088
Хөдөө МАА	273259.3	57999.06	159520.2	386998.3	6.94573

ХҮСНЭГТ 4.5-ын үргэлжлэл

Үржүүлэгчийн (М) хувилбар, байршлын тооцоо					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. алдаа.	[95% итгэмжлэх зааг]		D эффект
УБ албан бус	186669.1	10733.99	165625.2	207713	0.5579795
УБ МАА	5022.811	3291.728	-1430.596	11476.22	0.8130742
Аймгийн төв албан бус	85930.05	6391.349	73399.86	98460.24	0.3685774
Аймгийн төв МАА	6344.091	2204.18	2022.813	10665.37	0.2563898
Сумын төв албан бус	83431.61	60451.44	-35082.96	201946.2	9.287993
Сумын төв МАА	29653.56	16945.32	-3567.618	62874.73	2.842539
Хөдөө албан бус	12746.13	5206.918	2538.009	22954.25	4.305271
Хөдөө МАА	173703.3	20457.81	133595.9	213810.6	7.559049

Хүснэгт 4.3 дахь албан бус секторын харьцаатай холбоотойгоор дээр тайлбарласанчлан худалдаа, зоогийн газар, тээврийн салбарыг хамруулан дүнг тооцож тархаасан Бикалес нарын (1999) дүнгээс АБСӨС-ны нэмэгдэл өртгийн дүн хавьгүй илүү байгаа билээ. Гэхдээ албан бус салбарын өсөлт нь зөвхөн нэмэлт салбаруудыг хамруулснаас үүдэж байгаа хэрэг биш юм. Тухайлбал, энэ судалгаанд хамрагдсан салбаруудаас хамгийн том буюу E хувилбараар (M хувилбараар) 255 тэрбум төгрөг (200 тэрбум төгрөг)-тэй тэнцэж буй худалдааны салбар нь Бикалесийн судалгаанд тархаан тооцогдсон худалдааны салбарын нийт дүнтэй (259 тэрбум төгрөг) ойролцоо байна. Зоогийн газрын салбарын дүнд шууд харьцуулалт хийхэд АБСӨС-гаар өсөлт ажиглагдсанаас гадна бусад холбогдох дэд

салбарууд, тухайлбал албан бус зочид буудлын үйлчилгээ шинээр нэмэгдэж хамрагдсан байна. Харин АБСӨС-нд хэмжээгээрээ гуравт орж байгаа тээврийн салбар нь Бикалесийн нарын судалгаа (1999)-ны дүнг шинээр тооцон гаргасан 100 тэрбум төгрөгтэй харьцуулахад арай бага үзүүлэлттэй гарлаа. АБСӨС-нд тээврийн салбар E хувилбарын хувьд 47 тэрбум төгрөгтэй, M хувилбарын хувьд 33 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Ийнхүү тээврийн салбар бага үзүүлэлттэй гарсан нь нэлээд санаандгүй үр дүн ба а) манай судалгаанд энэ салбар дутуу хамрагдсан, эсвэл б) урьд нь явуулсан албан бус секторын судлагаанд энэ салбарын дүнг хэтрүүлэн тооцсон, эс бөгөөс в) албан сектор дахь тээврийн үйлчилгээ нэмэгдсэнээс албан бус сектор дахь энэ салбарын үйл ажиллагаа бодитойгоор буурсан байж болох юм.

ХҮСНЭГТ 4.6 Сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагаа, салбарын түвшингээр (ЭЗҮАОУСА-н дээд түвшингээр)

Дугтуйн (E) хувилбар салбарын тооцоо					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. Алдаа	[95% итгэмжлэх зааг]		D эффект
ХАА	322714.3	58822.09	207361.2	438067.4	5.605484
Загас агнуур	30.29535	30.29535	-29.11535	89.70606	0.4505077
Уул уурхай	3814.865	1512.79	848.2075	6781.523	1.413589
Боловсруулах үйлдвэрлэл	79777.81	9709.726	60736.55	98819.07	0.8499624
Цахилгаан, хий	348.0964	270.7714	-182.9	879.0928	0.4146345
Барилга	5107.539	1541.498	2084.584	8130.494	0.5577638
Худалдаа	264640.1	32306.88	201284.7	327995.5	0.8748234
Зочид бууд., зоог. газар	26013.19	5837.979	14564.62	37461.76	0.6886468
Тээвэр	48416.68	6866.617	34950.89	61882.46	0.4936939

ХҮСНЭГТ 4.6-ын үргэлжлэл

Санхүү	3761.817	1932.469	-27.85063	7551.485	0.7386012
Үл хөдлөх хөрөнгө	4316.387	1384.739	1600.844	7031.929	0.5843889
Боловсрол	354.4417	224.8522	-86.50483	795.3882	0.4601628
Эрүүл мэнд	5322.366	4305.007	-3119.969	13764.7	0.359852
Бусад, нийтийн аж ахуй	582.2341	9812.765	-18661.09	19825.56	0.6484286
Хувийн орон сууц	373.5442	332.4321	-278.3719	1025.46	0.7020484
Бусад	1.592725	1.592725	-1.530688	4.716137	0.0683262
Үржүүлэгчийн (М) хувилбар салбарын тооцоо					
Нийт дэд олонлог	Тооцсон дүн	Ст. Алдаа	[95% итгэмжлэх зааг]		D эффект
ХАА	245468.7	32748	181266.5	309670.9	4.434961
Загас агнуур	541.1902	458.6076	-357.9066	1440.287	7.998247
Уул уурхай	2516.155	804.1304	939.6639	4092.647	1.183033
Боловсруулах үйлдвэрлэл	53779.98	5143.895	43695.41	63864.55	0.5944037
Цахилгаан, хий	468.8083	182.4192	111.1768	826.4397	0.5213296
Барилга	4805.031	1202.577	2447.388	7162.674	0.5019692
Худалдаа	208474	58344.49	94090.05	322857.9	6.244412
Зочид бууд., зоог. газар	12381.85	2968.123	6562.867	18200.83	0.7866985
Тээвэр	34797.74	5470.339	24073.18	45522.3	0.7547262
Санхүү	2116.247	1435.573	-698.1834	4930.677	0.4598493
Үл хөдлөх хөрөнгө	3713.169	1106.898	1543.104	5883.233	0.6124611
Боловсрол	1789.043	1402.336	-960.2259	4538.313	0.6066508
Эрүүл мэнд	2653.418	1181.293	337.5012	4969.334	1.376959
Бусад, нийтийн аж ахуй	9249.018	1385.108	6533.524	11964.51	0.6134121
Хувийн орон сууц	593.9755	367.5629	-126.6288	1314.58	0.6939072
Бусад	100.7402	50.02167	2.673126	198.8073	0.9539653

Түүнчлэн судалгаагаар уул уурхайн салбарын үйл ажиллагаа харьцангуй бага, харин боловсруулах аж үйлдвэрийн салбар өндөр гарсан нь санаандгүй дүн болов. Ялангуяа сүүлийн үеийн судалгаа (МБХА 2003)-наас үзэхэд албан бус салбарт гар аргаар алт олборлох үйл ажиллагаа нэлээд зонхилох байр суурьтай байгаа талаар дурьджээ. Үүний нэг шалтгаан нь магадгүй гар аргаар алт олборлогч мэдээллээ нууцлах зорилгоор хийж байгаа ажлынхаа талаар дутуу мэдээлсэн байж болох юм. Алт олборлох үйл ажиллагаа нь зарим талаар том хэмжээтэй гарсан боловсруулах болон худалдааны салбарт хамрагдан тооцогдсон байж болох талтай. Энэ дагуу буруу ангилагдсан эсэхийг тодруулахын тулд эдгээр салбарт ажиллагч хүмүүсийг санамсаргүй аргаар түүвэрлэн дахин судлах шаардлагатай. Түүнчлэн гар аргаар уул уурхайн олборлолт эрхэлж буй үйл ажиллагааны тархалт

нь үндэсний хэмжээнд явуулж буй судалгаанд хамрагдахааргүй хэлбэртэй явагддаг байж болох юм. АБСӨС-гаар гарсан уул уурхайн олборлох үйл ажиллагаа эрхлэгчдийн тооны хувьд саяхны Ажиллах Хүчний Судалгааны тоотой ойролцоо гарсныг тэмдэглэе.²⁷

Эцэст нь дурьдахад сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагаа тодорхой салбарт илүүтэй тохиолдоно гэсэн төсөөлөлтэйгээр салбаруудыг сонгон энэ судалгааг явуулаагүй.

Тооцооны дүнгийн нарийвчлалтай холбоотой асуудлуудыг авч үзэхийн өмнө бас нэг багц үр дүнг танилцуулав. Хүснэгт 4.7-д бараа, үйлчилгээний нийт нийлүүлэлтийг холимог орлого (шууд бус татварыг оролцуулаад), нөхөн олговор элэгдэл хорогдол, завсрын хэрэглээ гэсэн ангиллаар задлан үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийн эзлэх хувь хэмжээгээр харуулав. Боловсрол, эрүүл мэнд зэрэг

²⁷ 5-р хэсэгт өрхийн тоог салбараар тооцсон хүснэгтүүдийг оруулав.

бага үзүүлэлттэй гарсан зарим салбарыг эс хувилбаруудаар тооцоход хоорондоо уялдаатай, тооцвол хүснэгтэнд буй дүнгүүд нь ойролцоо гарсан.

ХҮСНЭГТ 4.7 Эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийн эзлэх хувь, салбараар

<u>Дугтуйн (Е) хувилбар</u>					
Дундаж Холимог ЭЗҮАОУСА дээд түвшинд	орлого	Элэгдэл	Нөхөн олговор	Завсрын хэрэглээ	Нийт
ХАА	0.51	0.13	0.04	0.32	1.00
Загас агнуур					
Уул уурхай	0.58	0.00	0.02	0.39	1.00
Боловсруулах үйлдвэрлэл	0.58	0.01	0.04	0.37	1.00
Цахилгаан, хий	0.68	0.00	0.00	0.32	1.00
Барилга	0.46	0.02	0.19	0.34	1.00
Худалдаа	0.55	0.02	0.02	0.41	1.00
Зочид бууд., зоог. газар	0.39	0.07	0.15	0.39	1.01
Тээвэр	0.56	0.06	0.02	0.36	1.00
Санхүү	0.65	0.10	0.00	0.24	1.00
Үл хөдлөх хөрөнгө	0.43	0.08	0.14	0.35	1.01
Боловсрол	0.81	0.02	0.00	0.16	1.00
Эрүүл мэнд	0.05	0.12	0.33	0.50	1.01
Бусад, нийтийн аж ахуй	0.60	0.03	0.03	0.34	1.00
Хувийн орон сууц	0.40	0.02	0.00	0.58	1.00
Нийт	0.52	0.05	0.07	0.36	1.00
<u>Үржүүлэгчийн (М) хувилбар</u>					
Дундаж Холимог ЭЗҮАОУСА дээд түвшинд	орлого	Элэгдэл	Нөхөн олговор	Завсрын хэрэглээ	Нийт
ХАА	0.56	0.05	0.07	0.32	1.00
Загас агнуур	0.84	0.01	0.00	0.16	1.00
Уул уурхай	0.37	0.11	0.26	0.26	0.92
Боловсруулах үйлдвэрлэл	0.59	0.02	0.05	0.35	1.00
Цахилгаан, хий	0.45	0.09	0.07	0.39	1.01
Барилга	0.42	0.03	0.27	0.28	1.00
Худалдаа	0.60	0.02	0.02	0.37	1.00
Зочид бууд., зоог. газар	0.44	0.03	0.11	0.42	1.00
Тээвэр	0.55	0.05	0.03	0.37	1.00
Санхүү	0.50	0.04	0.08	0.38	1.00
Үл хөдлөх хөрөнгө	0.47	0.07	0.09	0.37	1.01
Боловсрол	0.10	0.09	0.29	0.52	1.02
Эрүүл мэнд	0.47	0.07	0.14	0.31	1.01
Бусад, нийтийн аж ахуй	0.51	0.03	0.07	0.39	1.00
Хувийн орон сууц	0.55	0.07	0.00	0.38	1.00
Нийт	0.49	0.05	0.10	0.35	1.00


Өгөгдлийн нарийвчлал ба хэвийн бус байдал. АБСӨС-ны тоо мэдээлэлд үндэслэн албан бус секторын хамрах хүрээг тооцсон бүх тооцоог хийхдээ үр дүнгийн нарийвчлалын утгыг агуулагч итгэмжлэх заагтай хийсэн. 95 хувийн итгэмжлэх заагтай авсан нь тус судалгааг 100 удаагийн давтамжтай тухайн түүврийн хүрээнээс шинээр санамсаргүй байдлаар өрхийг түүвэрлэн хийх бүрд тооцсон дундаж утга 100-гаас 95-д нь дээрх заагт багтан гарна. Хэдийгээр энэ зааг буюу интервалыг бид аль болох бага байлгах сонирхолтой байсан ч дийлэнх дүнгүүдэд итгэмжлэх зааг нэлээд их гарсан. Үүний нэг шалтгаан нь утгын тархалтыг хэвийн (нормаль) байна гэж төсөөлөн итгэмжлэх заагийг тооцсон юм. Гэтэл бодит тархалт хэвийн бус байна. Харин ч олон ажиглалт хязгаарын өндөр утгатай байсан нь тооцооны вариацийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.

Нэмэгдэл өртгийн өгөгдлийн хэвийн бус тархалтын түвшний нэг үзүүлэлтийг тархалтын ижил (1/4) хувь хоорондын хэмжээнээс гаргаж болох юм. Ижил j хувь хоорондын хэмжээ нь 25 дахь болон 75 дахь хувь хэмжээ (percentile)-ний өргөнийг тодорхойлох ба хязгаарын үзүүлэлтүүдийн бүсэд хэвийн тархалтын хувьд нийт утгын 0.7 хувь ногдож байх ёстой байтал АБСӨС-ны түүврийн хувьд дугтуйн болон үржүүлэгчийн аргаар хоёулангаар нь нийт ажиглалтын 11-ээс дээш хувийг агуулж байсан. Бид хязгаарын үзүүлэлтүүдийг туршиж үзэхэд эдгээр бизнесийн хувьд үр дүнгүүд нь эдийн засгийн

хувьд бодитой, уялдаатай байсан тул мэдээллийн сангаас хасах шаардлагагүй гэж үзсэн. Гэхдээ дээр дурьдсан засваруудыг хийсний дараагаар тооцоо хийхэд эдгээр нэгжүүдийн хувьд нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийн нэлээд хэсгийг буюу дугтуйн аргаар 34 хувь, үржүүлэгчийн аргаар 45 хувийг үйлдвэрлэсэн дүн гарчээ. Баруун болон Хангайн бүс нутгийн сумын төвд өндөр хязгаарын дүнтэй аж ахуйн нэгжүүд төвлөрсөн үзүүлэлт гарсан нь хачирхалтай ба албан бус секторын шинэчилсэн тооцоогоор дээрх сумдаас илүү их олон өрхийг түүвэрлэх шаардлагатай байж болзошгүй. Энэ судалгаагаар нэмэгдэл өртгийн үйлдвэрлэлийг тооцоход гарсан хэлбэлзлийн талаар бидний олж авсан мэдээлэл, судалгааны өртөг зэргийг харгалзан үзэж, цаашдын судалгааг илүү оновчтой болгох талаар 6.2-р хэсэгт дэлгэрүүлэн танилцуулав.

Зураг 4.1-т (мал аж ахуйн бус) албан бус секторын нэмэгдэл өртгийн нягтралыг үржүүлэгчийн аргын хувьд үзүүлэв.²⁸ Нэмэгдэл өртгийн харьцангуй доогуур түвшинд аж ахуйн нэгжийн тоо эрс буурч байгаа нь онцгой ажиглагдаж байна. Дээд хэсэгт байгаа аж ахуйн нэгжийн тоог бодолцвол хэвийн тархалтын хувьд тэгээс 50 сая төгрөгийн хоорондын зайнд хамаагүй олон аж ахуйн нэгж байх ёстой байсан. Итгэмжлэх заагийг тооцож үзэхэд эдгээр аж ахуйд үнэхээр оршин тогтнож байгаа нь харагдсан тул хүлээж байснаас илүү өргөн итгэмжлэх зааг үүсэхэд хүргэж байна.

ЗУРАГ 4.1 Нэмэгдэл өртгийн нягтралын тооцоо, үржүүлэгчийн хувилбараар



²⁸ Дугтуйн хувилбарыг ашиглах, эсвэл мал аж ахуйн салбарыг оролцуулан тооцоход зураг болон хэвийн бус тархалттай холбоотой асуудлууд өөрчлөгдөхгүй.

БҮЛЭГ 5

Бодлогын асуудлууд



Бодлогын асуудлууд

А өрөвдүгээр хэсэгт танилцуулсан ДНБ-ий тооцсон дүн чухал мэдээллийг өгч байгаа ба Монголын албан бус сектор дахь сүүдрийн эдийн засгийн талаар илүү бүрэн ойлголттой болох зорилгоор энэ хэсэгт дүн шинжилгээг гурван үе шаттайгаар гүнзгийрүүлэн дэлгэрүүлсэн болно. 5.1-р хэсэгт бизнес, өрхийн талаар болон хариулагсдын хувийн дүрслэл тоо мэдээллийг танилцуулж, холбогдох газар албан секторын бизнесийн эзэд, цалин хөлстэй ажил эрхлэгчид болон ажилгүйчүүдтэй харьцуулж судлав. Албан бус секторын сүүдрийн эдийн засгийн дүр зургийг илүү сайн тодорхойлохын тулд дүрслэл статистик шинжилгээг янз бүрийн тохиромжтой түвшинд дэлгэрүүлж хийлээ. Бид албан бус секторын үйл ажиллагааг хамгийн багадаа мал аж ахуй (ЭЗҮАОУСА 012) болон бусад салбар гэж ангилсан. Энэ хэсэгт текст болон хүснэгтэд мал аж ахуйн салбарыг тусгайлан дурьдаагүй албан бус секторт уг салбарыг оруулалгүйгээр танилцуулсан болно. Нийт үйл ажиллагааны тархалтын талаар мэдээлэх зорилгоор, мөн ЭЗҮАОУСА-ын дагуух ялгаа нь, тухайлбал хууль эрх зүйн орчны хувьд, сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох болсон шалтгаан, үр дагаврын талаар ойлголт авахад холбогдолтой байдаг тул 5.2 болон 5.3 хэсэгт уг ангиллын дагуу нэмэлт статистик мэдээг танилцуулав.

Хэдийгээр энэ хэсэгт танилцуулсан хэлэлцүүлэг, хүснэгт зэргийн тусламжтайгаар албан бус секторын талаар баялаг бодит зураглал гарган авах ч эдгээр нь хоёр хувьсагчийн хоорондын уялдаа хамаарал (хоёр шинж тэмдгийн харьцаа) дээр үндэслэсэн дүрслэн тодорхойлсон дүр зураг гэдгийг санах нь зүйтэй. Иймд илүү гүнзгий, нарийвчилсан ойлголт авахын тулд олон хувьсагчийн нэмэлт дүн шинжилгээ хийх шаардлагатай (6.2-р хэсгийг үзнэ үү).²⁹ Хүснэгт 5.75-д ийм нэг загварыг танилцуулсан ба үүгээр албан болон албан бус секторт бизнес эрхлэгчдийн ялгаатай талыг тодорхойлон үнэлсэн. Энэ арга нь

судлаачид хариулагчдын хувийн шинж чанар, нийгмийн хандлага, байршил, салбарын шинж чанарын талаар нэмэлт ойлголт авах боломж олгож байгаа юм. Энэ хэсэгт харин ямар хувилбарын аргыг тодорхой асуултанд хэрэглэх нь оновчтой болох талаар үнэлэлт дүгнэлт өгөөгүй бөгөөд энэ ажлыг судалгаа шинжилгээний дараачийн шатанд хэрэгжүүлэх ёстой.

Эцэст нь тэмдэглэхэд энэ хэсэгт танилцуулсан олонхи хүснэгтэд сүүлчийн мөрөнд “Нийт” гэсэн тооцоог оруулсан нь баганад байгаа бүх ажиглалтын дундаж дүн бөгөөд баганад байгаа тоонд задаргаа хийхэд ашиглах үзүүлэлтээр жигнэн тооцсон дүн юм. Иймд “Нийт” гэдэг нь баганад байгаа тооны энгийн дундаж биш болохыг анхаарна уу.

5.1. АЛБАН БУС СЕКТОР ДАХЬ СҮҮДРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

АБСӨС-гаар цуглуулсан өрх, бизнес, хувь хүний талаарх мэдээлэлд үндэслэн албан бус секторын сүүдрийн эдийн засгийн шалтгаан, үр дагаврын талаар судлан ойлгох үндсийг тавьсан дүнг энэ хэсэгт танилцуулж байна. Хэдийгээр албан бус сектор дахь хувиараа хөдөлмөр эрхлэлтэнд түлхүү анхаарсан боловч харьцуулсан дүн шинжилгээнээс ихээхэн зүйлийг мэдэж авах боломжтой. Тиймээс бид албан бус секторын дүнтэй хамт албан болон мал аж ахуйн салбарын талаарх өгөгдлийг мөн танилцуулж байна. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд цалин хөлстэй ажил эрхлэгчид болон ажилгүйчүүдээс авсан мэдээллийг ч энд танилцуулсан болно.

Өрхийн болон хувь хүний шинж чанар

Судалгааны 2, 3, 4, 5-р хэсэг дэх өрхийн болон хариулагчдын хувь хүний шинж чанар дээр тулгуурлан бүх хариулагчдын бүлгийг хооронд нь харьцуулан дүрслэсэн тоо статистикийг бид тооцсон. Ажилгүйчүүдийг эс тооцвол³⁰

²⁹ Ийм аргаас цөөн хэдэн жишээ дурьдвал пробит (probit) болон олон хариулт логит (logit) дүн шинжилгээ, вариацийн дүн шинжилгээ, олон хувьсагчийн (нэг болон олон тэгшитгэлт) регресс зэрэг болно.

³⁰ Судалгаагаар ажилгүйчүүд болон тэтгэврийнхнийг нэгтгэн авч үзсэн. Тиймээс ажилгүйчүүд гэсэн ажил эрхлэлтийн байдлыг тэтгэврийнхнийг оруулан тооцсон тооцоо гэж ойлгоно.

бүлгүүдийн хооронд насны ялгаа бага байгаа нь Хүснэгт 5.3-аас ажиглагдаж байна. Гэхдээ албан секторт ажиллагсдын нас албан бус секторт ажиллагсад болон цалин хөлстэй ажил эрхлэгчдийнхээс ялигүй өндөр байна. Хүснэгт 5.4-т харуулсанчлан хариулагчдын 66 хувь нь эрэгтэй байсан мал аж ахуйн салбарыг эс тооцвол ажил эрхлэлтийн төрлүүдийн хувьд ажиллагсдын хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд албан сектор дахь гол орлого ологчдын дийлэнх нь эмэгтэйчүүд олонхи болж байгаа бол хоёрдагч орлого ологчдын хувьд албан болон албан бус секторын аль алинд эмэгтэйчүүд давамгайлж байна.

Бүх ангиллын хариулагчдын тархалтыг Хүснэгт 5.1-д үзүүлсэн бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дундаас өрхийн үндсэн орлогыг бүрдүүлж буй иргэдийг хамруулах судалгааны протоколын чухал зорилгыг тоологч нар сайн биелүүлсэн байна. Тухайн үед хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 6914 (92%) нь үндсэн орлогоо бүрдүүлж, 592 (8 хувь) нь хоёрдагч орлогыг бүрдүүлж байна.

Судалгааны дүнг эл тайланд танилцуулах зорилгын хувьд хариулагчдын ангилал хамгийн сайн мэдээлэл агуулсан шинж чанар болж чадахгүй. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгсдийг бид албан секторт ажиллагсад, албан бус секторт ажиллагсад (албан бус), мал аж ахуй эрхлэгчид гэж гурав ангилсан. Сүүдрийн үйл ажиллагаанд орох болон гарах талаар ярилцахад бид өмнө нь хувиараа хөдөлмөр эрхэлж байсан эсэхийг сонирхсон. Тиймээс энэ хэсгээс бусад газар бид цалин хөлстэй ажиллагсдыг нэг бүлэг болгон авч үзсэн. Түүнчлэн ажилгүйчүүдийг нэг тусдаа бүлэг болгон авч үзсэн. Ийнхүү үүсгэсэн таван ангиллыг бид *ажил эрхлэлтийн байдал* гэж нэрлэсэн. Хүснэгт 5.2-г ажил эрхлэлтийн байдлаар судалгаанд хариулагчдыг ангилан, ажил эрхлэлтийн байдал тус бүрээр жинг тооцон – өөрөөр хэлбэл улсын түвшинд – тухайн ангилал бүрд хамаарах өрхийн тоог гаргасан. Эндээс харахад нийт өрхийн 48 хувь нь мал аж ахуйн болон мал аж ахуйн бус албан бус секторт ажил эрхэлж байхад 2.61 хувь нь албан секторт хувиараа хөдөлмөр эрхэлж байв.

Гэрлэлтийн байдлыг ажил эрхлэлтийн байдлаар судлахад онцын ялгаа ажиглагдаагүйг Хүснэгт 5.5-аас харж болно. Гагцхүү малчдын дунд гэр бүлийн салалт бага ажиглагдаж байна. Албан бус секторт мал аж ахуйн бус үйл ажиллагаа эрхлэгчдийн боловсролын түвшин малчдынхаас ерөнхийдөө өндөр байгааг Хүснэгт 5.6 харуулж

байна. Эцэст нь Хүснэгт 5.7-оос харахад өрхийн ам бүлийн тоо ажил эрхлэлтийн байдлаар нэг их ялгагдахгүй байгаа ч бусад бүлэгтэй харьцуулахад ажилгүйчүүдийн өрхийн ам бүлийн тоо бусад бүлгийнхээс 10 орчим хувиар бага байна.

ХҮСНЭГТ 5.1 Хариулагчдын ангилал

Хувиараа хөдөлмөр эрхэлсний орлого тухайн гэр бүлийн хувьд ач холбогдолтой байдал			
Ач холбогдол	Давтамж	Хувь	Нийт хувь
Үндсэн ХХЭ	6,914	36.37	36.37
Хоёрдагч ХХЭ	592	3.11	39.48
Өмнө нь ХХ			
эрхэлж байсан	290	1.53	41.01
Хэзээ ч эрхэлж байгаагүй	7,068	37.16	78.18
Ажилгүй/тэтгэвэрт	3,940	20.72	98.91
Хариулаагүй/байгаагүй	207	1.01	100.00
Нийт	19,011	100.00	

Жич: ХХЭ – хувиараа хөдөлмөр эрхлэгч

ХҮСНЭГТ 5.2 Өрх, ажил эрхлэлтийн байдлаар

Түүвэр дэх тархалт			
АЭ байдал	Давтамж	Хувь	Нийт хувь
албан бус	5,695	29.56	29.56
МАА	1,106	5.82	35.77
албан	668	3.51	39.28
цалин хөлс	7,382	38.82	78.12
ажилгүй	3,953	20.78	98.91
хариулаагүй	207	1.01	100.00
Нийт	19,011	100.00	
Улсын хэмжээний тархалт			
АЭ байдал	Давтамж	Хувь	Нийт хувь
албан бус	130,538.80	22.93	22.93
МАА	140,383.22	24.66	47.59
албан	14,885.886	2.61	50.21
цалин хөлс	182,088.35	31.99	82.19
ажилгүй	101,355.48	17.81	100.00
Нийт	569,251.73	100.00	

ХҮСНЭГТ 5.3 Нас, ажил эрхлэлтийн байдлаар

Дундаж Бүлэг	Тооцоо	Ст. алдаа	[95% Итгэмжлэгдэх зааг]		D эффект
албан бус	39.27087	.2139249	38.85154	39.6902	1.224964
МАА	40.05263	.5546379	38.96545	41.13981	5.365314
албан	40.97127	.4584415	40.07265	41.86989	.6926921
цалин хөлстэй	39.5766	.3859168	38.82014	40.33306	6.261933
ажилгүй	56.98567	.666832	55.67858	58.29277	4.267169

ХҮСНЭГТ 5.4 Хүйс, ажил эрхлэлтийн байдлаар

Асуулт 16

АЭ байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
албан бус	.5047	.4953	1
МАА	.6567	.3433	1
албан	.4493	.5507	1
цалин хөлс	.5026	.4974	1
ажилгүй	.488	.512	1
Нийт	.5371	.4629	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.5 Гэрлэлт, ажил эрхлэлтийн байдлаар

Асуулт 18

АЭ-ийн байдал	Гэрлэж байгаагүй	Гэрлэсэн	Хамтран амьдрагч	Тусдаа амьдардаг	Салсан	Бэлэвсэн	Нийт
албан бус	.0806	.7845	.0307	.014	.0303	.0601	1
МАА	.096	.8163	.0145	3.2e-05	.006	.0672	1
албан	.0381	.8694	.016	.0148	.0193	.0424	1
цалин хөлс	.0749	.7904	.0408	.0156	.0172	.0612	1
ажилгүй	.0496	.6156	.0057	.0132	.0153	.3006	1
Нийт	.0759	.7664	.0251	.0109	.0171	.1045	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.6 Боловсрол, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Бүрэн бус бага	Бага	Бүрэн бус дунд	Дунд	Бүрэн бус техник мэргэжил	Техник мэргэжил	Бүрэн бус дээд	Дээд	Нийт
албан бус	.0028	.0396	.2014	.4113	.0685	.1434	.1285	.0045	1
МАА	.0366	.2325	.4348	.2065	.0251	.0456	.0167	.0022	1
албан	0	.0098	.0868	.2623	.0441	.2266	.3401	.0304	1
цалин хөлс	.0051	.0178	.1671	.2814	.0597	.2033	.2441	.0215	1
ажилгүй	.0216	.25	.3042	.2006	.0323	.1042	.0863	8.7e-04	1
Нийт	.0152	.1169	.2633	.2778	.0479	.1336	.1359	.0094	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.7 Өрхийн ам бүл, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Дундаж тоо
албан бус	4.432
МАА	4.552
албан	4.364
цалин хөлстэй	4.439
ажилгүй	3.986
Нийт	4.383

Нийгмийн хандлага

Энэ хэсэгт хувь хүмүүс эдийн засгийн ямар шийдвэр гаргахад нөлөөлөх үүрэгтэй байж болзошгүй нийгмийн болон хувь хүний хандлага байр суурийн талаар ойлголт өгөх зорилгоор тавигдсан асуултуудын дүнг толилуулж байна. Энэ талаар асуухдаа тэвчээр, итгэл - үүн дотроо төр засагт итгэх итгэл, итгэл хүлээх байдал, шударга хандлага, үнэнч байдал, эрсдэл хүлээх сонирхол зэргийн талаар тодруулав.³¹ Тодорхой хариулагчдын бүлгүүдийн хооронд эдгээр

асуултуудад өгсөн хариулт нилээд зөрүүтэй байгаа ба харьцангуй ойролцоо хандлага байр суурьтай байгаа албан болон албан бус секторын бизнес эзэмшигчидтэй харьцуулахад малчдын байр суурь, хандлага ихээхэн өөр байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн энэ хэсэгт цалин хөлстэй ажил эрхлэгчид болон ажилгүйчүүдээс авсан хариултын дүнг танилцуулав.

Бусад бүлгийн хариулагчдыг бодоход албан секторт бизнес эзэмшигчид тэвчээр хүлээцтэй байдал нь үлэмж бага байгааг Хүснэгт 5.8-аас харж болох ба энэ байдал хоёр төрлийн асуултад өгсөн хариултын хувьд ойролцоо байна.³² Тэдний хувьд тодорхой бус гэхдээ түвэгтэй ажил хийх сонирхол (q30) бусад хариулагчтай харьцуулахад хамаагүй доогуур байгаа ба дэлгүүрт удаан хүлээж үйлчлүүлэх харьцангуй сонирхолгүй байна (q36). Харин малчид үйлчлүүлэхийг хүлээн цаг зарцуулах тал дээр бусад бүлгээ бодвол хамгийн тэвчээр хүлээцтэй байна. Цалин хөлстэй ажил эрхлэгчид болон ажилгүйчүүдтэй харьцуулахад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн гурван бүлгийн хариулагчид ерөнхийдөө жигд, бага ялгаатай байр суурьтай байна.

³¹ Эдгээр асуулт хариулагчийн хувьд эмзэг учир асуулгын дугуйн аргыг хэрэглэсэн хувилбар протокол дээр үндэслэн эдгээр хариултын дүрслэл тоо мэдээллийг бид тайлагнаж байна. Үүнтэй холбогдолтой асуудлын талаар илүү дэлгэрэнгүйг 2.2-р хэсгээс үзнэ үү.

³² “Дундаж” дүнг тооцвол нийт бүлгийн дүн 50 хувиас доогуур байгаа нь хазайлт байгаа эсвэл тодорхой бүлгийнхэн өөрсдийн харьцангуй байрлалын талаар тодорхой бус ойлголттой байгаатай холбоотой.

ХҮСНЭГТ 5.8 Тэвчээр хүлээцтэй байдал, ажил эрхлэлтийн байдлаар

Тодорхой бус гэхдээ төвөгтэй ажил хийх хүсэл, бусадтай харьцуулахад						
АЭ-н байдал	Асуулт 30					
Status	Маш их	Их	Дундаж	Бага	Маш бага	Нийт
албан бус	.2062	.2725	.3332	.119	.0691	1
МАА	.1702	.2786	.3575	.1456	.0481	1
албан	.1108	.2333	.4044	.1687	.0828	1
хөлсний	.1915	.2475	.3763	.1033	.0814	1
ажилгүй	.1938	.2554	.3393	.1315	.0799	1
Нийт	.1879	.2619	.3559	.1241	.0701	1

Жич: мөрөн дэх хувь

Дэлгүүрт үйлчлүүлэхээр хүлээх сонирхол					
АЭ-н байдал	Тооцоо	Ст. алдаа	[95% итгэмжлэгдэх зааг]		D эффект
албан бус	10.03879	.262588	9.524073	10.5535	1.713189
МАА	13.47106	.4256569	12.63671	14.30542	5.439461
албан	8.284828	.3888062	7.522705	9.046951	.8119865
цалин хөлстэй	11.89009	.582362	10.74857	13.03162	7.440421
ажилгүйчүүд	12.19621	.7241248	10.77681	13.61561	8.011775

Жич: хүлээлгийн хугацаа минутаар

Бусад бүлэгтэй харьцуулахад малчид хамгийн их итгэл бусдад үзүүлж байхад энэ талаар албан секторынхэн хамгийн доогуур үзүүлэлттэй байгааг Хүснэгт 5.9-өөс харж болно. Албан бус секторынхон, цалин хөлстэй ажил эрхлэгчид, ажилгүй иргэдийн хувьд итгэл найдвар хүлээлгэх байдал дундаж үзүүлэлттэй байна. Бусад хүмүүс

хариулагчдад хэр итгэл үзүүлдэг гэж үздэг талаар асуухад бүлгүүдийн хооронд нэг их ялгаатай хариулт өгсөнгүй. Бусад бүлгээ бодвол илүү олон малчид болон ажилгүйчүүд өөрсдийгөө арай илүү итгэл хүлээдэг гэж үзсэн боловч зөрүү нь статистикийн хувьд нөлөөтэй биш юм.

ХҮСНЭГТ 5.9 Итгэл үзүүлэх байдал , ажил эрхлэлтийн байдлаар

Асуулт 31				
АЭ-н байдал	Ихэнхи	Хагас	Цөөн	Нийт
албан бус	.3468	.3907	.2625	1
МАА	.6226	.2297	.1477	1
албан	.358	.3015	.3405	1
хөлсний	.438	.3127	.2492	1
ажилгүй	.522	.2826	.1954	1
Нийт	.4755	.3045	.22	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.10 Итгэл хүлээх байдал

АЭ-н байдал	Асуулт 33					Нийт
	Маш их	Илүү их	Адилхан	Илүү бага	Маш бага	
албан бус	.0804	.1945	.6634	.0528	.0089	1
МАА	.1016	.2104	.6384	.0411	.0084	1
албан	.0649	.2422	.6641	.0261	.0027	1
хөлсний	.0771	.1677	.7163	.0283	.0106	1
ажилгүй	.1121	.2059	.6344	.0367	.011	1
Нийт	.0898	.1931	.669	.0385	.0095	1

Жич: мөрөн дэх хувь

Шашны байгууллага, сүм хийдэд очих давтамж улсын хэмжээнд нэлээд бага байгаа буюу 73 хувь нь огт очдоггүй эсвэл жилд нэг, хоёр удаа л очдог байна. Харин байршлаар энэ үзүүлэлтийг судлахад хот суурин газарт шашны байгууллага,

сүм хийдэд очих давтамж илүү өндөр байна. Харин энэ нь шашны байгууллага, сүм хийдийн байршил ойр байгаатай холбоотой эсэхийг энэ өгөгдлөөс тодорхойлох боломжгүй байлаа.

ХҮСНЭГТ 5.11 2004 онд шашны байгууллага, сүм хийдэд очсон давтамж, байршлаар

Давтамж	Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Нийт
Очоогүй	0.2446	0.2467	0.3235	0.3963	0.3088
Нэг/хоёр удаа	0.3936	0.4193	0.4683	0.3924	0.4188
Улиралд нэг орчим	0.1771	0.1554	0.1276	0.0929	0.136
Сар тутам	0.0959	0.1053	0.0383	0.0657	0.0734
Сард нэгээс илүү	0.0889	0.0733	0.0423	0.0527	0.063
Нийт	1	1	1	1	1

Жич: Баганын хувь

Хэн нэгэнд худлаа хэлэх шаардлагатай чухал шалтгаан байдаг уу? гэж асуухад (q34) малчид, ажилгүйчүүд илүү үнэнч байх хандлагатай байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч бизнес эзэмшигчид хамгийн үнэнч бус ба цалин хөлстэй ажиллагсад дунд зэргийн үзүүлэлттэй байна. Энэ асуултанд албан болон албан бус секторт бизнес эзэмшигчид онцын их ялгаагүй хариулт өгсөн байна. Боломж олдвол хэн нэгнийг өөрсдийн эрх ашигт ашиглах уу, эсвэл шударга хандах уу гэсэн хүний шинж

чанартай холбоотой асуултад (q35) дээрхтэй төстэй хариултуудыг өгсөн байв. Шударга байдлын талаар асуухдаа тийм/үгүй гэсэн хариултыг авсан тул хариулагчдын бүлгүүдээс өгсөн хариултуудад ихээхэн ялгаатай байдал ажиглагдав. Үүнд малчдын 73 хувь нь хүмүүсийг шударга ханддаг гэж үзсэн байхад албан болон албан бус секторт хувиараа бизнес эрхлэгчдийн 42, 49 хувь л ийм хариултыг тус бүр өгсөн.

ХҮСНЭГТ 5.12 Худлаа хэлэх шалтгаан, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Санал бүрэн нийлж байна	Бага зэрэг	Итгэлтэй бус	Бага зэрэг нийлэхгүй	Санал огт нийлэхгүй	Нийт
албан бус	.1563	.3707	.1782	.1345	.1603	1
МАА	.0815	.2672	.1573	.149	.345	1
албан	.1739	.3735	.1424	.1228	.1874	1
хөлсний	.1166	.3958	.1573	.1247	.2057	1
ажилгүй	.0812	.2221	.2612	.1236	.3119	1
Нийт	.1122	.3268	.1802	.1327	.2481	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.13 Шударга байдал, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	бусдыг ашиглана	шударга хандана	нийт
албан бус	.5119	.4881	1
МАА	.2694	.7306	1
албан	.5812	.4188	1
хөлсний	.4655	.5345	1
ажилгүй	.2828	.7172	1
Нийт	.3983	.6017	1

Жич: мөрөн дэх хувь

Эрсдэлд хандах хандлагын талаар асуухад малчид хамгийн эрсдэл хүлээх сонирхолтой нь дараахь хоёр хэмжүүрээр харагдлаа. Үүнд 1) эрсдэлтэй сугалаанд оролцон мөнгө төлөх тэдний сонирхол бусад бүлэгтэй харьцуулахад үлэмж их байсан, 2) эрсдэлтэй сугалаа (Хүснэгт 5.15 дахь А тоглоом), эрсдэл багатай сугалаа (Б тоглоом)-аас сонгуулахад малчид эрсдэлтэйг нь сонгох илүү магадлалтай байлаа. Бусад бүлгийн хувьд энэ талаар нэг их статистикийн хувьд нөлөөтэй ялгаа гарсангүй. Бусад бүлгээ бодвол малчид өөрсдийгөө эрсдэлтэй алхам илүү хийдэг гэж үздэг нь үнэн байж болзошгүй (q46).

ХҮСНЭГТ 5.14 Асуулт 42-ын дагуу тоглоом тоглох сонирхол, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдал	Тоглоомыг тоглох сонирхол (төгрөг)	Өрхийн орлого
албан бус	1816	1563116
малчид	2519	864889
албан	2046	2637707
цалин хөлстэй ажил.	1900	1481592
ажилгүйчүүд	1348	413549

ХҮСНЭГТ 5.15 Тоглоомын сонголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	А тоглоом	В тоглоом	Нийт
албан бус	.3652	.6348	1
малчид	.4509	.5491	1
албан	.3757	.6243	1
цалин хөлстэй	.4196	.5804	1
ажилгүй	.39	.61	1
Нийт	.4084	.5916	1

Жич: А тоглоом нь илүү эрсдэлтэй

Хүснэгт 5.16 Бусадтай харьцуулахад өөрсдийгөө илүү эрсдэл хүлээх сонирхолтой гэж үздэг хандлага, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	бага сонирхолтой	тэнцүү	илүү сонирхолтой	Нийт
албан бус	.4169	.4918	.0913	1
малчид	.37	.4754	.1546	1
албан	.4018	.5053	.0929	1
цалин хөлстэй	.3952	.5075	.0973	1
ажилгүй	.5019	.401	.0971	1
Нийт	.4131	.477	.1099	1

Жич: мөрөн дэх хувь

Эцэст нь төр засгийн найдвартай байдал, үйлчилгээний ур чадварын талаар ямар хандлагатай байдгийг асууж, төрийн түшээдтэй харьцаж ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тохиолдож байсныг хариулагчдаас тодруулахаар нэмэлт асуулт асуусан. Эхний асуултаар (q40) “Төр засгийн зүгээс зөв зүйл хийнэ гэдэгт хэр итгэдэг вэ?” гэж асуусан бол хоёрдахь нь (q41) төрийн түшмэдийн зүгээс хариулагчдад шударга бус хандаж байсан тохиолдлын талаар асуусан. Эхний асуултад хариулсан дүнг Хүснэгт 5.17-д танилцуулсан ба бусад хандлага, байр суурийн талаарх асуултуудад хариулсан байдалтай ижил хэлбэрээр ажил эрхлэлтийн бүлгүүдийн дунд хариулт хэлбэлзэж байв. Ажилгүйчүүд төр

засгийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хамгийн их итгэж, тэдний дараагаар малчид ийнхүү үзэж байхад албан секторт бизнес эзэмшигчдийн итгэл их сул байна. Нийт хүн амын 60 хувь орчим нь төр засаг гол төлөв эсвэл дандаа зөв зүйл хийнэ гэдэгт итгэж, албан секторт 48 хувь, албан бус мал аж ахуйд 69 хувьтай тэнцэх хүртэл хэлбэлзэж байна. Дээрх асуултанд өгсөн хариултууд төрийн түшмэдтэй харьцсан байдал, улмаар түшмэд хэр хандсан талаарх хариулагчдын өгсөн мэдээлэлтэй нягт уялдаатай байв (Хүснэгт 5.18). Малчдын дөнгөж 19 хувь нь төрийн түшмэлийн шударга бус хандлагатай тулгарч байсан байхад албан секторт уг тоо 47 хувь байсан ба харин албан бус секторт 32 хувь болон буурсан байна.

Хүснэгт 5.17 Төр засагт итгэх итгэл, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Асуулт 40					Нийт
	Хэзээ ч үгүй	Ховорхон	Заримдаа	Олонхидоо	Дандаа	
албан бус	.0518	.1191	.3039	.355	.1702	1
МАА	.0246	.0457	.2411	.3563	.3322	1
албан	.0457	.139	.332	.3594	.124	1
хөлсний	.0545	.0863	.2802	.3753	.2037	1
ажилгүй	.0438	.0909	.2518	.3557	.2578	1
Нийт	.0444	.086	.2723	.3621	.2352	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.18 Төрийн түшмэд зохисгүй харьцсан байдал, ажил эрхлэлтийн байдлаар

Асуулт 41				
Ажил эрхлэлтийн байдал	Хэзээ ч үгүй	Нэг/хоёр удаа	Хоёроос олон	Нийт
албан бус	.6847	.2232	.0921	1
МАА	.8114	.1443	.0443	1
албан	.5291	.3232	.1477	1
хөлсний	.6526	.262	.0855	1
ажилгүй	.7394	.1932	.0674	1
Нийт	.7113	.2134	.0753	1

Жич: мөрөн дэх хувь

Албан бус секторын эдийн засгийн ажил эрхлэлтийн байдлын хувьд тархсан байдал

Судалгааны дүнг тархаахад 2004 оны 9-р сарын байдлаар нийт 285,808 өрх хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олсон байна. Үүний хамгийн том хэсэг буюу 140,383 нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй өрх ба дараагаар нь хэмжээгээрээ мал аж ахуйгаас бусад албан бус сектор орж байхад сүүлд нь харьцангуй жижиг албан сектор орж байна. Бүс нутаг (Хүснэгт 5.20), байршлаар (Хүснэгт 5.21) авч үзэхэд Улаанбаатар хот, Хангай болон төвийн бүсийн аймгийн төвүүдэд албан секторын ихэнх хэсэг ногдож байна.

ХҮСНЭГТ 5.19 Хувиараа хөдөлмөр эрхэлж буй өрхийн тоо, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Өрхийн тоо
албан бус	130.539
МАА	140.383
албан	14.886
Нийт	285.808

Дээрх тоо нь хувиараа эрхлэх үндсэн үйл ажиллагаан дээр тулгуурласан

ХҮСНЭГТ 5.20 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн тоо, бүс нутаг, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдал				
Бүс	албан бус	МАА	албан	Нийт
Баруун	14.686	36.655	883	52.224
Хангай	29.445	52.106	3.925	85.476
Төв	20.195	32.999	2.499	55.693
Зүүн	3.822	16.134	95	20.050
Улаанбаатар	62.390	2.489	7.485	72.364
Нийт	130,539	140,383	14,886	285,808

Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхүүдийн эзлэх хувь, түүнчлэн уг хувийг бүс нутаг, байршилын түвшингээр дор үзүүлэв. ҮСГ-аас мөрдөж буй ангиллын дагуу тооцоход улсын хэмжээнд албан бус сектор 46 хувь, албан бус сектор дахь мал аж ахуйн салбар 49 хувьтай тэнцүү байхад албан секторт хувиараа хөдөлмөр эрхлэгч өрх 5 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.21 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхүүдийн тоо, байршил, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдал				
Байршил	албан бус	МАА	албан	Нийт
Улаанбаатар	62.390	2.489	7.485	72.364
Аймгийн төв	35.265	3.346	4.434	43.044
Сумын төв	25.924	7.201	2.418	35.543
Хөдөө	6.960	127.347	550	134.856
Нийт	130.539	140.383	14.886	285.808

ХҮСНЭГТ 5.22 Улсын түвшинд хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн тоо, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.456736	0.011041
МАА	0.491180	0.011813
албан	0.052084	0.002759
Нийт	1.000000	

ХҮСНЭГТ 5.23 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн бүс нутгийн дагуу тархалт, ажил эрхлэлтийн байдлаар

<u>бүс= Баруун</u>		
АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.281215	0.021793
МАА	0.701879	0.022416
албан	0.016906	0.002700
<u>бүс=Хангай</u>		
АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.344483	0.022003
МАА	0.609598	0.023356
албан	0.045919	0.005748
<u>бүс=Төв</u>		
АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.362619	0.022102
МАА	0.592518	0.023412
албан	0.044862	0.006587
<u>бүс=Зүүн</u>		
АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.190609	0.021729
МАА	0.804656	0.022008
албан	0.004735	0.002391

бүс=Улаанбаатар

АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.862171	0.006568
МАА	0.034401	0.003595
албан	0.103429	0.005747

ХҮСНЭГТ 5.24 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн байршлын дагуу тархалт, ажил эрхлэлтийн байдлаар

байршил=Аймгийн төв

АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.819266	0.007743
МАА	0.077723	0.005536
албан	0.103012	0.006032

байршил=Сумын төв

АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.729372	0.027167
МАА	0.202612	0.025695
албан	0.068016	0.011710

байршил=Хөдөө

АЭ-н байдал	Тооцсон хувь	Ст. алдаа
албан бус	0.051607	0.009274
МАА	0.944316	0.009585
албан	0.004077	0.002532

Албан бус секторын сүүдрийн эдийн засгийн ЭЗҮАОУСА-ын дагуу салбарын тархалт

Энэ хэсэгт эдийн засгийн салбарын олон улсын ангиллын дагуу эдийн засгийн үйл ажиллагаа хэрхэн тархсан байдлыг дэлгэрүүлэн авч үзнэ. Албан секторын тоо мэдээллийг харьцуулах зорилгоор оруулсан ба улсын, бүсийн болон байршлын түвшинд тархсан байдлын хүснэгтүүдийг ЭЗҮАОУСА-ын нэг оронгийн түвшинд харуулсан болно. Улсын түвшинд үзүүлэлтүүдийг хоёр хэлбэрээр хооронд нь харьцуулан тооцсоныг танилцуулж байгаа ба эхнийх

нь ЭЗҮАОУСА тус бүрээр үйл ажиллагааны эзлэх хувийг ажил эрхлэлтийн байдлаар, хоёрдахь нь албан бус секторын хүрээнд эзлэх хувийн жинг үзүүлсэн болно. Ингэснээр албан болон албан бус секторын харьцангуй хэмжээг илүү тодорхой харах боломжтой.

Хүснэгт 5.25-ын эхний хэсгээс үзэхэд бөөний болон жижиглэнгийн худалдаа, засвар үйлчилгээг багтаасан худалдааны үйл ажиллагаа нь албан болон албан бус сектор дахь нийт эдийн засгийн үйл ажиллагааны 50 хувийг бүрдүүлж байна. Хүснэгт 5.25-ын хоёрдугаар хэсэг худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа өрхүүдийн 90 хувь нь албан бус секторт хамрагдаж байгааг харуулж байна.

ЭЗҮАОУСА-ын гурван оронгийн түвшинд худалдааны үйл ажиллагаанд нарийн дүн шинжилгээ хийвэл албан болон албан бус секторт үйл ажиллагааны харьцангуй төрөлжилт ажиглагдаж байгааг Хүснэгт 5.26-аас харж болно. Дэлгүүрийн бус үүргийн худалдаа эрхлэхэд албан бус үйл ажиллагаа хамгийн их хэмжээтэй байгаа (ЭЗҮАОУСА 525, 39 хувь) ба төрөл бүрийн барааны дэлгүүрийн худалдаа (ЭЗҮАОУСА 521, 19.5 хувь) дэлгүүрийн хүнс, ундаа, тамхины худалдаа (ЭЗҮАОУСА 522, 16.5 хувь) дараа дараачийн байранд орж байна. Албан секторын үйл

ажиллагааны худалдааны салбар дахь тархалт харьцангуй жигд ба дөрвөн дэд салбар тус бүрт нийт аж ахуйн нэгжийн наад зах нь 15 хувь ногдож байна. Эдгээр дэд салбаруудад хүнс, архи пиво, тамхины төрөлжсөн дэлгүүрүүд (ЭЗҮАОУСА 522, 33.2 хувь), төрөлжөөгүй үүргийн худалдаа (ЭЗҮАОУСА 521, 22.9 хувь), дэлгүүрийн бус үүргийн худалдаа (ЭЗҮАОУСА 525, 16.5 хувь) болон шинэ төрлийн бүтээгдэхүүний бусад төрөлжсөн худалдаа (ЭЗҮАОУСА 523, 15.0 хувь) орж байна.

Худалдааны албан болон албан бус секторт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувь хэмжээ ойролцоо байгаа ч албан бус секторт боловсруулах үйлдвэрлэл, (ЭЗҮАОУСА D, 20.4 хувь – албан бус секторт 10.4) тээвэр, агуулах, харилцаа холбоо (ЭЗҮАОУСА I, 11.4 хувь – албан секторт 5.3 хувь)-ны бизнесийн үйл ажиллагааны илүү төвлөрсөн байдал ажиглагдаж байна. Албан секторын үйл ажиллагаа зочид буудал, зоогийн газрын салбарт нилээд өндөр хэмжээтэй байна (ЭЗҮАОУСА H, албан бус сектор 4.5 хувь - албан сектор 10.8 хувь). Үйл ажиллагааны хувь хэмжээг үзүүлсэн доорхи хүснэгтүүдийн дараа Хүснэгт 5.27-д улсын хэмжээнд аж ахуйн нэгжийн тоог ЭЗҮАОУСА-ын дагуу тооцсоныг харуулсан болно.

ХҮСНЭГТ 5.25 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн салбарын дагуу тархалт, ажил эрхлэлтийн байдлаар

Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн салбарын дагуу тархалт - салбаруудаар				
ЭЗҮАОУСА	албан бус	МАА	албан	Нийт
ХАА	0.0441	1	0.0616	0.5145
Загас агнуур	5.30E-04	0	0	2.40E-04
Уул уурхай	0.0092	0	0.0039	0.0044
Боловсруулах үйлдвэрлэл	0.2044	0	0.1037	0.0987
Цахилгаан, хий	0.0019	0	0.0023	9.70E-04
Барилга	0.0219	0	0.0216	0.0111
Худалдаа	0.4994	0	0.5004	0.2542
Зочид буудал, зоогийн газар	0.0449	0	0.1077	0.0261
Тээвэр	0.114	0	0.0527	0.0548
Санхүү	0.0031	0	0.0296	0.003
Үл хөдлөх хөрөнгө	0.0106	0	0.0199	0.0059
Боловсрол	0.0021	0	0.0138	0.0017
Эрүүл мэнд	0.0042	0	0.0389	0.004
Бусад, нийтийн аж ахуй	0.0382	0	0.0439	0.0197
Хувийн орон сууц	0.0016	0	0	7.30E-04
Нийт	1	1	1	1

Жич: багана дахь хувь

ХҮСНЭГТ 5.25 –ын үргэлжлэл

Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн салбарын дагуу тархалт - ЭЗҮАОУСА-н салбар дотор				
ЭЗҮАОУСА	албан бус	МАА	албан	Нийт
ХАА	0.0391	0.9546	0.0062	1
Загас агнуур	1	0	0	1
Уул уурхай	0.9541	0	0.0459	1
Боловсруулах үйлдвэрлэл	0.9453	0	0.0547	1
Цахилгаан, хий	0.8795	0	0.1205	1
Барилга	0.899	0	0.101	1
Худалдаа	0.8975	0	0.1025	1
Зочид буудал, зоогийн газар	0.785	0	0.215	1
Тээвэр	0.9499	0	0.0501	1
Санхүү	0.4786	0	0.5214	1
Үл хөдлөх хөрөнгө	0.8232	0	0.1768	1
Боловсрол	0.5735	0	0.4265	1
Эрүүл мэнд	0.4889	0	0.5111	1
Бусад, нийтийн аж ахуй	0.8841	0	0.1159	1
Хувийн орон сууц	1	0	0	1
Нийт	0.4567	0.4912	0.0521	1

Жич: багана дахь хувь

ХҮСНЭГТ 5.26 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн худалдааны салбарын ЭЗҮАОУСА-ын дагуу тархалт, ажил эрхлэлтийн байдлаар

ЭЗҮАОУСАЗ	албан бус	албан	Нийт
501	0.0036	0.0118	0.0044
502	0.033	0.0214	0.0318
503	0.0054	0.0097	0.0059
504	0.0034	0.0036	0.0034
505	0.0024	0.0182	0.004
511	2.20E-04	0	2.00E-04
512	0.0609	0.0319	0.0579
513	0.0037	0	0.0033
514	0.0047	0.0028	0.0045
515	0.003	0.0041	0.0031
519	0.0031	0	0.0027
521	0.1947	0.2289	0.1982
522	0.1649	0.3327	0.1821
523	0.0766	0.1505	0.0842
524	0.0178	0.0071	0.0167
525	0.3853	0.1645	0.3626
526	0.0373	0.0126	0.0348
Нийт	1	1	1

Жич: багана дахь хувь

ХҮСНЭГТ 5.27 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхүүдийн тоо, салбар, ажил эрхлэлтийн байдлаар

ЭЗҮАОУСА	албан		албан	Нийт
	бус	МАА		
ХАА	5.756	140.383	917	147.056
Загас агнуур	69			69
Уул уурхай	1.197		58	1.254
Боловсруулах үйлдвэрлэл	26.679		1.543	28.222
Цахилгаан, хий	245		34	278
Барилга	2.862		322	3.184
Худалдаа	65.191		7.449	72.640
Зочид бууд., зоог. газар	5.855		1.604	7.459
Тээвэр	14.880		785	15.665
Санхүү	404		440	845
Үл хөдлөх хөрөнгө	1.380		296	1.676
Боловсрол	277		206	483
Эрүүл мэнд	554		580	1.134
Бусад, нийтийн аж ахуй	4.982		653	5.635
Хувийн орон сууц	208			208
Нийт	130.539	140.383	14.886	285,808

Аж ахуйн нэгжийн хэмжээ

Албан сектор дахь бизнесийн үйл ажиллагааны хэмжээ мал аж ахуй болон албан бус сектор дахь бизнесийнхтэй харьцуулахад илүү их байгааг Хүснэгт 5.28-аас харж болно.

ХҮСНЭГТ 5.28 Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн аж ахуйн дундаж хэмжээ ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Ажиллагсдын тоо
албан бус	2.30
МАА	2.91
албан	4.86
Нийт	2.74

ХҮСНЭГТ 5.29 Ажиллагсдын тоо, ажилласан дундаж цаг зарцуулалт, ажил эрхлэлтийн байдлаар

Албан бус, дундаж	Тооцоо	Ст. Алдаа	[95% итгэмж. зааг]		D эффект
Өрхийн цалин хөлстэй ажиллагсад	0.033711	0.0045782	0.0247362	0.0426861	1.219944
Өрхийн бус цалин хөлстэй ажиллагсад	0.200954	0.0124409	0.1765651	0.225343	1.059259
Өрхийн цалингүй ажиллагсад	0.421403	0.0170331	0.3880119	0.454795	1.465887
Ажиллагсдын дундаж ажилласан цаг	44.58037	0.7320086	43.1448	46.01593	1.542626
(*) Зарим хувьсагчдын хувьд орхигдсон өгөгдөл байгаа					
Мал аж ахуй, дундаж	Тооцоо	Ст. Алдаа	[95% итгэмж. зааг]		D эффект
Өрхийн цалин хөлстэй ажиллагсад	0.007388	0.0035662	0.0003902	0.0143851	1.054602
Өрхийн бус цалин хөлстэй ажиллагсад	0.048415	0.0083038	0.0321212	0.0647077	0.7777277
Өрхийн цалингүй ажиллагсад	1.116973	0.0528095	1.013353	1.220593	1.507635
Ажиллагсдын дундаж ажилласан цаг	35.29553	1.882405	31.59908	38.99198	1.889963
(*) Зарим хувьсагчдын хувьд орхигдсон өгөгдөл байгаа					
Албан, дундаж	Тооцоо	Ст. Алдаа	[95% итгэмж. зааг]		D эффект
Өрхийн цалин хөлстэй ажиллагсад	0.076218	0.0170619	0.042714	0.1097223	1.566104
Өрхийн бус цалин хөлстэй ажиллагсад	1.99694	0.2273022	1.550591	2.44329	0.9472176
Өрхийн цалингүй ажиллагсад	0.467783	0.0837656	0.3032942	0.6322725	0.8699874
Ажиллагсдын дундаж ажилласан цаг	49.49582	1.312898	46.91419	52.07745	1.143062

Төлбөрийн хэлбэр

Хүснэгт 5.29-т өрхийн ажиллагсдын цалин урамшууллын талаарх мэдээллийг харуулж байна. Албан бус секторт аль ч төрлийн бизнесийн хувьд өрхийн гишүүд цалин хөлстэй ажиллах нь ховор, харин цалин хөлстэй ажиллагсад албан секторт

түгээмэл байгаа нь санаандгүй үр дүн биш.³³ Өрхийн бизнест цалин хөлстэй оролцогчийг ажиллуулах түвшин албан бус мал аж ахуй болон албан салбарт ойролцоо түвшинд байгаа хэдий ч мал аж ахуйд цалин хөлстэй ажилтнууд гол төрлийн ажиллагсад болж байна. Албан салбарт

³³ Энд тухайлбал .03 гэсэн тоо нь зуун өрхийн гурав нь тухайн төрлийн ажиллагсадтай болохыг илтгэнэ.

ажиллагсад илүү ажиллаж, илүү цалин авч байна. Судалгаа авахаас өмнөх долоо хоногт ажилласан дундаж цаг албан бус байдлаас албанд шилжихэд өсч гарч байна (q98). Дунджаар мал аж ахуйн салбарт ажиллагсад 36 цаг, албан бус секторт ажиллагсад 46 цаг, албан секторт ажиллагсад 50 цаг ажиллажээ. Хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүнийг тооцсоноо Хүснэгт 5.30-д

танилцуулсан ба энэ нь нэмэлт нэг цагаар ажилтныг хөлслөн ажиллуулахад шаардлагатай мөнгөний дүн юм. Энэ хөлс малчдын хувьд ихээхэн бага (47 төгрөг) байхад албан бус секторт ажиллагсдын хувьд 387 төгрөг, албан секторт ажиллагсдын хувьд 666 төгрөгийн хэмжээнд хувьсаж байна.

ХҮСНЭГТ 5.30 Ажиллагсдын нэмэлт нэг цагийн өртөг, ажил эрхлэлтийн байдлаар

Нэмэлт цагийн өртөг	Тооцоо	Ст. Алдаа	[95% итгэмж. зааг]		D эффект
албан бус	386.54	33.77216	320.2695	452.8118	1.05095
МАА	47.33	25.31557	-2.343736	97.00982	2.794927
албан	666.18	137.6798	396.0176	936.356	1.110463

Ажилласан хугацаа

Албан бус болон албан секторын бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан цаг хоорондоо нэг их ялгаагүй байгаа ч аль алиных нь хувьд ихээхэн хугацаагаар буюу жилд 2-3 сар бизнесийн үйл ажиллагаандаа завсарлагаа авдаг дүн гарлаа. Малчид сард ажилладаг хоног (сард 29 хоног, 9-р сарын байдлаар) болон жилд ажилладаг сарын тоогоор (жилд 11.5 сар) хамгийн их ажилладаг байна.

Эвлэлдэн нэгдэх үйл ажиллагаа

Хувийн хэвшилд нэгдмэл үйл ажиллагаа олон тохиолдолд бизнесийн хоршоодоор дэмжигдэн хэрэгждэг. Судалгаанд хариулагчдын 98 гаруй хувь аливаа бизнес холбоонд хамрагдаагүй байгаа нь Монголд эвлэлдэн нэгдэх явдал доогуур түвшинд байгааг харуулж байна. Албан секторт энэ үзүүлэлт харьцангуй өндөр буюу ойролцоогоор нийт бизнесийн 8 хувь нь холбоодын гишүүн байхад албан бус секторт 2 хүрэхгүй хувьтай байна. Холбоодын хүч чадлын хувьд салбаруудаар тодорхой хэмжээнд харилцан адилгүй байна. Тухайлбал, албан бус секторт санхүүгийн болон боловсролын үйлчилгээ үзүүлэгчдийн дунд эвлэлдэн нэгдэх явдал харьцангуй өндөр (тус бүр 16 ба 9 хувь) байна. Албан секторт уул уурхай (38 хувь), барилга (29 хувь), боловсруулах үйлдвэрлэл (18 хувь), үл хөдлөх хөрөнгө (18 хувь) зэрэг салбар эвлэлдэн нэгдэх хувь өндөр байна. Аливаа холбооны гишүүдийн дийлэнх нь (67 хувь) холбооны татвар хураамжаа төлдөг байна. Албан болон албан бус сектороос хамааран татвар хураамж төлөлтийн хувь хэмжээнд ялгаа ажиглагдаж байгаа ба уг хэмжээ мал аж ахуйн салбарт 22 хувь, албан бус секторт 69 хувь, албан секторт 88 хувь байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 5.32 болон Хүснэгт 5.33-аас үзнэ үү.

ХҮСНЭГТ 5.31 Есдүгээр сар болон 2004 онд ажилласан хугацаа, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдал	9 сард ажилласан өдрийн тоо	Жилд ажилласан сарын тоо
албан бус	23.06	9.15
МАА	28.85	11.55
албан	25.46	9.95
Нийт	26.03	10.37

ХҮСНЭГТ 5.32 Үйлдвэрчний эвлэл, холбоодын гишүүнчлэл ба оролцоо, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Холбооны гишүүн			АЭ-н байдал	Оролцсон/хураамж төлсөн		
	Тийм	Үгүй	Нийт		Тийм	Үгүй	Нийт
албан бус	0.0158	0.9842	1	албан бус	0.6913	0.3087	1
МАА	0.0067	0.9933	1	МАА	0.2157	0.7843	1
Албан	0.08	0.92	1	албан	0.8807	0.1193	1
Нийт	0.0147	0.9853	1	Нийт	0.6401	0.3599	1

Жич: багана дахь хувь

Жич: мөрөн дэх хувь

Хүснэгт 5.33 Үйлдвэрчний эвлэл, холбоодын гишүүнчлэл, эдийн засгийн салбараар

Мал аж ахуйн бус албан бус			
	Холбооны гишүүн		
	Тийм	Үгүй	Нийт
ЭЗҮАОУСА			
ХАА	0.009	0.991	1
Загас агнуур	0	1	1
Уул уурхай	0	1	1
Боловсруулах үйлдвэрлэл	0.0069	0.9931	1
Цахилгаан, хий	0	1	1
Барилга	0	1	1
Худалдаа	0.0174	0.9826	1
Зочид бууд., зоог. газар	0.0169	0.9831	1
Тээвэр	0.0159	0.9841	1
Санхүү	0.1551	0.8449	1
Үл хөдлөх хөрөнгө	0.0106	0.9894	1
Боловсрол	0.0925	0.9075	1
Эрүүл мэнд	0.0246	0.9754	1
Бусад, нийтийн аж ахуй	0.0419	0.9581	1
Хувийн орон сууц	0.1423	0.8577	1
Нийт	0.0158	0.9842	1

Жич: мөрөн дэх хувь

Албан			
	Холбооны гишүүн		
	Тийм	Үгүй	Нийт
ЭЗҮАОУСА			
ХАА	0.0508	0.9492	1
Уул уурхай	0.381	0.619	1
Боловсруулах үйлдвэрлэл	0.1818	0.8182	1
Цахилгаан, хий	0	1	1
Барилга	0.2924	0.7076	1
Худалдаа	0.0347	0.9653	1
Зочид бууд, зоог. газар	0.0994	0.9006	1
Тээвэр	0.0592	0.9408	1
Санхүү	0.1407	0.8593	1
Үл хөдлөх хөрөнгө	0.1846	0.8154	1
Боловсрол	0	1	1
Эрүүл мэнд	0.1637	0.8363	1
Бусад, нийтийн аж ахуй	0.1114	0.8886	1
Нийт	0.08	0.92	1

Бизнесийн албан ёсны байдал — бүртгэл хөтлөлт, байнгын ажлын байр, өмчлөлийн хэлбэр

Энэ хэсэг хүртэл танилцуулсан судалгааны дүнг тооцоход албан ёсны байдлыг хуулийн этгээд болон бүртгэгдсэн байдалтай холбон тодорхойлж ирсэн. Албан секторт мөрддөг бизнесийн үйл ажиллагааны туршлага, хэв маяг илрэх байдлаар албан бус секторт мөн үнэлгээ өгч болдог. Бичгэн хэлбэрээр данс бүртгэл хөтлөлт, байнгын ажлын

байр, өмчлөлийн хэлбэр зэрэг нь албан байдлыг бүртгэлийн дагуу болон дотор нь бид тодорхойлсноор албан бус секторын сүүдрийн үйл ажиллагааны мөн чанарыг судлах гурван арга зам юм (Дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 5.34, Хүснэгт 5.35, Хүснэгт 5.36-аас үзнэ үү).

Данс бүртгэл хөтлөх явдал албан ёсны бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдэд даруй хоёр дахин их байна (77 ба 36 хувь). Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг албан бус бизнесийн 49 хувь,

санхүү, зоогийн газар, зочид буудал эрхлэгчдийн тус бүр 86 ба 59 хувь нь данс бүртгэл хөтөлдөг байна. Албан бус секторын томоохон салбаруудаас боловсруулах аж үйлдвэр (20 хувь), тээвэр, агуулах, харилцаа холбоо (11 хувь), барилга (9 хувь) зэрэг салбарт данс бүртгэл хөтлөлт доогуур түвшинд байна.

Сонирхолтой нь гэртээ бизнесээ эрхлэх явдал албан (30 хувь) болон албан бус секторт (36 хувь) ойролцоо байна. Харин ажлын байр гэр орноос гадуур байхад албан бус секторт ажлын байрны төрөл нэлээд олон янзынх буюу 28 хувь нь байнгын дэлгүүрт албан бус бизнесээ эрхлэж байхад албан

секторт нийт 52 хувь нь ийм төрлийн ажлын байртай байна. Албан сектортой харьцуулахад албан бус секторын бизнес үйл ажиллагаа захын лангуу, машин тээврийн хэрэгсэл, бусад байнгын бус газарт явагдах магадлал нь даруй гурав дахин илүү байна.

Өмчийн хэлбэрийн хувьд албан болон албан бус секторт нэг их ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд тус бүр 64 болон 60 хувь нь ганц хүн дангаар эзэмшдэг байна. Мал аж ахуйн салбарын дөнгөж 43 хувь нь ганцаараа эзэмшдэг, харин 57 хувь нь гэр бүлээрээ өмчилж байна.

ХҮСНЭГТ 5.34 Өмчлөлийн хэлбэр, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Асуулт 93			
	Дангаар өмчилдөг	Гэр бүл дэх түнш	Гэр бүлийн бус түнш	Нийт
албан бус	0.6363	0.3017	0.062	1
МАА	0.4314	0.5646	0.0041	1
албан	0.611	0.2925	0.0965	1
Нийт	0.5343	0.4304	0.0353	1

Ажлын байр нь албан болон албан бус сектороор ялгагдах бас нэг үзүүлэлт байж болох ба ийм ялгааг албан бус худалдааны аж ахуйн нэгжийн 39 хувь нь байнгын дэлгүүрийн байршлаас гадуур байрладаг худалдааны салбарт ажигласнаа өмнө нь дурьдсан (ЭЗҮАОУСА 525).

ХҮСНЭГТ 5.35 Данс бүртгэл хөтөлсөн байдал, эдийн засгийн салбараар

АЭ-н байдал	Тийм	Үгүй	Нийт
албан бус	0.3578	0.6422	1
МАА	0.3238	0.6762	1
албан	0.7742	0.2258	1
Нийт	0.3628	0.6372	1

Жич: мөрөн дэх хувь

ЭЗҮАОУСА	Асуулт 106		
	Тийм	Үгүй	Нийт
ХАА	0.1327	0.8673	1
Загас агнуур	0	1	1
Уул уурхай	0.0638	0.9362	1
Боловсруулах үйлдвэрлэл	0.1958	0.8042	1
Цахилгаан, хий	0.5779	0.4221	1
Барилга	0.0905	0.9095	1
Худалдаа	0.4941	0.5059	1
Зочид бууд., зоог. газар	0.591	0.409	1
Тээвэр	0.1092	0.8908	1
Санхүү	0.8638	0.1362	1
Үл хөдлөх хөрөнгө	0.3627	0.6373	1
Боловсрол	0.427	0.573	1
Эрүүл мэнд	0.5548	0.4452	1
Бусад, нийтийн аж ахуй	0.3312	0.6688	1
Хувийн орон сууц	0.1324	0.8676	1
Нийт	0.3578	0.6422	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.36 Ажлын үндсэн байрны төрөл, ажил эрхлэлтийн байдлаар

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бүгд								
АЭ-н байдал	Гэр дэх дэлгүүр цех	Өрхөөс гадуур дэлг./цех	Зах дээрх лангуу	Байрлал тогтмол бус	Машин тээврийн хэрэгсэл	Зүлэг ил талбай	Бусад	Нийт
албан бус	0.3554	0.2765	0.1195	0.1229	0.0875	0.0369	0.0014	1
МАА	0.0728	0.0698	5.70E-04	0.0638	0.0014	0.7917	0	1
албан	0.2961	0.5173	0.0377	0.0565	0.0331	0.0574	0.0018	1
Нийт	0.2135	0.1875	0.0568	0.0904	0.0424	0.4087	7.10E-04	1

Жич: мөрөн дэх хувь

Санхүү

Бизнест амжилт олох нэг гол хүчин зүйл бол санхүүгийн эх үүсвэрийн асуудал. Энэ тайлангийн хүрээнд санхүүгийн эх үүсвэр, эхлэлийн хөрөнгийн санхүүжилт, албан бус секторын аж ахуйн нэгжийн зээл авдаг туршлагын талаар судаллаа. Хүснэгт 5.37-д эхлэлийн хөрөнгийн эх үүсвэрийг харуулав. Үүнээс харахад хөрөнгийн 66 хувиас (албан секторын жижиг бизнес эрхлэгчид) 88 хүртэл (малчид) хувь нь өөрийн (эсвэл гэр

бүлийн) эх үүсвэрээс гардаг байна. Бусад хэсэг нь бусад боломжит эх үүсвэрүүдээс гардаг ба банк, хувиараа мөнгө зээлдэгчид, найз нөхөд зэрэг эх үүсвэрүүд ойролцоо хувьтай байна. Гэвч Хүснэгт 5.40-өөс үзэхэд албан бус бизнес эрхлэгчдийн наймны нэг нь л (13 хувь) зээл авсан байхад албан салбарт энэ үзүүлэлт дөрөвний нэг орчим (27 хувь) байна. Харин энэ хүснэгтээс харахад нэгэнт зээл авсан бол дахин зээл авах явдал эрс нэмэгдэх хандлагатай байгаа нь таатай мэдээ байж болох юм.

ХҮСНЭГТ 5.37 Бизнесийн эхлэлийн хөрөнгийн эх үүсвэр, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Гэр бүлийн/ хувийн хадгаламж	Найз нөхөд	Мөнгө зээлдүүлэгч	Хоршоо	Банк	Бусад	Нийт
албан бус	0.7591	0.0702	0.0613	0.0136	0.0725	0.0233	1
МАА	0.8813	0.0134	5.60E-04	0.0049	0.0093	0.0906	1
албан	0.6373	0.0639	0.1029	0.0347	0.1431	0.0181	1
Нийт	0.8128	0.042	0.0336	0.0104	0.0452	0.0561	1

Жич: мөрөн дэх хувь

Банкны зээлийг бизнес эхлүүлэх зорилгоор бус харин үйл ажиллагаагаа өргөтгөх, үргэлжлүүлэн явуулахад хөрөнгө оруулалт хийх чиглэлээр илүү авдаг байна. Сүүлийн 12 сард зээл авсан аж ахуйн нэгж 9 хувийг эзэлж байгаагаас банкнаас зээл авах явдал 63 хувь буюу хамгийн их

хэмжээтэй, дараагаар нь мөнгө зээлдэгчид, гэр бүл/найз нөхдөөсөө авсан тохиолдол (15 хувь) орж байна. Банкнаас зээл авах явдал малчдын хувьд хамгийн элбэг тохиолддог буюу 86 хувь нь хөрөнгийн эх үүсвэрээ банкнаас авдаг гэж дурьдсан байна. Энэ үзүүлэлт албан бус секторт 54 хувь, албан секторт 71 хувьтай тэнцүү байна.

ХҮСНЭГТ 5.38 Сүүлийн 12 сард оруулсан хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Гэр бүл/ найз	Хоршоо	Ломбард	Банк	Нийлүү- лэгч	Хэрэг- лэгч	Мөнгө зээлдүүлэгч	Бусад	Нийт
албан бус	0.1969	0.0464	0.0206	0.539	0.0114	0.0058	0.1731	0.0068	1
МАА	0.0131	0.0077	0	0.8644	0	0	0.1051	0.0096	1
албан	0.1571	0.0263	0.0083	0.7068	0.0055	0	0.0905	0.0055	1
Нийт	0.1523	0.0354	0.0145	0.6318	0.0082	0.0037	0.1469	0.0072	1

Жич: мөрөн дэх хувь

Тухайн бизнес хэр зэрэг удаан үйл ажиллагаа явуулж байгаагаас шалтгаалан хөрөнгийн эх үүсвэр, тэр дотроо эхлэлийн болон үргэлжилсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр нилээд ялгаатай байна.

Хүснэгт 5.39-т үзүүлсэнээр удаан жил үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд найз нөхөд болон гэр бүлээсээ мөнгө авч бизнесээ эхлүүлсэн байх магадлал илүү өндөр бахарин одоо банкны зээл авах хандлага илүү байна. Эдгээр хүчин зүйлс, мөн дор дурьдсанчлан зээлийн барьцаанд тавих шаардлагад нааштай чиг хандлага

ажиглагдаж байгаа зэргийг харгалзан үзэхэд сүүлийн жилүүдэд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бизнесийг санхүүжүүлэхэд ахиц гарч байна. Гэхдээ бизнесээ эхлүүлэхээс бусад зорилгоор зээл авч байгаа хүмүүс нийт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн багахан хувь болохыг санах хэрэгтэй. Үлдэж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд зээл авах явдал хязгаарлагдмал байгаагийн үр нөлөөний талаар 5.3-р хэсэгт албан бус үйл ажиллагааны нийгмийн болон эдийн засгийн үр дагаврын талаар авч үзэхэд өгүүлнэ.

ХҮСНЭГТ 5.39 Санхүүгийн эх үүсвэр, бизнес эрхэлсэн хугацаагаар

Асуулт 141							
Бизнесийн нас	Мөнгө						
	Гэр бүл	Найз	зээлдүүлэгч	Хоршоо	Банк	Бусад	Нийт
1.5	0.7185	0.0733	0.0842	0.0194	0.0721	0.0326	1
3	0.7578	0.0706	0.0713	0.0087	0.071	0.0206	1
5	0.7933	0.0505	0.0501	0.0174	0.0612	0.0275	1
9	0.8282	0.0397	0.0272	0.0149	0.0519	0.0381	1
80	0.8561	0.0226	0.0052	0.0035	0.0213	0.0913	1
Нийт	0.8128	0.0419	0.0336	0.0104	0.0452	0.0561	1

Жич: мөрөн дэх хувь

Асуулт 146								
Бизнесийн нас	Мөнгө			Нийлүү- лэгч	Хэрэг- лэгч	Мөнгө		Нийт
	Гэр бүл найз	Ломбард	Банк			зээлдүүлэгч	Бусад	
1.5	0.2137	0.0257	0.5248	0.0059	0.0039	0.1558	0.0085	1
3	0.1696	0.0318	0.6418	0	0	0.1271	0	1
5	0.1442	0.011	0.5347	0.0175	0.0152	0.2392	0.0029	1
9	0.1735	0.0121	0.615	0.0082	0	0.1485	0.008	1
80	0.0942	0.003	0.7811	0.0067	0	0.0775	0.0134	1
Нийт	0.1525	0.0145	0.6314	0.0082	0.0037	0.1471	0.0072	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.40 Өмнө нь зээл авч байсан байдал, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Хэзээ ч үгүй	Тийм, 2001 оноос өмнө	Тийм, 2001/2002	Тийм, 2003/2004	Нийт
албан бус	0.8105	0.0303	0.025	0.1341	1
МАА	0.891	0.0194	0.0146	0.075	1
албан	0.6544	0.0321	0.0487	0.2648	1
Нийт	0.8442	0.0249	0.0208	0.1101	1

Жич: мөрөн дэх хувь

Хүснэгт 5.41-д зээлийн хэмжээг шаардлагатай барьцаанд эзлэх хувиар харуулсан бөгөөд хэмжээ нь өндөр байвал шаардлагатай барьцааны хэмжээ бага байна гэсэн үг. Эндээс үзэхэд барьцааны шаардлагатай хэмжээ зээлийн хэмжээнээсээ даруй 2-3 дахин өндөр байна. Арилжааны хуулийн дагуух институциудын хөгжил Монголын түвшинд байгаа улс орнуудад энэ нь түгээмэл үзэгдэл боловч бизнесийн зээл

авагчдын нуруун дээр хэвийн бус эрсдэлийг тохож байдгаас гадна эрсдэлийг төрөлжүүлэх, саармагжуулах зуучлагчийн үүргээ санхүүгийн тогтолцоо гүйцэтгэж чадахгүй байгааг харуулж байна. Түүнчлэн албан секторт зээлийн барьцааны шаардлага ихсэх хандлагатай, харин мал аж ахуйн бус албан бус секторт буурсан буюу тогтвортой түвшинд байгаа нь ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 5.41 Зээлийн хэмжээ шаардагдах барьцааны хэмжээнд эзлэх хувь, жил, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	2001 оноос өмнө	Зээл авсан жил	
		2001/2002	2003/2004
албан бус	43.7387	32.6525	40.9475
МАА	39.0447	35.2796	35.3053
албан	62.5321	41.2808	36.9984
Нийт	41.8424	34.4225	38.6747

Хүснэгт 5.42-оос үзэхэд 2001-2004 оны хугацаанд албан бус секторын бүх салбарт зээлийн барьцааны хэмжээ буурсан байна. Харин тээвэр, агуулах, харилцаа холбоо (9) болон бусад нийтийн аж ахуйн, нийгмийн, хувийн үйл ажиллагаанд (15) энэ бууралт ажиглагдсангүй. Албан бус сектор дотроо хамгийн их хэмжээний барьцаа шаарддаг салбарт уул уурхай орж байна (Хүснэгт 5.42-т хамгийн бага утгатай тоо). Гэвч энэ талаар олон жилийн тоо мэдээ байхгүй тул чиг хандлагыг тодорхойлж чадсангүй.

ХҮСНЭГТ 5.42 Мал аж ахуйн бус албан бус сектор дахь барьцааны хэмжээнд эзлэх хувиар тооцсон зээлийн хэмжээний хандлага, жил, ЭЗҮАОУСА-аар

ЭЗҮАОУСА	2001 оноос өмнө	2001/2002	2003/2004
ХАА		33.0865	40.5803
Уул уурхай			26.1559
Боловсруулах үйлдвэрлэл	34.616	29.5016	44.2032
Барилга	30	30	39.6555
Худалдаа	26.9576	32.7285	41.483
Зочид бууд., зоог. газар	50	31.0859	43.6439
Тээвэр, агуулах		41.4979	37.8039
Санхүү		45	57.8593

ХҮСНЭГТ 5.42 –ын үргэлжлэл

Үл хөдлөх хөрөнгө			37.4069
Боловсрол			
Эрүүл мэнд			50.4558
Бусад, нийтийн аж ахуй		39.9917	39.4215
Нийт	32.2665	33.3835	41.7037

Жич: мөрөн дэх хувь

Маргаан зөрчлийг шийдвэрлэх нь

Хүснэгт 5.43 болон Хүснэгт 5.44-т албан бус сектор улс орны хууль эрх зүйн орчин, институциудад хандаж, үйлчлүүлж буй талаар судлав. Хүснэгт 5.43-аас харахад Монголчуудын ихэнх нь (83 хувь) маргааныг зохицуулан шийдвэрлэх бусад арга үр дүнгээ өгөөгүй бол шүүхийн байгууллагад хандах сонирхолтойгоо илэрхийлсэн байна. Энэ сонирхол нь урьд шүүхэд хандаж маргаанаа шийдвэрлүүлж байсан хүмүүсийн хувьд ойролцоо (79 хувь) боловч уг бүлгийн хувьд шүүх тогтолцооны чадавхид үл итгэх байдал нэмэгдсэнийг Хүснэгт

5.44-өөс харж болно. Тухайлбал, шүүхэд хандсан иргэдийн 8 хувь нь нөгөө талынхан шүүгчдийг хахуульдаж магадгүй хэмээн сэрэмжилж байхад шүүхэд хандаж үзээгүй иргэдийн дөнгөж 2 хувь ингэж бодож байна. Шүүхэд урьд хандаж байсан иргэдийн дунд шүүх шударга ёсыг найдвартай сахиулдагт үл итгэх ерөнхий хандлага байгаа ба үүнийг шүүхэд хандахгүй байх шалтгаан гэж эдгээр иргэдийн 6 хувь нь мэдэгдсэн байна. Гэтэл шүүхэд урьд нь хандаж байгаагүй иргэдийн зөвхөн 1.5 хувь нь л ийм бодолтой байна.

ХҮСНЭГТ 5.43 Их хэмжээний хөрөнгөтэй холбоотой асуудлаар хариуцагч талыг шүүхэд өгөх хүсэл сонирхол, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Тийм	Үгүй, учир нь...					Нийт
		хариуцагч хахуульдана	шүүх их цаг авна	их зардалтай	шүүх найдваргүй	яаж гэдгийг мэдэхгүй	
албан бус	0.828	0.0274	0.018	0.0392	0.0263	0.0612	1
албан бус МАА	0.8307	0.0183	0.0187	0.0162	0.0059	0.1102	1
албан	0.8756	0.0117	0.0379	0.0256	0.0376	0.0116	1
Нийт	0.8318	0.0221	0.0194	0.0272	0.0168	0.0827	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.44 Их хэмжээний хөрөнгөтэй холбоотой асуудлаар хариуцагч талыг шүүхэд өгөх хүсэл сонирхол, шүүхэд урьд нь хандаж байсан байдлаар

Өмнө нь шүүхэд хандаж байсан байдал	Тийм	Үгүй, учир нь...					Нийт
		хариуцагч хахуульдана	шүүх их цаг авна	их зардалтай	шүүх найдваргүй	яаж гэдгийг мэдэхгүй	
Тийм	0.7927	0.0772	0.0195	0.0338	0.0603	0.0165	1
Үгүй	0.8336	0.0195	0.0194	0.0269	0.0148	0.0858	1
Нийт	0.8318	0.0221	0.0194	0.0272	0.0168	0.0827	1

Жич: мөрөн дэх хувь

5.2. АЛБАН БУС СЕКТОРТ ОРОЛЦОХ ШАЛТГААН

Сүүдрийн үйл ажиллагааны шалтгаануудыг ойлгож мэдэх үүднээс хувь хүний ба бизнесийн шинж чанарууд, итгэл үнэмшлийг бизнесийн орчинтой нь харилцан холбоотойгоор судалж үзлээ. Бидний олж мэдсэнээр хууль журмыг дагаж мөрдөхгүй байх ойлголт, ийм зан үйлдлийг хийснээ хүлээн зөвшөөрөх байдал хоёр аль аль нь нилээд бодитойгоор оршиж байна. Цаашилбал ингэж зөрчил гаргаснаар хүнд шийтгэл ногдохгүй гэж судалгаанд оролцогчдын дийлэнх олонх нь үзэж байна. Ямар нэг шалтгаанаар шүүхийн тогтолцоотой харьцаж үзсэн багахан бүлэг хүмүүсийн хувьд бизнесийн бүртгэлийн шаардлагуудыг дагаж мөрдөх явдал эрс дээшилсэн байна. Энэхүү тоо баримтаас үзэхэд албан секторт бүртгэлийн шаардлагыг биелүүлэх нь тодорхой хэмжээгээр банкны харилцаа тогтоох хүсэл эрмэлзлэлээс үүдэлтэй байдаг байна. Албан бус салбарын бизнесийн үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэр улам их болохын хэрээр ингэж бүртгүүлэх сонирхол буурч болох юм. Бид дор танилцуулсан судалгааны үр дүнг авч үзэхдээ дөрвөн чиглэлд голлон анхаарч байна. Эдгээр нь бүртгэлийн шаардлагуудыг төрөөс сахиулахтай холбоотой итгэл үнэмшил, бизнесийн зохицуулалтуудын үр нөлөө, мөн зохисгүй үйл ажиллагаанууд, түүний дотор татвараас зайлсхийх явдалтай холбоотой итгэл үнэмшил, зан байдлууд юм. Эндээс хууль журмыг даган мөрдөх үйл ажиллагаа, түүнээс үүдэх үр дагавруудыг үл ойшоох явдал их байгааг, түүнчлэн үл ойшоох

явдал болон итгэл үнэмшил бүс нутгийн хувьд нилээд ялгавартай байгааг харж болно.

Бүртгэлийн шаардлагууд

Бизнесийн орчин юуны өмнө бизнесийн байгууллагуудыг бүртгэхтэй холбоотой эрх зүйн үйл явцаар тодорхойлогддог. Бид компаниудыг бүртгэдэг албан секторын бүртгэлээс гадна патентын бүртгэл хэмээх Албан бус салбарын татварын хуулийг дагаж мөрдөхтэй холбоотой хүмүүсийн итгэл үнэмшил, зан байдлыг авч үзнэ. Итгэл үнэмшлийн тухай асуултуудыг судалгаанд оролцогч бүх хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт тавьсан бөгөөд тиймээс албан салбарт тавигддаг шаардлагуудыг үл биелүүлэхтэй холбоотой асуултуудад албан бус салбарынхан хариулсан байхад албан салбарынхан ч эсрэгээр нөгөө талын асуултуудад хариулсан гэсэн үг.

Хүснэгт 5.45-д үзүүлснээр албан салбарт бүртгүүлэхгүй байхаас үүдэх үр дагавартай холбоотой хүмүүсийн ойлголтууд тэдгээрийн бизнесийн байдлаас хамаарч бага зэрэг ялгаатай байна. Албан салбарынхны 10 хувь нь бүртгүүлээгүйгээс үүдэх ямар нэг сөрөг үр дагавар байхгүй гэж хариулж байхад албан бус салбарын аж ахуйнуудын 29 хувь нь ингэж үзсэн байна. Олон хүн ийм сөрөг үр дагавар юу байж болох талаар тодорхой ойлголтгүй байсан боловч хамгийн их санаа зовоосон зүйл нь, ялангуяа албан салбарынхны хувьд, зээлийн санхүүжилт авах чадвараа алдах явдал байв.

ХҮСНЭГТ 5.45 Бүртгүүлээгүйгээс үүдэх үр дагаврын тухай ойлголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н Байдал	1	2	3	4	5	6	7	8	9	10	Нийт
албан бус	.1952	.3843	.2565	.0868	.0223	.0202	.0034	.0235	.0057	.0021	1
МАА	.1715	.5911	.1613	.0292	.0062	.0087	.0000	.0308	.0012	.0000	1
Албан	.0894	.1350	.4098	.2039	.0641	.0474	.0073	.0222	.0081	.0128	1
Нийт	.1784	.4539	.2270	.0705	.0184	.0172	.0023	.0264	.0040	.0019	1

Тайлбар:

1 = Байхгүй

2 = Мэдэхгүй

3 = Мэдэхгүй, гэхдээ бизнесээ явуулахад минь сөрөг нөлөө үзүүлэх бусад үр дагаврууд байж болзошгүй

4 = Банкнаас юм уу зээлийн хоршооноос зээл авахад хэцүү байх болно

5 = Бизнесийн маргаанаа шүүхээр шийдүүлж чадахгүй болно

6 = Цагдаагийн хамгаалалт бага байх болно

7 = Олон улсын хэмжээнд импорт, экспортын үйл ажиллагаа явуулахад хэцүү байх болно

8 = Засгийн газрын ямар нэг хөтөлбөрийн үр шимийг хүртэх эрхгүй болно

9 = Хотоос үзүүлдэг усан хангамж, хий, цахилгаан, хог хаягдал ачих зэрэг үйлчилгээнд хамрагдахад хэцүү байх болно

10 = Бусад

Түлхүүр: мөрийн дүнд эзлэх хувь

Дагаж мөрдөөгүй нь илэрсэн тохиолдолд ногдуулах шийтгэлийн тухай хүмүүсийн ойлголтыг Хүснэгт 5.46-д үзүүлэв. Нийт оролцогчдын 9 хувь, албан секторынхны 11 хувь нь төрийн хууль сахиулах механизм, ногдуулах шийтгэл албан секторт бүртгүүлээгүй хүмүүст ноцтой үр дагавар авчирна гэдэгт итгэдэг байна. Албан секторт ажиллагчдын 52 хувь нь хэрвээ хууль тогтоомж дагаж мөрдөөгүй нь илэрвэл татварын нөхөн төлбөрийн хариуцлага хүлээнэ

гэдэгт (5 ба 6 дугаар сонголтын хослол) итгэдэг байхад албан бус секторынхны дөнгөж 25 хувь, мал аж ахуйн салбарынхны 9 хувь нь ингэж үздэг байна. Татварын нөхөн төлбөрөөс гадна албан секторт ажиллагчдын нилээд их хувь нь төрийн хууль сахиулах ажиллагаанд татагдан орж цаг хугацаа алдах нь бас нэг чухал үр дагавар болно гэдэгт итгэж байв. Харин маш бага хувь (1-ээс бага хувь) нь шоронд хоригдох явдлыг болзошгүй үр дагавар гэж үзсэн байна.

ХҮСНЭГТ 5.46 Бүртгүүлээгүй болох нь илэрвэл оногдуулах шийтгэлийн талаарх ойлголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н Байдал	Байхгүй/ хахуульдах боломжтой	Бага	Ноцтой	Шорон	Хугацаа алдах/ нөхөн татвар төлөх	Албадан бүртгэх	Бусад	Нийт
Албан бус	0.0346	0.5936	0.0982	0.006	0.0548	0.1931	0.02	1
МАА	0.0766	0.7354	0.0759	0.008	0.0172	0.0702	0.0172	1
Албан	0.0168	0.3221	0.1146	0.006	0.1587	0.3601	0.0223	1
Нийт	0.0543	0.6491	0.0881	0.007	0.0417	0.1414	0.0188	1

Жич: мөрөн дэх хувь

Мөн Хүснэгт 5.47-д үзүүлсэнчлэн Албан бус салбарын тухай хуулийг дагаж мөрдөөгүй нь илрэх магадлалын тухай итгэл үнэмшил ч оролцогчдын ажил эрхлэлтийн байдлаас хамаарч янз бүр байлаа. Энэ хуулийг зөрчсөн тохиолдолд илрэх магадлалтай буюу илрэх нь зайлшгүй гэж итгэдэг хүмүүсийн эзлэх хувь доод тал нь малчдын хувьд 43 хувь байхад албан салбарт ажиллагсдын 86 хувь болж нэмэгдэж байна. Харин албан бус секторт ажиллагсдын 68 хувь нь ингэж үзэж байлаа. Албан

бус секторын бизнес эрхлэгчдийн хувьд патентын хуулийн зөрчил илрэхтэй холбоотой итгэл үнэмшлийнхээ талаар хариулсан дүнг бид мөн байршил (Хүснэгт 5.48), бүс нутгийн ялгавартай байдлаар (Хүснэгт 5.49) нь харуулав. Баруун бүс нутагт болон хөдөөд зөрчил илрэх магадлал харьцангуй бага гэж үзэж байсан боловч эдгээр газруудад ч гэсэн бараг тал хувь нь хууль журмын зөрчил илрэх магадлалтай буюу зайлшгүй илэрнэ гэдэгт итгэж байв.

ХҮСНЭГТ 5.47 Патентын хураамж төлөх өртэй боловч төлөөгүй хүн илрэх эсэх, ажил эрхлэлтийн төрлөөр

АЭ-н Байдал	Үгүй	Үгүй байх	Мэдэхгүй	Илрэх байх	Илрэнэ	Нийт
Албан бус	0.0498	0.044	0.2353	0.2112	0.4597	1
МАА	0.0398	0.1804	0.3554	0.1091	0.3153	1
Албан	0.0314	0.0167	0.0843	0.146	0.7217	1
Нийт	0.0439	0.1096	0.2864	0.1576	0.4024	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.48 Патентын хураамж төлөх өртэй боловч төлөөгүй хүн илрэх эсэх, байршлаар

Байршил	Үгүй	Үгүй байх	Мэдэхгүй	Илрэх байх	Илрэнэ	Нийт
Улаанбаатар	0.0397	0.0437	0.2091	0.2564	0.4512	1
Аймгийн төв	0.0481	0.0403	0.2189	0.1919	0.5008	1
Сумын төв	0.0615	0.0499	0.2375	0.1246	0.5264	1
Хөдөө	0.04	0.1843	0.3637	0.1019	0.31	1
Нийт	0.0439	0.1096	0.2864	0.1576	0.4024	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.49 Патентын хураамж төлөх өртэй боловч төлөөгүй хүн илрэх эсэх, бүс нутгаар

Байршил	Үгүй	Үгүй байх	Мэдэхгүй	Илрэх байх	Илрэнэ	Нийт
Баруун	0.0642	0.4128	0.3154	0.0912	0.1164	1
Хангай	0.054	0.0741	0.4385	0.0769	0.3564	1
Төв	0.0213	0.0092	0.1577	0.1981	0.6136	1
Зүүн	0.0277	0.0237	0.1933	0.2061	0.5492	1
Улаанбаатар	0.0397	0.0437	0.2091	0.2564	0.4512	1
Нийт	0.0439	0.1096	0.2864	0.1576	0.4024	1

Жич: мөрөн дэх хувь

Албан бус секторын тухай хуулийг үл дагаж мөрдөхтэй холбоотой үр дагаврын хувьд бизнесийн бүртгэлийнхтэй ерөнхийдөө төстэй үр дүн гарч байгааг бид Хүснэгт 5.50-иас харж байна. Дагаж мөрдөхгүй байхаас үүдэх үр дагаврыг үл ойшоох байдал нилээд байгаа хэдий ч зарим тодорхойгүй сөрөг үр дагаврууд учирна гэдэгт судалгаанд оролцогчдын ихээхэн хувь нь итгэж байна. Өмнөхийн нэгэн адил албан секторт ажиллагсдын хувьд боломжит үр дагаврыг үл

ойшоох байдал хамаагүй бага байлаа.

Дагаж мөрдөхгүй байхтай холбоотой оногдох шийтгэлийн хувьд албан салбарын бүртгэлийнхтэй ихээхэн төстэй үр дүн гарч байгааг Хүснэгт 5.51 харуулж байна. Энд мөн л албан секторын аж ахуйн нэгжүүд албан бус салбарынхныг бодвол улсын бүртгэлийн ажилд зарцуулах цаг хугацаатай холбоотой асуудлыг илүү их ноцтой үр дагавартай гэж үзэж байлаа.

ХҮСНЭГТ 5.50 Бизнесийн бүртгэлд ороогүйгээс үүсэх үр дагаврын тухай ойлголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	1	2	3	4	5	6	7	8	9	10	Нийт
Албан бус	.1121	.3744	.3241	.0787	.0241	.0265	.0037	.0432	.0115	.0019	1
МАА	.1672	.5085	.2029	.0358	.0033	.0066	.0000	.0752	.0000	.0000	1
Албан	.0651	.1807	.3862	.1554	.0836	.0467	.0144	.0452	.0167	.0060	1
Нийт	.1367	.4302	.2678	.0617	.0170	.0178	.0024	.0590	.0063	.0012	1

Тайлбар:

1 = Байхгүй

2 = Мэдэхгүй

3 = Мэдэхгүй, гэхдээ бизнесээ явуулахад минь сөрөг нөлөө үзүүлэх бусад үр дагаврууд байж болзошгүй

4 = Банкнаас юм уу эзэлийн хоршооноос зээл авахад хэцүү байх болно

5 = Бизнесийн маргаанаа шүүхээр шийдүүлж чадахгүй болно

6 = Цагдаагийн хамгаалалт бага байх болно

7 = Олон улсын хэмжээнд импорт, экспортын үйл ажиллагаа явуулахад хэцүү байх болно

8 = Засгийн газрын ямар нэг хөтөлбөрийн үр шимийг хүртэх эрхгүй болно

9 = Хогоос үзүүлдэг усан хангамж, хий, цахилгаан, хог хаягдал ачих зэрэг үйлчилгээнд хамрагдахад хэцүү байх болно

10 = Бусад

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.51 Бизнесийн бүртгэл хийлгээгүйгээс ногдох шийтгэлийн тухай ойлголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н Байдал	Байхгүй/ хахуульдах боломжтой	Бага	Ноцтой	Шорон	Хугацаа алдах/ Нөхөн татвар Төлөх	Албадан бүртгэх	Бусад	Нийт
Албан бус	.0346	.5936	.0982	.0058	.0548	.1931	.0200	1
МАА	.0766	.7354	.0759	.0076	.0172	.0702	.0172	1
Албан	.0168	.3221	.1146	.0055	.1587	.3601	.0223	1
Нийт	.0543	.6491	.0881	.0067	.0417	.1414	.0188	1

Жич: мөрөн дэх хувь

Дараагийн багц үр дүнд оролцогчдын итгэл үнэмшлийг зан байдалтай нь харьцуулав. Үүний тулд бид зөвхөн Албан бус секторын тухай хуулийн дагуу бүртгүүлэх шаардлагатай гэж үздэг хүмүүсийг авч үзэх ба тухайн хариулагч хуулийг дагаж мөрдөх явдлыг хүлээн зөвшөөрсөн эсэхээр нь түүврийг хоёр хэсэгт хуваав.³⁴ Хүснэгт 5.51-т бүртгэл, татварын шаардлагыг дагаж мөрдөгсдийн ихэнх хувь нь уг шаардлагыг зөрчвөл илрэх нь зайлшгүй гэж үзсэн нь санамсаргүй дүн биш юм (бүртгүүлэгчдийн 52 хувь, бүртгүүлээгүй хүмүүсийн 40 хувь). Харин энэ хоёр бүлгийн хооронд байгаа нэг том ялгаа бол бүртгүүлэхгүй байхын үр дагавар ба илрэх магадлалын хоёуланг нь үл ойшоох байдлаар хандаж байгаагаа ихээр хүлээн зөвшөөрсөн явдал ба энэ нь илүү бодлогын үр дагавартай юм. Эдгээр хэмжүүрээр авч үзэхэд

хуулийг даган мөрдөхгүй байгаа хэсгийн 40 хувь нь илрэх магадлалыг үл ойшоож байгаагаа хүлээн зөвшөөрсөн бол хууль дүрмийг даган мөрдөж байгаа албан бус секторын оролцогчдын 20 хувь нь ийм байр суурьтай байна. Үүний нэг адил үзэл бодол гарах үр дагаврын хувьд зонхилж байгааг Хүснэгт 5.53-аас харж болох ба үүнд хуулийг даган мөрдөгч болон үл даган мөрдөгчдийн ихээхэн хэсэг шийтгэлийн талаар үл ойшоох байр суурьтайгаа хүлээн зөвшөөрсөн байна. Магадгүй хамгийн таагүй нь Хүснэгт 5.54-т үзүүлсэн дүн бөгөөд энд хэдийгээр патентын хураамж төлөх өртэй байсан ч гэсэн төлөхгүй байхад нэг их юм болохгүй гэж оролцогчдын гуравны хоёр нь үзсэн байна. Энэ бол хариулагч татвараа төлж байгаа эсэхээс үл хамаарч өгсөн хариултын дүн юм.

³⁴ Бүх хариулагчид нэг бол 2 эсвэл 4 дүгээр хувилбарт хамаарч байсан бөгөөд энд тэдний 161 дүгээр асуултад өгсөн хариултыг ажиглахад дугтуйн аргыг хэрэглэсэн болно.

ХҮСНЭГТ 5.52 Патентын хураамж төлөөгүй хүн илрэх эсэх, хариулагч татвар төлдөг эсэхээ мэдүүлсэн байдлаар

Хариулагч татвараа төлсөн үү?	Үгүй Үгүй	Мэдэхгүй байх	Илрэх	Байх	Илэрнэ	Нийт
Үгүй	0.0266	0.0145	0.3996	0.1638	0.3955	1
Тийм	0.0152	0.0138	0.1946	0.2581	0.5183	1
Нийт	0.0204	0.0141	0.2887	0.2149	0.462	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.53 Патентын хураамж төлөөгүй хүнд ногдуулах шийтгэлийн тухай ойлголт, хариулагч татвар төлдөг эсэхээ мэдүүлсэн байдлаар

Хариулагч татвараа төлсөн үү?	1	2	3	4	5	6	7	8	9	Нийт
Үгүй	.0899	.4843	.2182	.0924	.0142	.0152	.0000	.0759	.0100	1
Тийм	.1100	.3671	.3608	.0685	.0232	.0393	.0023	.0288	.0000	1
Нийт	.1007	.4211	.2951	.0795	.0191	.0282	.0012	.0504	.0046	1

Тайлбар:

1 = Байхгүй

2 = Мэдэхгүй

3 = Мэдэхгүй, гэхдээ бизнесээ явуулахад минь сөрөг нөлөө үзүүлэх бусад үр дагаврууд байж болзошгүй

4 = Банкнаас юм уу зээлийн хоршооноос зээл авахад хэцүү байх болно

5 = Бизнесийн маргаанаа шүүхээр шийдүүлж чадахгүй болно

6 = Цагдаагийн хамгаалалт бага байх болно

7 = Олон улсын хэмжээнд импорт, экспортын үйл ажиллагаа явуулахад хэцүү байх болно

8 = Засгийн газрын ямар нэг хөтөлбөрийн үр шимийг хүртэх эрхгүй болно

9 = Хотоос үзүүлдэг усан хангамж, хий, цахилгаан, хог хаягдал ачих зэрэг үйлчилгээнд хамрагдахад хэцүү байх болно

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.54 Зөвшөөрлийн хураамж төлөх өртэй боловч төлөөгүй хүнд ногдуулах шийтгэлийн тухай ойлголт, хариулагч татвар төлдөг эсэхээ мэдүүлсэн байдлаар

Хариулагч татвараа төлсөн үү?	Байхгүй/ хахуульдах боломжтой	Бага	Ноцтой	Шорон	Хугацаа алдах/ нөхөн татвар төлөх	Албадан бүртгэх	Бусад	Нийт
Үгүй	0.0033	0.6672	0.056	0.0383	0.0493	0.1789	0.0071	1
Тийм	0.0159	0.6701	0.0881	0.0126	0.0225	0.1907	0	1
Нийт	0.0101	0.6688	0.0733	0.0244	0.0349	0.1853	0.0033	1

Жич: мөрөн дэх хувь

Зохицуулалт

Хүснэгт 5.55 аж ахуйн нэгжийн албан ёсны байдал нэмэгдэх тусам зохицуулалт саад болдгийг харуулж байна. Малчдын дөнгөж 2 хувьд зохицуулалт нөлөөлж байхад албан бус секторынхны 18 хувь, албан секторынхны 34 хувь нь төрийн зохицуулалт, бусад дүрэм журмууд тэдний бизнесийн үйл ажиллагаанд саад тотгор учруулдаг гэж үзсэн байна. Энэхүү хүндрэл бэрхшээлийн цар хүрээний тухай ойлголт албан ба албан бус салбарт ижил төстэй байх бөгөөд үүнд зохицуулалтад өртсөн хэсгийнхний дундаж тооцоогоор ийм саад тотгор байгаагүй бол тэдний ашиг одоо байгаагаасаа даруй 24 хувь өндөр байх байсан гэж үзжээ.

Албан ба албан бус секторын хувьд зохицуулалтын талаарх тулгарч буй асуудлууд харилцан адилгүй байгааг Хүснэгт 5.56-д үзүүлэв. Тодорхой салбарын шинжтэй зохицуулалтууд хоёр бүлэгт хоёуланд нь хамгийн их хүндрэлтэй асуудал болж байгаа хэдий ч албан секторын 41 хувь нь гол анхаарал татсан асуудал гэж үзэж байхад албан бус секторын 24 хувь нь л ингэж

ХҮСНЭГТ 5.55 Хүндрэл бүхий зохицуулалтын тухай ойлголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Тийм	Үгүй	Нийт
Албан бус	0.1819	0.8181	1
МАА	0.0226	0.9774	1
Албан	0.3359	0.6641	1
Нийт	0.1116	0.8884	1

Жич: мөрөн дэх хувь

үзжээ. Албан бус секторынхны хувьд салбарын шинжтэй зохицуулалтуудын дараа орох гол асуудал бол гаалийн болон гадаад худалдааны, мөн хөдөлмөрийн зохицуулалтууд (тус бүр 18 хувь) байна. Харин албан секторын аж ахуйн нэгжүүд ямар нэг бизнес шинээр эхлэхэд (17 хувь), мөн барилга барих болон бизнесийн үйл ажиллагаа явуулахад (13 хувь) олгодог зөвшөөрлүүдийг илүү анхаарчээ.

ХҮСНЭГТ 5.56 Хариулагчийн бизнест тулгарч буй зохицуулалтын гол саад бэрхшээлийн тухай ойлголт, МАА-н бус ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Худалдаа	Хөдөлмөр мөр	Салбарын шинжтэй	Үйл ажил. /барилгын зөвшөөрөл	Бизнесийн бүртгэлийн зөвшөөрөл	Үл хөдлөх хөрөнгийн арилжаа	Байгаль орчин	Бусад	Нийт
Албан бус	.1803	.1802	.2386	.1052	.1331	.0477	.0648	.0500	1
Албан	.0988	.1128	.4072	.1255	.1732	.0106	.0185	.0534	1
Нийт	.1661	.1685	.2680	.1087	.1401	.0412	.0568	.0506	1

Жич: мөрөн дэх хувь

Салбарын шинжтэй зохицуулалтууд чухал ач холбогдолтойг харгалзан Хүснэгт 5.57-д аль салбарт илүү зохицуулалтын саад бэрхшээл байгааг бид ЭЗҮАОУСА-аар харуулсан. Ингэхдээ албан секторынхон саад бэрхшээл ихтэй, албан бус секторынхан саад бэрхшээл багатай гэж үзсэн салбарт онцгой анхаарсан юм. Энэ талаар хамгийн их зөрөөтэй түвшинг харуулсан салбарууд бол боловсруулах үйлдвэрлэлийн болон барилгын салбар байсан бөгөөд албан бус секторын үйлдвэрлэгчдийн 8 хувь, албан секторын үйлдвэрлэгчдийн 31 хувь нь зохицуулалтын саад бэрхшээл байгааг илэрхийлжээ. Барилгын салбарт мөн л албан бус секторынхны 8 хувь, харин албан

секторын аж ахуйн нэгжүүдийн 55 хувь нь зохицуулалтын саад бэрхшээл байгааг дурьджээ. Хэдийгээр зөрүү нь тийм их биш ч гэсэн албан салбарт саад бэрхшээл их байгааг мөн адил хуваалцаж байсан өөр хоёр томоохон албан бус бүрэлдэхүүнтэй салбар бол худалдааны болон тээврийн салбарууд байлаа. Худалдааны салбарт албан бус аж ахуйн нэгжүүдийн 23 хувь, албан ёсны үйлдвэр аж ахуйн газруудын 34 хувь нь зохицуулалтын саад бэрхшээл байгааг илэрхийлжээ. Тээврийн салбарын хувьд албан бус аж ахуйн нэгжүүдийн 22 хувь, албан ёсны нэгжүүдийн 40 хувь нь хүндрэл бэрхшээл байна гэж хариулжээ.

ХҮСНЭГТ 5.57 Хариулагчийн бизнест тулгарч буй зохицуулалтын гол саад бэрхшээлийн тухай ойлголт, МАА-н бус ажил эрхлэлтийн байдлаар болон ЭЗҮАОУСА-аар

Мал аж ахуйн бус албан бус			
ЭЗҮАОУСА	Тийм	Үгүй	Нийт
ХАА	.1660	.8340	1
Загас агнуур	0	1	1
Уул уурхай	.2105	.7895	1
Боловсруулах үйлдвэрлэл	.0762	.9238	1
Цахилгаан, хий	.0509	.9491	1
Барилга	.0753	.9247	1
Худалдаа	.2246	.7754	1
Зочид бууд., зоог. газар	.1994	.8006	1
Тээвэр	.2178	.7822	1
Санхүү	.2820	.7180	1
Үл хөдлөх хөрөнгө	.1211	.8789	1
Боловсрол	.1715	.8285	1
Эрүүл мэнд	.2064	.7936	1
Бусад, нийтийн аж ахуй	.1567	.8433	1
Хувийн орон сууц	0	1	1
Нийт	.1819	.8181	1

Жич: мөрөн дэх хувь

Албан сектор			
ЭЗҮАОУСА	Тийм	Үгүй	Нийт
ХАА	.1091	.8909	1
Уул уурхай	.3810	.6190	1
Боловсруулах үйлдвэрлэл	.3068	.6932	1
Цахилгаан, хий	0	1	1
Барилга	.5499	.4501	1
Худалдаа	.3346	.6654	1
Зочид бууд., зоог. газар	.4298	.5702	1
Тээвэр	.4030	.5970	1
Санхүү	.2941	.7059	1
Үл хөдлөх хөрөнгө	.3804	.6196	1
Боловсрол	.4011	.5989	1
Эрүүл мэнд	.3959	.6041	1
Бусад, нийтийн аж ахуй	.2726	.7274	1
Нийт	.3359	.6641	1

Жич: мөрөн дэх хувь

Авилгал ба татвараас зайлсхийлт: ойлголт ба зан байдал³⁵

Монголд авилгал, хээл хахууль (Хүснэгт 5.58), татвараас зайлсхийх явдал (Хүснэгт 5.59) хоёр газар авсан гэдэгт хүн амын ихээхэн хувь нь итгэж байна. Авилгал хамаагүй бага байгаа гэсэн ойлголтоороо малчид хүн амын бусад хэсгээс ихээхэн ялгаатай боловч энэ бүлгийн хүмүүс ч гэсэн талаас илүү хувь нь (53 хувь) авилгал нилээд буюу өргөн хүрээтэй газар авсан гэдэгт итгэж байна. Харин бусад хувиараа бизнес эрхлэгч эзэд болон хөлсний ажилтны 80 орчим хувь нь авилгал

нилээд буюу өргөн хүрээтэй газар авсан гэж үзэж байна. Ажилгүйчүүдийн 66 хувь нь авилгал өндөр түвшинд байгаад итгэдгээ илэрхийлснээр дээрх хоёр туйлын дунд явж байна. Татвараас зайлсхийх явдлын талаарх дээрх бүлгүүдийн ойлголтын зөрүү мөн л үүнтэй төстэй гарсан боловч ийм ойлголтын түвшин авилгалынхтай харьцуулахад бага буюу 30 хувиас (малчид) 64 хувийн (албан салбарт бизнес эзэмшигчид) хооронд буюу дунджаар 50 хувь байна.

³⁵ Энэ хэсэгт цалин хөлс авагчид болон ажилгүйчүүдийн өгсөн хариултыг оруулсан байгааг анхаараарай. Эдгээр бүлгүүдийг бизнесийн орчны тухай өмнөх асуултуудад оруулаагүй байгаа. Түүнчлэн, энэхүү дэд хэсгийн хүснэгтүүд дугтуйгаар асуулга авах аргад тулгуурлав.

ХҮСНЭГТ 5.58 Улс оронд бүхэлдээ авилгал газар авсан түвшний тухай ойлголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал (2)	Байхгүй	Бага	Дунд	Ихээхэн	Нилэнхүй	Нийт
Албан бус	0.019	0.0862	0.1079	0.2177	0.5693	1
МАА	0.1266	0.1763	0.1749	0.1933	0.3288	1
Албан	0.0364	0.0627	0.0564	0.2481	0.5964	1
Хөлсний	0.0228	0.0821	0.1005	0.3094	0.4852	1
Ажилгүй	0.065	0.1328	0.1443	0.2354	0.4225	1
Нийт	0.0554	0.1148	0.1272	0.2449	0.4577	1

Жич: мөрөн дэх хувь

ХҮСНЭГТ 5.59 Улс оронд бүхэлдээ татвараас зайлсхийх явдал газар авсан түвшний тухай ойлголт, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал (2)	Огт байхгүй	Тийм гэж бодохгүй	Итгэлгүй	Тийм гэж бодож байна	Баттай тэгэж бодож байна	Нийт
Албан бус	0.0615	0.1223	0.2211	0.322	0.273	1
МАА	0.2471	0.1707	0.2796	0.202	0.1007	1
Албан	0.065	0.1396	0.1554	0.3537	0.2863	1
Хөлсний	0.0584	0.1216	0.2117	0.3818	0.2265	1
Ажилгүй	0.1528	0.1398	0.2855	0.2698	0.1522	1
Нийт	0.1226	0.1376	0.2423	0.3031	0.1945	1

Жич: мөрөн дэх хувь

Авилгагч зан байдал, татвараас зайлсхийх явдал нь зохицуулалтын үр нөлөөний талаарх хариулагчдын үзэл бодолтой ихээхэн хамааралтай байгааг Хүснэгт 5.60 харуулж байна. Гаалийн хээл хахуулийн хувьд авч үзэхэд (q158) зохицуулалтын дарамт чухал нөлөөтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийн дунд үйл ажиллагааны түвшин хүлээн зөвшөөрөөгүй хүмүүсийнхтэй харьцуулахад дөрөв дахин илүү их байна (39 хувь ба 9 хувь). Ерөнхийдөө хээл хахууль өгч байгаа байдлыг үзэхэд (q162) ижил үр дүн гарч байгаа ба зохицуулалт яришиг төвөгтэй гэж үзэгсдийн 32 хувь нь хээл хахууль өгдөгөө хүлээн зөвшөөрсөн байхад тэгж үздэггүй хүмүүсийн 19 хувь нь

зөвшөөрсөн байна. Хээл хахуулийн тухай асуултыг дагалдсан "бэлэг өгөх" явдлын тухай асуулт мөн ижил хэв маягийг харуулах бөгөөд энэ зан байдлыг хүлээн зөвшөөрөгсдийн үйлдэл мөн л ихээхэн хувийг эзэлж байна (27 хувь ба 8 хувь). Татвар төлөлтийн хувьд эдгээрээс ялгаатай байсан бөгөөд зохицуулалтын саад бэрхшээлийг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийн дотор татвараас зайлсхийгсдийн эзлэх хувь бага зэрэг их байлаа (70 хувь ба 62 хувь). Эдгээр үр дүн нь хос асуултын аргыг хэрэглэсэн хувилбарын дүн бөгөөд энэ хувилбараар авилгагч зан байдлыг хүлээн зөвшөөрөх түвшин илүү өндөр байсан.

ХҮСНЭГТ 5.60 Авилгах үйлдэл хийх, зохицуулалт яришигтай гэж үзэх явдал хоёрын хамаарал

Зохицуулалт Хүндрэл төвөгтэй юу?	Гаалийн татварыг бууруулахын тулд хахууль өгч байсан уу?		
	Үгүй	Тийм	Нийт
Тийм	0.6058	0.3942	1
Үгүй	0.9121	0.0879	1
Нийт	0.8559	0.1441	1

Жич: мөрөн дэх хувь

Зохицуулалт Хүндрэл төвөгтэй юу?	Төр засгийн албан тушаалтанд бэлэг сэлт өгч байсан уу?		
	Үгүй	Тийм	Нийт
Тийм	0.7432	0.2568	1
Үгүй	0.9215	0.0785	1
Нийт	0.8894	0.1106	1

Жич: мөрөн дэх хувь

Зохицуулалт Хүндрэл төвөгтэй юу?	Төр засгийн албан тушаалтанд хахууль өгч байсан уу?		
	Үгүй	Тийм	Нийт
Тийм	0.68	0.32	1
Үгүй	0.8057	0.1943	1
Нийт	0.7856	0.2134	1

Жич: мөрөн дэх хувь

Зохицуулалт Хүндрэл төвөгтэй юу?	Өнгөрсөн жил тагвар төлөхөөс зайлсхийсэн үү?		
	Үгүй	Тийм	Нийт
Тийм	0.3012	0.6988	1
Үгүй	0.3809	0.6191	1
Нийт	0.3665	0.6335	1

Жич: мөрөн дэх хувь

5.3. АЛБАН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮР ДАГАВАР

Бид 5.1-р хэсэгт бизнесийн шинж чанаруудыг тодотгох үедээ албан бус секторын сүүдрийн үйл ажиллагаанд оролцсоны зарим нэг үр нөлөөг авч үзсэн. Ерөнхийдөө албан бус секторт ажиллагсад нь харьцангуй бүтээмж багатай ажилчидтай, зохицуулалтын дарамт ачаалал нилээн бага үүрдэг жижгэвтэр аж ахуйнууд байдаг. Энэ хэсэгт бид албан бус сектор дахь оролцоотой холбоотой санхүүжилт, амьжиргаа ба ядуурал, оролцооны үргэлжлэх хугацаа зэрэг гурван гол асуудлыг нарийвчлан судлана.

Санхүүжилт авах боломж

Хүснэгт 5.61-д бизнес эрхлэгчдийн зээл авах боломжийн цар хүрээг дүрслэн харуулав. Энд нийт хүн амын дийлэнх олонхи нь (85 хувь) хөрөнгө

оруулалт хийхээр банкны зээл ашиглаагүй байна. Хангагдаагүй зээлийн хэрэгцээ албан бус секторт хамгийн их (46 хувь) байсан бөгөөд судалгаанд оролцогчдын хувьд хамгийн тулгамдсан асуудлууд бол барьцаа хөрөнгийн шаардлагууд (27 хувь), мэдээлэл (10 хувь), хүүгийн хувь (7 хувь)-д хавчигдах явдал гэж үзжээ. Барьцаа хөрөнгийн хувьд хүснэгтэн дэх тоо нь барьцаа хөрөнгийн шаардлага хэт өндөр, эсвэл хангалттай барьцаа хөрөнгө байхгүй гэсэн хариултын нийлбэр тоо болно. Мал аж ахуйн салбарт ажиллаж буй нэмэлт хөрөнгө шаардлагатай хүмүүсийн санаа зовоосон асуудлуудын дотор мэдээллийн хомс байдал зонхилж (18 хувь) байлаа. Харин албан секторынхны хувьд барьцааны шаардлагууд (20 хувь), хүүгийн хувь (15 хувь) хоёр гол тулгамдсан асуудал болжээ.

ХҮСНЭГТ 5.61 Банкнаас зээл аваагүй шалтгаан, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Шаардлага гараагүй	Яаж	Барьцаа байхгүй	Барцаа	Татварын	Данс байхгүй	Хүү	Бусад	Нийт
		гэдгээ мэдэхгүй		хэт өндөр	тайлан байхгүй		өндөр		
албан бус	.5440	.1003	.1934	.0820	.0024	.0054	.0687	.0039	1
МАА	.7049	.1799	.0635	.0236	.0004	.0025	.0247	.0005	1
албан	.6165	.0269	.0997	.0965	.0000	.0044	.1524	.0035	1
Нийт	.6325	.1400	.1207	.0513	.0012	.0038	.0483	.0021	1

Жич: мөрөн дэх хувь

Хүснэгт 5.62-оос үзэхэд албан бус сектор дахь зээлийн дарамт шахалтын үр нөлөөг өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын хэтийн төлөвийн аль аль талаас нь авч үзэж болох юм. Албан бус секторын зээл авах шаардлагагүй гэж үзсэн бизнесүүдийн нэмэгдсэн орлогын жилийн дүн барьцааны хөрөнгөгүй хүмүүсийнхээс 45 хувиар илүү байна. Барьцааны хувь хэтэрхий өндөр гэж үзсэн учраас зээл аваагүй хүмүүсийн хувьд

барьцааны хөрөнгөгүй хүмүүсээс нилээд өөр бөгөөд бизнесийнх нь нэмэгдсэн орлогын жилийн дүн зээл огт шаардлагагүй гэсэн хүмүүсийнхээс 1 хувь доогуур байна. Нэмэгдсэн орлогын жилийн дүн нь зээл шаардлагагүй хүмүүсээс давж гарсан нэг бүлэг байна. Энэ бол татварын бүртгэлгүй хүмүүс бөгөөд тэдний нэмэгдсэн орлогын дүн 21 хувь өндөр байна.

ХҮСНЭГТ 5.62 Мал аж ахуйн бус албан бус секторынхны жилээр тооцсон нийт нэмэгдэл өртөг, банкнаас зээл аваагүй шалтгаанаар

Зээл аваагүй шалтгаан	Тооцоо	Ст. Алдаа	[95% итгэмжлэгдэх зааг]		D эффект
Шаардлага гараагүй	2462811	537471.6	1409083	3516538	8.393145
Яаж гэдгээ мэдэхгүй	3254682	1066934	1162929	5346435	11.96088
Барьцаа байхгүй	2054669	134423.5	1791128	2318210	1.163809
Барьцаа хэт өндөр	2195917	766293.2	693578	3698255	1.211481
Татварын тайлан байхгүй	3669469	999229.3	1710453	5628485	1.125073
Данс хөтөлдөггүй	2805757	832182	1174242	4437273	0.925691
Хүү өндөр	3878612	643837.2	2616352	5140872	1.126792
Бусад	1886879	814698	289641.6	3484117	1.198243

Цаашдын төлвийн хувьд зээл шаардлагагүй бүлгийн 77 хувь нь бизнесийн өсөлтийн төлөв ирэх гурван жилд эерэг байна гэж үзэж байхад 16 хувь нь тогтвортой байна, харин дөнгөж 8 хувь нь уналт гарна гэж төсөөлж байгааг Хүснэгт 5.63 харуулж байна. Харин барьцааны хөрөнгө эсвэл татварын бүртгэл байхгүйгээс зээл авч чадаагүй бүлгүүдийн хувьд илүү өөдрөг бус байгаа ба ирээдүйн төлөв

эерэг байна гэдэгт 57 ба 55 хувь нь тус тус итгэж байгаа үзүүлэлт гарчээ. Татварын бүртгэлгүй хэсгийнхэн хамгийн өөдрөг бус төсөөлөлтэй бөгөөд 31 хувь нь ирэх гурван жилд бизнесийн өсөлт сөрөг байна гэж үзэж байгаа нь нийт хариулагчдын дундаж 9 хувиас ихээхэн ялгаатай байна.

ХҮСНЭГТ 5.63 Бизнесийнхээ өсөлтийн төлөвийг тодорхойлсон байдал, банкнаас зээл аваагүй шалтгаанаар

Банкнаас зээл аваагүй шалтгаан	Бизнесийн ирээдүйн төсөөлөл			
	Уналт	Тогтвортой	Өсөлт	Нийт
Шаардлага гараагүй	0.077	0.1579	0.765	1
Яаж гэдгээ мэдэхгүй	0.0758	0.2331	0.6911	1
Барьцаа байхгүй	0.1268	0.3033	0.5698	1
Барьцаа хэт өндөр	0.1638	0.1992	0.6369	1
Татварын тайлан байхгүй	0.3067	0.1467	0.5466	1
Данс хөтөлдөггүй	0.146	0.0564	0.7976	1
Хүү өндөр	0.092	0.201	0.7069	1
Бусад	0.3251	0.331	0.3439	1
Нийт	0.089	0.1904	0.7206	1

Жич: мөрөн дэх хувь

Барьцааны хөрөнгө дутагдсантай холбоотой хүндрэл мал аж ахуйн бус хөдөө аж ахуйн салбарт нэн ноцтой нөлөөлж байгаа буюу тус салбарынхны 30 хувь нь энэ шалтгаанаар зээл аваагүй байна. Мөн барьцааны хөрөнгө дутагдах асуудал уул уурхай, үйлдвэрлэлийн салбаруудад хүнд байгааг тэдгээрийн 28 ба 23 хувь нь тус тус онцлон тэмдэглэжээ. Түүнчлэн зочид буудал, зоогийн газрын салбар ч харьцангуйгаар барьцааны хөрөнгө дутагдах (16 хувь) болон хүүгийн өндөр хувийн (15 хувь) бэрхшээлд гол төлөв баригддаг байна.

Орлого, хөрөнгө, ядуурал

Албан бус секторын үйл ажиллагаатай холбоотой нэг чухал асуудал бол өрх бүлийн гишүүдийн амьжиргаанд үзүүлж байгаа хувь нэмэр юм. Энэ

хэсэгт бид албан бус сектор өрхийн орлого, өмч хөрөнгөд оруулж байгаа хувь нэмрийг үнэлэх болно.

Эхлээд бид Хүснэгт 5.64-т албан бус секторын хувь нэмрийг судалж, орлогын түвшнийг ҮСГ-аас гаргасан тус улсын нэг хүнд ногдох амьжиргааны доод түвшний үзүүлэлттэй харьцуулав. Доорх хүснэгтэд бүс нутаг болон өрхийн байдал тус бүрийн хувьд гурван үзүүлэлтээр танилцуулав. Үүний эхнийх нь өрхийн жилийн орлого, хоёр дахь нь нэг хүнд ногдох өрхийн сарын орлогын дундаж, гурав дахь нь ҮСГ-аас гаргасан сард нэг хүнд ногдох амьжиргааны доод түвшний үзүүлэлт байна. Энд ҮСГ-аас гаргасан стандарт бүс нутаг бүрт харилцан адилгүй байгааг анхаарна уу.

ХҮСНЭГТ 5.64 Өрхийн жилийн орлого, нэг хүнд ногдох сарын орлого, сарын ядуурлын шугам, бүс нутаг ба ажил эрхлэлтийн байдлаар (төгрөгөөр)

Бүс нутаг	албан бус	МАА	албан	цалин хөлстэй	ажилгүй	нийт
Баруун	874,460	486,764	1,166,772	1,207,437	254,037	750,770
	19,797	10,118	21,051	26,240	5,541	16,262
	20,200	20,200	20,200	20,200	20,200	20,200
Хангай	1,019,558	687,135	2,282,220	1,799,410	260,638	1,018,159
	22,542	12,698	47,826	34,072	7,713	20,279
	20,600	20,600	20,600	20,600	20,600	20,600

ХҮСНЭГТ 5.64-ийн үргэлжлэл

Төв	1,195,244	1,254,313	1,229,450	1,320,473	280,654	1,104,405
	25,028	29,761	24,107	28,089	6,930	24,204
	20,600	20,600	20,600	20,600	20,600	20,600
Зүүн	3,845,717	889,479		1,124,935	195,495	1,145,571
	49,350	21,908		23,558	6,131	22,698
	21,200	21,200		21,200	21,200	21,200
Улаанбаатар	2,042,721	1,947,525	2,866,844	1,011,102	439,836	1,396,081
	43,240	35,164	53,875	23,780	12,057	30,515
	26,500	26,500	26,500	26,500	26,500	26,500
Нийт	1,576,394	800,459	2,241,811	1,345,623	325,193	1,105,847
	33,010	16,925	43,804	28,163	8,765	23,458
	23,371	20,662	23,093	21,960	22,664	22,118

Жич: Орлогын мэдээллийг асуулгын дугтуйн аргаар цуглуулан гаргасан болно (2.2-р хэсгийг үзнэ үү)

Хүснэгтийн баруун доод буланд байгаа тоо нь нэг хүнд ногдох дундаж орлого үндэсний хэмжээний амьжиргааны доод түвшнээс багахан хэмжээгээр давж гарсныг харуулж байна. Мэдүүлсэн орлогын хэмжээ 23,458 төгрөг байхад улсын амьжиргааны доод түвшний жигнэсэн дундаж хэмжээ 22,118 төгрөг байна. Ажилгүй болон мал аж ахуйн салбарынхан энэ түвшинд хүрч чадаагүй буюу ажилгүйчүүд дунджаар амьжиргааны доод түвшний 39 хувь, малчид 82 хувьтай тэнцэх орлоготой байна. Энэ босгыг цалин

хөлстэй ажиллагсад (128 хувь), албан бус секторын өрхүүд (141 хувь), албан секторын өрхүүд (190 хувь) тус тус давж чаджээ. Уг үзүүлэлтүүдийг байршлаар нь ангилж Хүснэгт 5.65-д үзүүлснээс харахад албан секторын аж ахуйн нэгжтэй өрхүүд бүх газар амьжиргааны доод түвшнээс давсан орлоготой байхад албан бус секторын аж ахуйн нэгжүүдийн хувьд зөвхөн аймгийн төвүүд болон Улаанбаатар хотод ийм байдалтай байна.

ХҮСНЭГТ 5.65 Өрхийн жилийн орлого, нэг хүнд ногдох сарын орлого, сарын амьжиргааны доод түвшин, байршил ба ажил эрхлэлтийн байдлаар

Байршил	албан бус	МАА	албан	цалин		нийт
				хөлстэй	ажилгүй	
Улаанбаатар	2,042,721	1,947,525	2,866,844	1,011,102	439,836	1,396,081
	43,240	35,164	53,875	23,780	12,057	30,515
	26,500	26,500	26,500	26,500	26,500	26,500
Аймгийн төв	1,310,331	716,046	2,377,582	2,396,856	381,759	1,495,245
	29,251	14,334	55,802	45,490	10,595	31,011
	20,560	20,772	20,551	20,536	20,566	20,559
Сумын төв	1,170,220	966,839	418,034	1,117,929	169,920	881,270
	19,575	18,730	7,446	24,560	4,427	18,534
	20,528	20,580	20,554	20,580	20,599	20,577

ХҮСНЭГТ 5.65 –ын үргэлжлэл

Хөдөө	313,865	773,728	2,474,339	562,699	345,542	755,568
	7,079	16,582	42,357	9,956	5,157	15,838
	20,397	20,563	20,600	20,494	20,316	20,546
Нийт	1,576,394	800,459	2,241,811	1,345,623	325,193	1,105,847
	33,010	16,925	43,804	28,163	8,765	23,458
	23,371	20,662	23,093	21,960	22,664	22,118

Жич: Орлогын мэдээллийг асуулгын дугтуйн аргаар цуглуулан гаргасан болно (2.2-р хэсгийг үзнэ үү)

Хөрөнгийн хувьд бид өмч хөрөнгийг мал амьтан ба үйлдвэр/тоног төхөөрөмж (амьтан бус) гэсэн хоёр төрөлд хуваав. Хүснэгт 5.66-д судалгаанд оролцогчдын тайлан тэнцэл, мэдүүлсэн өмч хөрөнгө (q119), өр төлбөрийн байдлыг (q120) үзүүлэв. Энд мөн л дугтуйн аргаар (Env) цуглуулсан тоо үржүүлэгчийн аргыг бодвол нилээд их өмч хөрөнгийг илрүүлсэн бөгөөд зөрүү нь малчин өрхүүдийн өгсөн хариултад хамгийн их илэрч байлаа. Сонирхолтой нь аргуудын үр нөлөөг тооцож үзэхэд өр төлбөрүүдийн хувьд бусдаас

онцлог үр дүн гарсан буюу үржүүлэгчийн аргаар малчдын хувьд өр төлбөр хамаагүй өндөр гарсан байв. Энэ нь дугтуйн ба үржүүлэгчийн аргын ялгаанаас хамаарч судалгаанд оролцогчид стратегийн хариулт өгөх боломжтой байгааг анхаарах ёстой гэсэн үг бөгөөд үржүүлэгчийн аргаар асуулгыг авахад хүмүүс илүү стратегийн шинжтэй хариулт өгч болзошгүй юм. Хүснэгт 5.67-д мал амьтны хөрөнгийг малчид болон мал аж ахуйн бус албан бус секторын бизнесүүдийн аль алиных нь хувьд тооцсоныг үзүүлэв.

ХҮСНЭГТ 5.66 Хөрөнгө ба өр төлбөрийн тайлан тэнцэл, ажил эрхлэлтийн байдлаар

Нийт хөрөнгө	Дэд олонлог	Тооцоо	Ст. Алдаа	[95% итгэмжлэх зааг]		D эффект
Дугтуй	албан бус	7.86E+10	1.30E+10	5.30E+10	1.04E+11	0.4233722
Үржүүлэгч	албан бус	1.20E+11	8.34E+09	1.04E+11	1.36E+11	0.6972588
Дугтуй	мал аж ахуй	1.42E+11	4.90E+10	4.59E+10	2.38E+11	6.119897
Үржүүлэгч	мал аж ахуй	1.11E+11	1.70E+10	7.80E+10	1.45E+11	7.372394
Өр төлбөр						
Дугтуй	албан бус	8.88E+09	2.94E+09	3.11E+09	1.47E+10	0.4967668
Үржүүлэгч	албан бус	1.20E+10	1.48E+09	9.08E+09	1.49E+10	0.7671556
Дугтуй	мал аж ахуй	3.22E+08	2.21E+08	-1.12E+08	7.56E+08	5.142009
Үржүүлэгч	мал аж ахуй	4.28E+09	2.07E+09	2.18E+08	8.34E+09	7.741012

ХҮСНЭГТ 5.67 Малын тоо, ажил эрхлэлтийн байдлаар

АЭ-н байдал	Дундаж хэмжээ	Нийт
албан бус	13	1,640,144
МАА	167	23,171,692
албан	50	746,161
цалин хөлстэй	17	3,179,243
ажилгүй	12	1,241,466
Нийт	53	29,978,706

Гадаад мөнгөн гуйвуулга

Өмнөх хэсэгт үзсэн өрхийн орлогын дүн хэмжээ бүхий л эх үүсвэрээс олж байгаа орлогыг оруулсан байгаа. Энэ хэсэгт бид гадаад мөнгөн гуйвуулгаар орсон өрхийн орлогын хэсгийг илүү нарийвчлан авч үзэх болно. Судалгааны тооцооноос үзэхэд маш цөөн тооны өрхүүд (12,431 буюу 2.2 хувь) гадаад мөнгөн гуйвуулгаар орлого олдог боловч энэ төрлийн орлогын эх сурвалжтай хүмүүсийн хувьд нийт орлогынх нь нэг чухал хэсэг болдог буюу дунджаар 31 хувийг нь бүрдүүлдэг байна.

Хүснэгт 5.68-аас үзэхэд ийм гуйвуулга нь ажилгүйчүүдийн хувьд туйлын чухал бөгөөд жилийн өрхийн орлогынх нь 48 хувийг эзэлдэг хэмээн хариулсан байна. Ажилгүйчүүдийн орлогод эзлэх хувь ийнхүү өндөр байгаа нь их хэмжээний гуйвуулгаас бус харин өрхийн орлогын түвшин доогуур байдагтай нь холбоотой. Үнэндээ бусад ажил эрхлэлтийн байдалтай харьцуулахад ажилгүйчүүдийн жилийн дундаж гуйвуулгын орлогын хэмжээ хамгийн доод түвшинд буюу 344,850 төгрөг байна. Гуйвуулга хүлээн авдаг өрхүүдийн эзлэх хувь болон гуйвуулгын дундаж хэмжээ мал аж ахуйн салбарт хамгийн бага (0.9 хувь) байгаа ч хамгийн их хэмжээний буюу 609,380 төгрөгийн гуйвуулга авсныг мэдүүлсэн байна. Гуйвуулга хүлээн авдаг түвшин албан секторт 5.2 хувь буюу хамгийн өндөр байгаа ба гуйвуулгын хэмжээгээрээ 565,487 төгрөгөөр малчдын дараа орж байна. Гуйвуулга хүлээн авдаг өрхүүд авдаггүй өрхтэй харьцуулахад дунджаар 277,641 төгрөгийн илүү орлоготой байгаа ба энэ нь статистикийн хувьд нөлөөтэй зөрүү биш байна.

Хүснэгт 5.69 болон Хүснэгт 5.70-д бүс нутаг болон байршлаар гуйвуулгын ялгааг харуулав. Энд гуйвуулга хүлээн авдаг өрхийн ихэнх Улаанбаатарт байхад баруун бүсэд болон ерөнхийдөө хөдөөд маш цөөн байгааг тэмдэглэх хэрэгтэй. Баруун бүсийн цөөн тооны өрхийг эс тооцвол гуйвуулгын хэмжээний хувьд ихэнх хэсэг нь Улаанбаатар болон аймгийн төвийн өрхүүдэд очиж байхад сумд, хөдөө, мөн нэн ялангуяа зүүн бүсэд маш бага ногдож байна.

ХҮСНЭГТ 5.68 Гадаад мөнгөн гуйвуулга, ажил эрхлэлтийн байдлаар (жилийн)

АЭ-н байдал	Хэмжээ	Орлогын хувь	Өрхийн тоо
албан бус	457,477	26	2,948
МАА	609,380	14	1,261
албан	565,487	25	777
цалин хөлстэй	392,395	26	4,317
ажилгүй	344,850	48	3,193
Нийт	428,263	31	12,497

Гуйвуулгын хэмжээ төгрөгөөр, гуйвуулгын хувь гадаад мөнгөн гуйвуулгын өрхийн орлогод эзлэх хувиар. Өрхийн тоо нь гадаад мөнгөн гуйвуулга авч байгаа өрхийн тоогоор.

ХҮСНЭГТ 5.69 Гадаад мөнгөн гуйвуулга, бүс нутгаар (жилийн)

Бүс нутаг	Хэмжээ	Орлогын хувь	Өрхийн тоо
Баруун	1,026,079	29	732
Хангай	276,515	29	2,693
Төв	228,666	24	934
Зүүн	57,379	13	868
Улаанбаатар	494,177	34	7,269
Нийт	428,263	31	12,497

Хүснэгт 5.70-ын тэмдэглэлийг харна уу.

ХҮСНЭГТ 5.70 Гадаад мөнгөн гуйвуулга, байршлаар (жилийн)

Байршил	Хэмжээ	Орлогын хувь	Өрхийн тоо
Улаанбаатар	494,177	34	7,269
Аймгийн төв	563,162	31	1,544
Сумын төв	322,850	29	2,675
Хөдөө	26,362	8	1,009
Нийт	428,263	31	12,497

Хүснэгт 5.70-ын тэмдэглэлийг харна уу.

Үргэлжлэх хугацаа ба өөрчлөлт гарах хугацаа

Албан бус сектор дахь сүүдрийн үйл ажиллагааны эдийн засгийн үр дагавар нь мөн тухайн секторт орж, гарах боломжийн хэмжээнээс хамаардаг. Энэ секторт ажиллагсад өөр хаа нэгтгээ илүү их бүтээмжтэй ажиллаж чадахуйц ур чадвар олж авч байна уу? Хүснэгт 5.71-ээс харахад тийм гэсэн баттай нотолгоо байхгүй байна. Харин цалин хөлс авагчдын хувьд өмнө нь албан бус байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэж орлого олж байсан хүмүүс өмнө нь энэ секторт огт оролцож байгаагүй хүмүүсээс ихээхэн доогуур өрхийн орлоготой байна. Гэсэн хэдий ч цалин хөлс авагчид сэтгэл хангалуун бус байдлаас болж албан бус секторт хувиараа хөдөлмөр эрхлэхээр орж байгааг Хүснэгт 5.72-оос ажиглаж болно. Үүнд эдгээр хүмүүсийн 49 хувь нь энэ секторт орохгүй байх шалтгаан бол зээлийн хязгаарлалт гэж үзсэн байна. Тэгвэл тэдний 31 хувь нь авч байгаа цалин хөлсөндөө сэтгэл ханамжтай ба хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй байдаг байна.

ХҮСНЭГТ 5.71 Цалин хөлс авдаг гишүүнтэй өрхийн жилийн орлого, өрхийн аль нэг гишүүн 2001 оноос хойш хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олж байсан эсэхээр

2001 оноос хойш хувиараа хөдөлмөр эрхлэн орлого олж байсан эсэх					
	Тооцоо	Ст. Алдаа	[95% итгэмжлэх зааг]		D эффект
Тийм	1108051	132136.7	849038.9	1367063	0.833752
Үгүй	1508464	112165.7	1288599	1728329	1.055862

ХҮСНЭГТ 5.72 Цалин хөлс авагчийн хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олохгүй байгаа шалтгаан

АЭ-н байдал	Бүтэн цагийн ажилтай	Хөрөнгө бүрдүүлж чадахгүй	Татвар хэт өндөр	Ур чадвар байхгүй	Гэрийн ажилтай	Бусад	Нийт
	Цалин хөлстэй	0.3124	0.4925	0.035	0.055	0.0801	0.025

Албан бус секторт хувиараа бизнес эрхэлж байгаа хүмүүсийн хувьд зан байдал нь албан бус секторт ажилласан хугацааны урт богиноос хамаарч өөрчлөгдөж байгааг Хүснэгт 5.73-аас харж болно. Жишээлбэл, патентын бүртгэл, хураамжаар дамжуулан Албан бус секторын тухай хуулийг дагаж мөрдөх явдал албан бус секторт ажилласан жил нэмэгдэх тусам нилээд тогтвортой буурч байна. Хамгийн богино хугацаанд хувиараа хөдөлмөр эрхэлсэн (1.42 жил буюу түүнээс бага) 20 хувьд багтаж байгаа хүмүүсийн 67 хувь нь хуулийг дагаж мөрддөгөө мэдэгдсэн байхад, тус секторт есөөс дээш жил ажилласан хэсгийнхний хувьд энэ үзүүлэлт 38 хувь болж буурсан байна. Энэ байдлаас харахад албан бус секторт хувиараа хөдөлмөр эрхэлж хамгийн их туршлага хуримтлуулсан хүмүүсийн хувьд дүрэм журмыг дагаж мөрдөх, албан тушаалтнуудтай харьцах асуудлыг анхаарах нь багасаж байна.

Олон хувьсагчийн аргын жишээ: Албан бус секторт оролцох харьцангуй шалтгаан

Энэхүү 5 дугаар бүлгийн төгсгөлийн хэсэгт уг судалгааны өгөгдлийг ашиглан хийж болох олон хувьсагчийн статистик дүн шинжилгээний нэгэн жишээг танилцуулж байна. Тайлангийн энэ хэсэг хүртэл ашиглаж ирсэн дүрслэл тоо статистикээс ялгаатай нь нэгэн зэрэг хэд хэдэн хувьсагч эх сурвалжийг авч үзэх ба тэдгээрийн харьцангуй ач

ХҮСНЭГТ 5.73 Патентын хураамж төлөлт ба албан бус бизнес эрхэлсэн жилийн хамаарал

Одоогийн бизнесээ байсан	Өнгөрсөн сар патентын хураамж төлөх ёстой эрхэлсэн жил ба төлсөн эсэх		
	Үгүй	Тийм	Нийт
1.5	0.3273	0.6727	1
3	0.3769	0.6231	1
5	0.3416	0.6584	1
9	0.4702	0.5298	1
60	0.623	0.377	1
Нийт	0.4195	0.5805	1

Жич: мөрөн дэх хувь мөр тус бүр тухайн албан бус бизнес эрхэлсэн жил бүхий бизнесийн 20 хувийг төлөөлж байна. Жилийн тоо нь тус ангилалд орсон 20 хувийн төлөөллийн ажилласан жилийн дээд хэмжээг харуулна.

холбогдлыг илүү нарийн харьцуулах боломжийг олгож байгаа юм.

Энэхүү жишээнд албан сектор ба албан бус секторын хувиараа хөдөлмөр эрхлэгч бизнес эзэмшигчдийн хоорондын ялгааг нарийвчлан шинжлэх олон хувьсагчит пробит загварыг толилуулж байна. Энэ загварт тухайн бизнесийн

байршил ба салбар, мөн бизнес эрхлэгч хувь хүний өөрийн зан чанар болон өрхийн онцлог шинжид тулгуурлан албан бус секторт байх магадлалын таамаглалыг дэвшүүлж байна. Өмнө нь хувь хүний зан чанарыг ажил эрхлэлтийн байдал тус бүрээр харьцуулж хүснэгтээр гарган авч үзэж байсан олон үр дүнг энэ шинжилгээнд үргэлжлүүлэн хамруулав. Бид бусад бүх хувьсагчуудын утгыг тогтмол байлган сонирхсон хувьсагч бүрээр үр нөлөөг нь гаргаж үзэж болох учраас энэ аргын хүч чадал илүү их юм. Харин гарсан үр дүнг тайлбарлахдаа болгоомжтой хандах хэрэгтэй. Бид энд гарсан үр дүнгийн шалтгаант холбоосын чиглэлтэй холбоотой асуудлуудыг авч үзэх оролдлого хийгээгүй бөгөөд энэ тохиолдолд олон тэгшитгэл бүхий загварчлал шаардлагатай юм. Жишээлбэл, бид нэг хэмжүүрээр найдвартай итгэл даах чадвартай хүмүүс албан секторт байх илүү магадлалтай гэдгийг олж мэдэв. Тэгвэл энд гарсан үр дүн нь уг секторт итгэж болох хүмүүс ялгаран орсон эсэх эсвэл тэд албан секторт орж ажилласнаар илүү итгэл даах чадвартай болсон эсэхийг тогтоож чадахгүй гэсэн үг.

Уг загварт нэг бол 1 эсвэл 0 гэсэн утгатай байх сул хувьсагчийг бүс нутаг, байршил, салбар бүрийн хувьд оруулж тэдгээрийн өөр өөр үр нөлөөг хэмжихийг зорив. Энэ загварын тооцоог хийхдээ сул хувьсагчийг нэг нэгээр нь орхин, уг орхисон утга нь бусдыг харьцуулах тухайн бүс нутаг, байршил, салбар болж хувирна. Энэхүү загварт баруун бүс нутгийн хөдөө аж ахуйн үзүүлэлтийг бусдыг нь харьцуулах суурь болгон хэрэглэлээ.³⁶ Энэ загварт хүйс, нас (q17age), боловсрол (q20), өрхийн хэмжээ (q25), хүлээц тэвчээр (q30 ба q36), итгэл (q31), итгэл даах чадвар (q39), шударга байдал (q35), төрд итгэх итгэл (q40), төрийн ажилтны шударга бус хандлага (q41), эрсдэл (q44) зэрэг зан чанар, хандлагуудыг оруулж тооцов. Түүнчлэн бид бизнесийн бүртгэлийн шаардлагуудыг сахиулахад чиглэсэн хандлагуудтай холбоотой сул хувьсагчдыг оруулж байна (q137). Энэ асуулт нь 7 боломжит хариулттай бөгөөд хариулт 1 (“бүртгүүлэхгүй байхад ямар ч сөрөг үр дагавар байхгүй, хээл хахууль өгөөд л асуудлыг шийдчихэж болно”) -ийг энэ асуултын хувьд суурь болгон ашиглана. Мөн зохицуулалтын саад тотгорын тухай ойлголт (q148), авилгалын хамарч буй цар хүрээний тухай

ойлголт (q155), татвараас зайлсхийх явдал (q156) зэрэг холбоотой асуудлуудыг оруулав.

Тооцооны үр дүнг Хүснэгт 5.74-д үзүүлэв. Бидний гол сонирхол татсан мэдээлэл бол *delta Prob* буюу дельта магадлал гэсэн багана бөгөөд энд 1 дүгээр баганад³⁷ буй хувьсагчид гарсан аливаа өөрчлөлт албан бус секторт байх магадлалд ямар ахиуц өөрчлөлт авчирч байгааг тогтоож байна. *Дельта магадлал* эерэг утгатай байна гэдэг бол албан бус секторт байх магадлал илүү их байна гэсэн үг. Энд гарсан тооцооны үр дүнг ойлгоход уг ахиуц үр нөлөөний хэмжээ, түүний статистик ач холбогдол хоёул чухал байдаг. Статистик ач холбогдлыг үнэлэхийн тулд бид $P > |z|$ багананд гарсан р-утга 0.10-аас бага байгаа хувьсагчдыг авч үзэж статистик алдаанаас бусад шалтгаанаар үүсэх нөлөөллийг тодорхойлно. Тиймээс жишээлбэл насыг заагч *q17age* хувьсагч статистикийн нөлөөтэй ($p=0.076$) хэдий ч нөлөөллийн хэмжээ нь бага байна. Насны утга өөрчлөгдөхөд албан бус секторт байх магадлалыг -0,06 хувиар өөрчилж байгаа нь бага нөлөө байгаа ба залуу ажиллагсад албан бус секторт бизнес эзэмших магадлал арай илүү байгааг харуулж байна. Харин үүний эсрэг жишээ бол хүйсийн хувьсагч (эрэгтэй=1 ба эмэгтэй=0 гэж кодлосон) ба статистикийн хувьд нөлөөгүй (р-утга нь 0.137) 1.04 хувийн ахиуц нөлөөтэй байгаа нь бусад хүчин зүйлийг тогтмол гэж үзвэл сүүдэр эдийн засагт оролцоход хүйсээс хамаарсан ялгаа байхгүй байгааг илтгэнэ.

Албан бус секторт оролцох магадлалд хамгийн их нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл бол бүртгүүлэхгүй байхын үр дагаврын тухай ойлголт байв. Энэ хариултын хувьд харьцуулах суурь нь хээл хахууль өгөх шаардлагаас өөр сөрөг үр дагавар байхгүй гэсэн хариулт болохыг санах хэрэгтэй. Энэ асуултын (3), (5), (6) гэсэн хариултуудыг өгсөн хүмүүс албан секторт байх магадлал хавьгүй өндөр бөгөөд ахиуц нөлөө нь тус бүр -10.20 хувь, -15.62 хувь, -8.62 хувь байгаа ба р-утгын хувьд бүгдээрээ хүчтэй ач холбогдолтой гарсан байна. Эдгээр хариултууд нь хууль журмыг дагаж мөрдөхгүй байхаас үүдэн гарах зардалтай буюу тодорхойгүй боловч өндөр зардал (3), хүнд суртлын үр ашиггүй байдал (5), татвараа нөхөн төлөх шаардлага (6) зэрэгтэй холбоотой байна.

³⁶ Байрлалын хувьд Улаанбаатар (байрлал 1) болон хөдөө (байрлал 4) гэсэн байрлалыг оруулаагүй нь тэднийг бүс нутаг (бүс нутаг 5) гэдгээр нь оруулсантай холбоотой.

³⁷ Нэмэлт үр нөлөөг тухайн хувьсагчын дунджаар тооцов, эдгээр утга нь үр дүнгийн хүснэгтийн х-бар баганад байгаа.

Хувь хүний шинж чанаруудаас боловсрол (q20), итгэл даах чадвар (q39б) гэсэн хоёр хувьсагч статистикийн ач холбогдолтой хувьсагчдаас хамгийн их нөлөө үзүүлж байсан. Хоёулангийнх нь хувьд өндөр утга нь албан секторт оролцох оролцоотой холбоотой. Төрийн ажилтнуудын шударга бус хандлагын тухай ойлголт ч (q41) мөн албан секторын оролцоотой хүчтэй холбоотой байна. Эдгээр хувьсагчууд нь хууль сахиулах тухай асуултаас бага нөлөөтэй байсан ч (q20-д -2.57 хувь, q39б-д -2.30 хувь, q41-д -2.63 хувь) зан байдалд чухал ач холбогдолтой нөлөө үзүүлсэн хэвээр байв. Зохицуулалтын саад бэрхшээлийн тухай ойлголт бас чухал байдаг. Энд зохицуулалтын саад бэрхшээлийг чухалчилж үзсэн хүмүүсийн хувьд албан бус секторт байх магадлал ингэж үзээгүй хүмүүстэй харьцуулахад 2.8 хувь илүү байна.

Түүнчлэн бүс нутгийн болон салбарын үр нөлөө зарим талаар ач холбогдолтой байсан бөгөөд Хангайн бүс (-4.18 хувь) болон Төвийн бүсэд

(-3.11 хувь) хувь нь албан ёсны секторт байх магадлал илүүтэй, Зүүн бүс (5.97 хувь) албан бус байх магадлал өндөртэй байв. Улаанбаатарын хувьд суурь үзүүлэлт болох Баруун бүсийнхээс ($p=0.30$) нэг их ялгаагүй байв.

Одоо эдийн засгийн салбар албан бус үйл ажиллагаа явуулах шийдвэрт хэрхэн нөлөөлж байгааг авч үзье. Томоохон салбаруудын хувьд үйлдвэрлэлийн (4-р салбар), тээврийн салбар (9-р салбар) хоёр хөдөө аж ахуйн салбарыг бодвол нилээд албан ёсны байдалтай (тус бүр 4.30 хувь, 4.59 хувь) байсан боловч хамгийн том салбар болох худалдааны салбар (7-р салбар) хувьд хөдөө аж ахуйгаас нэг их ялгаатай байсангүй ($p=0.287$). Зочид буудал, зоогийн газрын салбар (8-р салбар) хөдөө аж ахуйн салбараас илүү албан ёсны шинжтэй (-4.54 хувь) байна. Санхүү, боловсрол, эрүүл мэнд гэх мэт цөөн жижиг салбарууд албан секторт илүү их төлөөлөлтэй байсан нь (тус бүр -12.79 хувь, -12.84 хувь, -18.43 хувь) нэг их гайхмаар зүйл биш байв.

ХҮСНЭГТ 5.74 Албан бус оролцооны пробит шинжилгээний дүн

Пробит тооцоо		Ажиглалтын тоо = 6318					
Log likelihood = -1794.5266		LR chi2(40) = 662.68					
		Prob > chi2 = 0.0000					
		Pseudo R2 = 0.1559					
shadow2	delta Prob	Ст. Алдаа	z	P> z	x-bar	[95%	И.З.]
gender*	0.0103859	0.0069841	1.49	0.137	0.50918	-0.003303	0.024074
q17age	-0.0005919	0.0003336	-1.77	0.076	39.7395	-0.001246	0.000062
q20	-0.0257137	0.0022578	-11.35	0	4.61048	-0.030139	-0.02129
q25	-0.0003224	0.0021867	-0.15	0.883	4.41722	-0.004608	0.003963
q30	-0.0122474	0.0030134	-4.06	0	2.65369	-0.018154	-0.00634
q31	-0.0018129	0.0044272	-0.41	0.682	1.94302	-0.01049	0.006864
q33	0.0072829	0.0046116	1.58	0.114	2.71921	-0.001756	0.016321
q35	0.0076088	0.0069116	1.1	0.271	1.47657	-0.005938	0.021155
q36	0.0007979	0.0004203	1.9	0.058	9.67569	-0.000026	0.001622
q39b*	-0.0229277	0.0072715	-2.96	0.003	0.753245	-0.03718	-0.00868
q40	-0.003819	0.0033222	-1.15	0.251	3.43906	-0.01033	0.002692
q41	-0.0263176	0.0049345	-5.33	0	1.42039	-0.035989	-0.01665
q44	-2.14E-06	1.32E-06	-1.62	0.106	1807.07	-4.70E-06	4.50E-07
_Iq137_2*	-0.0231716	0.0216261	-1.06	0.291	0.563944	-0.065558	0.019215
_Iq137_3*	-0.102005	0.0404939	-3.19	0.001	0.092909	-0.181371	-0.02264
_Iq137_4*	-0.041845	0.0713811	-0.68	0.494	0.006648	-0.181749	0.098059
_Iq137_5*	-0.1561566	0.0480348	-4.37	0	0.072175	-0.250303	-0.06201
_Iq137_6*	-0.0872593	0.0332851	-3.13	0.002	0.207186	-0.152497	-0.02202
_Iq137_7*	-0.04861	0.0459582	-1.25	0.212	0.019152	-0.138686	0.041466
q148	0.0285538	0.0077724	3.68	0	1.80073	0.01332	0.043787
q155	-0.0012807	0.0035477	-0.36	0.718	4.26242	-0.008234	0.005673
q156	0.0054081	0.0030138	1.79	0.073	3.67854	-0.000499	0.011315
_Iregi~2*	-0.0417587	0.0153167	-3.02	0.003	0.216049	-0.071779	-0.01174
_Iregi~3*	-0.0311075	0.0160931	-2.12	0.034	0.154004	-0.06265	0.000434
_Iregi~4*	0.0597119	0.0099069	3.36	0.001	0.04416	0.040295	0.079129
_Iregi~5*	0.0396875	0.0382784	1.03	0.303	0.468186	-0.035337	0.114712
_Iloca~2*	0.0514993	0.0359014	1.41	0.159	0.440013	-0.018866	0.121865
_Iloca~3*	0.0436495	0.0232569	1.43	0.153	0.084362	-0.001933	0.089232
_Isec~_3*	0.0398966	0.0270329	1.07	0.285	0.006964	-0.013087	0.09288
_Isec~_4*	0.0429267	0.0125999	2.84	0.005	0.176638	0.018231	0.067622
_Isec~_5*	-0.0429917	0.0897777	-0.56	0.575	0.002374	-0.218953	0.132969
_Isec~_6*	0.021471	0.0210012	0.9	0.369	0.023583	-0.01969	0.062633
_Isect~7*	0.0172487	0.0162658	1.07	0.287	0.520734	-0.014632	0.049129
_Isect~8*	-0.0453994	0.0278379	-1.9	0.057	0.043526	-0.099961	0.009162
_Isect~9*	0.0458564	0.0118277	2.98	0.003	0.112219	0.022675	0.069038
_Isec~10*	-0.1278727	0.0664144	-2.59	0.01	0.006015	-0.258043	0.002297
_Isec~11*	-0.0113675	0.0324756	-0.37	0.712	0.012504	-0.075018	0.052283
_Isec~13*	-0.1283704	0.078915	-2.19	0.029	0.003957	-0.283041	0.0263
_Isec~14*	-0.1843417	0.0699129	-3.69	0	0.007756	-0.321368	-0.04732
_Isec~15*	-0.0136218	0.02416	-0.6	0.55	0.040203	-0.060975	0.033731
obs. P	0.8947452						
pred. P	0.9254726	(at x-bar)					

(*) delta Prob нь сул хувьсагч 0, 1-н хооронд өөрчлөгдөхтэй холбоотой z ба P>|z| холбогдох итгэлцүүр 0-тэй тэнцүү байхыг шалгаж байгаа

БҮЛЭГ 6

Сурч мэдсэн зүйлс



Сурч мэдсэн зүйлс

Одоо бид албан бус сектор, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар юу сурч мэдсэн, мөн өрхийн судалгаагаар олж цуглуулсан баялаг мэдээлэлдээ тулгуурлан юу хийх үлдээд байгаагаа нэгтгэн дүгнэх боломжтой боллоо. Төгсгөлд нь бид сайжруулан боловсронгуй болгох төлөвлөгөө (мөн энэхүү төслөөр боловсруулсан)-г хэрэгжүүлэх дараагийн алхамуудыг санал болгож, улмаар Монгол дахь сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааг тогтмол, зардал багатайгаар хэмжиж тогтооход чиглэсэн ҮСГ-ын хүчин чармайлтын тогтвортой, иж бүрэн байдлыг хангахыг зорилоо.

6.1. ҮР ДҮНГИЙН ТОЙМ

Судалгаагаар гарсан үр дүнгүүдийг (i) хэмжилт ба тархалт, (ii) албан бус секторын шинж тэмдэг, (iii) шалтгаан, үр дагаврууд, (iv) хувилбаруудын нөлөөгөөр нь нэгтгэн дүгнэж болох юм. Бид албан бус секторыг мал аж ахуйн салбар (ЭЗЧАОУСА 012) ба бусад бүх салбар гэж хоёр хуваасныг санах хэрэгтэй.

Түүнчлэн өмнөх хэсэгт ярьсан зүйлс, хүснэгтүүд албан бус секторын дүр зургийг маш сайн гаргаж өгч байгаа ч хоёр анхаарах зүйл байгаа. Нэгдүгээрт, гарч байгаа үр дүнгүүд нь голцуу хоёр хувьсагчийн корреляцийн хамааралд (хоёр шинж чанарын хоорондын хамаарал) тулгуурлан дүрсэлсэн дүр зураг байгаа. Бүр нарийн тодорхой, баттай ойлголт бий болгохын тулд олон хувьсагчийн нэмэлт дүн шинжилгээ хийхийг зөвлөмж болгож байна. Хоёрдугаарт, судалгааны үр дүнг түүнд ашигласан янз бүрийн асуулгын аргуудтай уялдуулан тайлбарлах шаардлагатай бөгөөд түүнийгээ нэгтгэн дүгнэх ажил үлдээд байна. Санал асуулгын арга бүр, ялангуяа "эмзэг" (ял зэм тулгах боломжтой) асуултууд оролцсон асуудлуудтай холбоотойгоор өөр өөр статистик үр дүн гаргаж байгаа учраас тэр болтол дүгнэлт маань туршилтын шинжтэй хэвээр байх юм. Дараагийн 6.2 дахь хэсэгт энэ хоёр асуудлыг засч сайжруулах талаар авч үзнэ.

Хэмжилт ба тархалт

ҮСГ-аас 2004 оны ДНБ-ий хэмжээг урьдчилан тооцоолсноор 1,807 тэрбум төгрөг байна. Энэ дүнгээс бидний ҮСГ-ын өгөгдөлд тулгуурлан тооцооноор албан секторын үйл ажиллагааны 14.34 хувь буюу 259 тэрбум төгрөг нь албан бус секторын сүүдрийн эдийн засгийг хэмжих гэсэн урьд өмнөх оролдлогуудтай холбоотой байна (Бикалес нар, 2000). АБСӨС-ны дундаж тооцоогоор мал аж ахуйн салбарыг оруулахгүйгээр албан бус секторын сүүдрийн үйл ажиллагааны хэмжээг илүү сайн тооцож үзэхэд 24 хувь (үржүүлэгчийн арга) эсвэл 30 хувь (дугтуйн арга) болж байна. Албан бус секторын сүүдэр үйл ажиллагааны хэмжээ ингэж өргөжиж байгаа нь эдийн засгийн болон статистикийн шалтгаанаас аль алианаас нь үүдэлтэй. Нотлох баримтаас үзэхэд хэд хэдэн салбар, түүний дотор худалдааны салбарт ДНБ-ий нийт өсөлттэй харьцангуй өсөлт гарсан байна. Түүнчлэн АБСӨС-д бусад нэмэлт салбаруудыг хамруулснаас хамгийн чухал ач холбогдолтой нь үйлдвэрлэлийн салбар байлаа.

Маш их хэмжээний нэмэгдэл өртөг бүтээгч цөөн тооны жижиг аж ахуйн нэгж түүвэрт оршин байгаатай холбоотойгоор АБСӨС-д харьцангуй өргөн итгэмжлэх зааг бүхий үр дүн гарч байна. Бидний хийсэн шинжилгээ түүвэрлэгдсэн өрхүүдийн дотор эдгээр аж ахуйнууд бодитойгоор оршин байгааг харуулахын зэрэгцээ гарсан үр дүн нь тооллогод буюу өгөгдөл оруулах ажилд гардаг алдаанаас болоогүй ба ерөнхийдөө өгөгдлийн чанар өндөр түвшинд байгааг илтгэж байна. Ийнхүү олон тооны жижиг аж ахуйн нэгж болон цөөн тооны том аж ахуйн нэгжээс албан бус сектор бүрэлдэж байгаа нь энэ хоёр бүлгийн хувьд бодлогын асуудал болон шийдэл ялгаатай байх тул нэмэлт нарийн судалгаа шаардана. Энэ хоёр бүлгийн салган судалбал нэгтгэн судалсан үр дүнтэй харьцуулахад ядуурал илүү ноцтой асуудал болж гарах магадлалтай.

Албан бус секторын шинж тэмдэг

Судалгаагаар өрхийн гол орлого ологч хүмүүсийг хамруулах зорилго амжилттай биелсэн (92 хувь). Эдгээр хүмүүсийн зан чанар нь хууль дүрэм дагаж мөрдөх шийдвэр болон бусад эдийн засгийн зан үйлийг судлахад хамгийн холбогдолтой юм. Хувиараа хөдөлмөр эрхлэгч бүлгүүдийн хооронд хүйс, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо, настай холбоотой ялгаа нэг их байгаагүй боловч нийт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 53 хувь нь эрэгтэй байсантай харьцуулахад малчдын гуравны хоёр нь эрэгтэй байлаа. Боловсролын хувьд мал аж ахуйн бус албан бус секторынхон ерөнхийдөө малчдыг бодвол боловсролын түвшин өндөртэй, харин албан секторынхон малчин бус албан бус секторынхнаас илүү өндөр боловсролтой байлаа.

Уг судалгааг загварчлахдаа хувь хүмүүсийн гаргах эдийн засгийн шийдвэрийн төрөлд нийгмийн болон хувийн хандлага чухал үүрэг гүйцэтгэдэг тухай ИШАБС Төвийн бусад судалгааны ажлуудаас гарсан үр дүнгүүдэд тулгуурласан юм. 6.2 дугаар хэсэгт авч үзсэнчлэн эдгээр онцлог шинжүүд нь хэд хэдэн хазайлтыг засварлахад болон өөр өөр аргаас үүдсэн ажиглалтуудыг нэгтгэн багцлахад тустай байх болно. Ийм учраас энэхүү судалгаанд хүлээц тэвчээр, итгэл, түүний дотор төр засгийн итгэлтэй байдал, итгэл даах чадвар, үнэнч шударга байдал, мөн эрсдэл даахад бэлэн байдал гэх мэт олон янзын асуудлуудыг хамарсан асуултуудыг тавьсан юм. Эндээс ерөнхийдөө мал аж ахуйн салбарынхны хандах хандлага бусдаасаа нилээд өөр байхад албан ба албан бус секторын бизнес эрхлэгчдийн хандлага хоорондоо адил төстэй байх нь нийтлэг байгааг бид олж мэдлээ.

Нэн ялангуяа, албан секторын бизнес эзэмшигчид бусад бүх бүлгийн дотроос тэвчээр, итгэл хамгийн муутай бол малчид хамгийн их итгэлтэй болохыг мэдлээ. Итгэл хүлээх чадварын хувьд нэг их ялгаа ажиглагдсангүй. Хариулагчдын дөнгөж 25 хувь нь шашны байгууллагад байнга очдоогоо илэрхийлсэн байна. Үнэнч шударга зан, шударга ухамсрын хувьд өөрсдийгөө үнэлэхэд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамгийн өндөр, харин хувиараа эрхлэх аж ахуйн эзэд хамгийн бага үзүүлэлттэй байв. Энэ талаар албан ба албан бус секторын хооронд ямар нэг томоохон ялгаа гарсангүй. Эрсдэлд хандах хандлагын хувьд малчид эрсдэл хүлээх илүү сонирхолтой байсан нь тэдний орлогын түвшин доогуур байдлыг харгалзаж үзэх юм бол хамгийн гайхмаар үр дүн

байлаа. Эцэст нь төрд итгэх итгэл, төрийн шударга ёсны талаарх судалгаанд оролцогчдын үзэл бодол нь тухайн бизнесийн албан ёсны байдал багасах тусам буурч байсан нь бизнес албан ёсны болох тусам нэмэгддэг сөрөг үр дагавруудтай холбоотой юм.

2004 оны 9 дүгээр сард ойролцоогоор 286,000 өрх хувиараа хөдөлмөр эрхэлсний орлого олж байснаас мал аж ахуйн салбар (49 хувь), мал аж ахуйн бус албан бус сектор (46 хувь) болон албан сектор (5 хувь) ногдож байна. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийг бүс нутгийн байдлаар авч үзэхэд мал аж ахуйн бус албан бус секторын хувьд Зүүн бүсэд 19 хувьтайгаас эхлээд Улаанбаатарт 86 хувь хүртэл янз бүр байна. Байршилын ялгаа ч бас их байлаа. Мал аж ахуйн бус албан бус сектор дахь хувиараа хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувь хөдөөд 5 хувьтайгаас эхлээд сумын төвд 73 хувь, аймгийн төвд 82 хувь байна. (Энд бид хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн тоог ярьж байгаа бол өмнө нь бид хэмжилтийн тухай ярих үедээ хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааны үнэ цэнийн тархалтыг ярьсан гэдгийг анхаарна уу.)

Хувиараа хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн салбарын бүтцээр авч үзвэл худалдааны үйл ажиллагаа, түүний дотор бөөний ба жижиглэнгийн худалдаа, засвар үйлчилгээ нийлээд албан ба албан бус сектор дахь нийт хувиараа хөдөлмөр эрхлэлтийн 50 хувийг эзэлж байгааг олж тогтоов. Гэхдээ худалдааны салбар дотор нь авч үзвэл хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн 90 хувь нь албан бус секторт байхад дөнгөж 10 хувь нь албан секторын бизнес байв. Албан бус секторын өрхийн тоогоор дараагийн том эдийн засгийн салбарт үйлдвэрлэл (20 хувь), тээвэр, агуулах, харилцаа холбоо (11 хувь)-ны салбарууд орж байна. Эцэст нь, албан ёсны хувиараа эрхлэх аж ахуйнууд дунджаар 4.9 ажилтантай (эзнийг нь оруулаад) байгаа нь дунджаар 2.3 ажилтантай албан бус секторын аж ахуйнуудаас бараг хоёр дахин том хэмжээтэй байна.

Бүхий л бизнесийн хувьд гэр бүлийн гишүүндээ цалин хөлс олгох явдал ховор байсан бөгөөд цалин авагсдын эзлэх хувь албан бус секторт хамгийн өндөр байсан нь хүлээж байсан үр дүн юм. Мал аж ахуйн бус албан бус сектор дахь ажиллагсдын дотор гэр бүлийн цалингүй ажилчид зонхилж байна. Харин албан секторт ажиллагсад ихээхэн илүү цагаар ажиллаж, басхүү цалин хөлс ч сайтай байна. Хөдөлмөрийн ахиуц

бүтээгдэхүүнийг тооцсон бидний тооцоогоор нэг цагийн хугацаагаар нэмэлт ажилчин хөлслөн ажиллуулах өртөг малчдын хувьд тун ялихгүй (47 төгрөг) байхад малчин бус албан бус секторынхны хувьд 387 төгрөг, албан секторын бизнесүүдийн хувьд 666 төгрөг байна. Эцэст нь, албан ба мал аж ахуйн бус албан бус секторын бизнесийн үйл ажиллагаа жилд 2-3 сараар тасарч байхад малчдын хувьд тогтмол үйл ажиллагаа байх онцлогтойг дурджээ.

Хувийн салбар дахь хамтын үйл ажиллагаа голцуу бизнесийн холбоодоор дамжин явагддаг. Судалгаанд оролцогчдын 98-аас илүү хувь нь бизнесийн холбоодын үйл ажиллагаанд оролцдоггүй гэж хариулсан нь нэгдмэл үйл ажиллагааны түвшин Монголд доогуур байгааг харуулж байна.

Албан ёсны аж ахуйн нэгжүүд бичмэл данс бүртгэлтэй байх магадлал 2 гаруй дахин их байна (77 хувь ба 36 хувь). Томоохон албан бус секторуудад бичмэл данс бүртгэл ховор байгаа салбарт үйлдвэрлэл (20 хувь), барилга (9 хувь), тээвэр, агуулах, харилцаа холбоо (11 хувь) орж байна. Бизнесийн ажлын байрны байрлалын хувьд гэр орондоо тулгуурлан бизнес эрхлэгчдийн эзлэх хувь албан бус секторт бага зэрэг илүү байна. Мал аж ахуйн бус албан бус секторынханы дөнгөж 40 хувь нь тогтвортой, гэрийн бус ажлын байртай байхад энэ тоо албан секторт 56 хувь байна. Өмчлөлийн төрлийн хувьд албан ба албан бус сектор (мал аж ахуйн бус бус) нэг их ялгаагүй байсан ба аль аль салбарт ойролцоогоор 60 орчим хувь нь нэг хүний өмчлөлтэй гэжээ.

Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд гуравны хоёроос (албан ёсны жижиг бизнес) наймны долоо (малчид) хүртэл хэмжээг өөрийн (эсвэл гэр бүлийн) эх үүсвэрээс гаргасан байна. Үлдэх хувь нь бусад боломжит эх үүсвэрүүдэд хуваагдсаны дотор банкуудыг мөнгө зээлдүүлэгчид буюу гэр бүлийн найз нөхөдтэй бараг адилаар чухалчилж үзсэн байна. Албан секторын жижиг бизнесүүдийн гуравны нэг хувь нь зээл авч үзсэн байхад албан бус секторын бизнесүүдийн дөнгөж наймны нэг орчим нь зээл авч байжээ.

Эцэст нь маргаан шийдвэрлэх тал дээр шүүх ерөнхийдөө ажилдаг гэдэгтэй санал нэгтэй байгаа бөгөөд дөнгөж 10 хувь нь л шүүхийн чадавхи, авилгал буюу шүүхээр шийдвэрлүүлэх өртөг зардалтай холбоотой дутагдалтай талуудыг шүүхийн тогтолцоог хэрэглээгүй шалтгаан гэж дурдсан байна. Мөн 7 хувь нь маргааныг шүүхээр

яаж шийдвэрлүүлэхээ сайн мэдэхгүйгээс шүүхэд хандаагүй гэсэн байхад нийт өрхийн бараг 83 хувь нь энэ механизмыг хэрэглэхэд бэлэн байгаагаа илэрхийлжээ. Ажил эрхлэлтийн байдлаар авч үзэхэд ч эдгээр үр дүн адил төстэй байлаа. Нэг зүйл анхааруулахад өмнө нь шүүхээр орж, уг тогтолцоог ашиглаж байсан хүмүүсийн хувьд дахин шүүхэд хандахад бэлэн байдал зарим талаар буурч байгаа ч статистикийн хувьд нөлөөтэй биш байна. Гэхдээ энэ бүлгийн хувьд хээл хахуулийн асуудал болон ерөнхийдөө шүүхийн тогтолцооны найдваргүй байдалтай холбоотой сэтгэл зовнил байдгийг илэрхийлжээ.

Шалтгаан, үр дагаврууд

Судалгаагаар ихээхэн хэмжээний мэдээллийг цуглуулсан тул энэхүү тайланд бодлогын бүхий л асуудлын багахан хэсгийг л хөндсөн болно. Энэ санааг 6.2-р хэсэгт дэлгэрүүлэн авч үзэх болно. Бидний хэлж чадах зүйл бол зохицуулалтын асуудлууд болон хууль журмыг дагаж мөрдөхгүй байхаас ноцтой үр дагавар үүсэхгүй гэсэн ойлголт хоёр бол судалгаанд оролцогчдын хүлээн зөвшөөрсөн олон тооны хууль бус үйлдэлтэй холбоотой хүчин зүйлүүд юм. Албан секторын бизнесийнхэн салбарын шинжтэй зохицуулалтууд, мөн бизнесийн бүртгэлийн үйл явц хамгийн том саад бэрхшээлүүд гэж үздэг. Харин салбарын шинжтэй зохицуулалтууд, гаалийн ба хөдөлмөрийн зохицуулалтууд бол албан бус секторынханы санаа зовоосон асуудлууд юм. Яг аль салбарын зохицуулалт асуудал болж байгаа талаар албан ба албан бус ажил эрхлэлтийн байдлын хооронд ялгаатай байдал ажиглагдаж байна. Эндээс үзэхэд албан секторын зохицуулалтаас зайлсхийх нь албан бус ажиллагааг өдөөгч хүчин зүйл байж болох байна. Албан ба албан бус секторын хооронд зохицуулалтын саад бэрхшээл байна гэж үзэгсэдийн эзлэх хувь барилга, үйлдвэрлэл, зочид буудал ба зоогийн газар, тээврийн салбарт хамгийн их зөрөөтэй гарч байна. Харин санхүү, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт зохицуулалтын саад бэрхшээлийн тухай ойлголтын зөрүү харьцангуй адил төстэй байна.

Бүртгэлийн шаардлагын хувьд албадан бүртгэх гэх мэтээр хууль дүрэм зөрчигчдөд ногдуулах шийтгэл бага байгаатай дийлэнх нь санал нэг байлаа. Харин дээрх зөрчлүүд илрэх магадлал өндөр гэж үзэх явдал их бөгөөд энэ нь албан бус секторын тухай хуулийг дагаж мөрдөгсдийн эзлэх хувь ойролцоогоор 60 хувьтай тэнцэхэд хүргэж байна.

Хувилбар аргуудын нөлөө

Авилгалын практик болон татвараас зайлсхийх явдалтай холбоотой судалгааны үр дүнг хэлэлцэх явцад хос асуултын аргаар авсан хариултууд дээр үндэслэсэн дүнг ашиглах нь зүйтэй гэж үзэхэд хүргэсэн юм. 2 дугаар хэсэгт дурьдсанчлан дугтуйн болон холих хэрэгслийг аль алийг нь ашигласан учраас хоёр асуултын арга нь "тийм-үгүй" гэсэн хариулттай асуултуудад хэрэглэх хамгийн тохиромжтой хэлбэр байв. Ийм учраас ярилцлагын үеэр болон дараа судалгаанд оролцогчдын нууцлалыг хамгаалж байв. Энэ хэсэгт бид ерөнхийдөө хос асуултын аргыг ашиглан илүү хувийн чанартай эмзэг мэдээллийг олж авч байсныг харуулах дүрслэл статистик тоо баримтуудыг толилуулав байна. Түүнчлэн Хүснэгт 6.1-д бусад хэд хэдэн сонирхолтой, чухал үр нөлөөнүүдийг илрүүлэн харууллаа.

Хүснэгт 6.1-д байгаа 1-р хувилбар бол шууд асуултын арга юм. 2 ба 4-р хувилбарт дугтуйн аргыг, 3 ба 5-р хувилбарт хос асуултын аргыг ашиглав. 2 ба 4-р хувилбар хоорондоо ялгаатай нь орлого ба тайлан тэнцлийн хэсэгт 2-р хувилбар нь дугтуй ашиглаж, 4-р хувилбар нь үржүүлэгч ашигласан болно. Мөн 3 ба 5-р хувилбар нь яг энэ талаараа ялгаатай байгаа. Хоёр тохиолдлын хоёуланд нь орлогын ба тайлан тэнцлийн асуултуудын хувьд бага дугаартай хувилбар нь нууцлалын хувьд арай найдвартай бус аргуудыг хэрэглэсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд хэдийгээр үр нөлөө багатай ч орлогын ба тайлан тэнцлийн асуултын үед илүү аюулгүй байдлаар

хангагдсан оролцогч нар судалгааны дараагийн хэсгүүдэд хувийн чанартай эмзэг мэдээллийг ил гаргахад илүү бэлэн байсан нь тууштай харагдаж байлаа. Жишээлбэл, 158-р асуултад 2-р хувилбараар асуухад оролцогчдын 8.5 хувь нь экспорттой холбоотой хээл хахуулийг хүлээн зөвшөөрсөн бол 4-р аргыг хэрэглэхэд 11.5 хувь нь үүнийг хүлээн зөвшөөрч байлаа.

Энэхүү ялгаанууд нь тодорхой нэг сэдвийн хувьд асуултын хэлбэр чухал төдийгүй, оролцогчийн нууцлалыг хамгаалахтай холбоотой судалгааны ерөнхий өнгө аяс ч чухал нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Судалгааны эхний хэсэгт аюулгүй асуултын хэлбэрүүдийг ашиглаж хариулагчийг нууцлалаар хангах хүчин чармайлт тавьсан нь дараа дараагийн асуултад хариулт авахад асуултын хэлбэр ялгаагүй байсан ч эерэгээр нөлөөлж байв. Энэ үр нөлөө нь хариултын нууцлалын баталгааг хангах нь үнэн зөв хариулт авахад чухал ач холбогдолтой болохыг харуулсан өмнөх хэлэлцүүлэгтэй нийцэж байна (*Moore ба Loomis, 2001*). Судалгааны талаарх ерөнхий сэтгэгдлийн асуудлыг үл ойшоож болохгүйн зэрэгцээ хувийн чанартай эмзэг асуултуудын хэсэг дээр дугтуйн болон хос асуултын аргыг шууд харьцуулж үзэхэд эрс өөр нөлөөтэй байгааг бид олж харлаа. Хүснэгт 6.2-т бид 2 ба 4-р хувилбарууд (дугтуйн)-н өгөгдлийг 3 ба 5-р хувилбар (хос асуултын)-р авсан ажиглалттай нэгтгэж, мөн харьцуулах боломж олгох үүднээс шууд асуултын аргыг ч толилуулав (хувилбар 1).

ХҮСНЭГТ 6.1 Эмзэг асуултуудад хувилбаруудын үзүүлэх нөлөө

Асуулт 158-163-г хувиараа хөдөлмөр эрхлэгч нараас асуув.
Асуулт 164-г бүх оролцогчдоос асуув.

A158 Та гаалийн ажилтанд хахууль өгсөн үү?

Хувилбар	"Тийм" гэж хариулагсдын хувь	Хувилбарт хамрагдагсдын тоо
Хувилбар-1	0.1011905	168,0
Хувилбар-2	0.0853081	1,055
Хувилбар-3	0.1666525	1,253
Хувилбар-4	0.1153846	156
Хувилбар-5	0.1817627	4,848
Нийт	0.1624333	7,480

A159 Та Монголд нууцаар бараа оруулж ирж байсан уу?

Хувилбар	"Тийм" гэж хариулагсдын хувь	Хувилбарт хамрагдагсдын тоо
Хувилбар-1	0.1011905	168,0
Хувилбар-2	0.1090047	1,055
Хувилбар-3	0.1686605	1,253
Хувилбар-4	0.1217949	156
Хувилбар-5	0.1975703	4,848
Нийт	0.176491	7,480

A160 Та өөрийгөө албан бус секторын татвар төлөх ёстой гэж үздэг үү?

Хувилбар	"Тийм" гэж хариулагсдын хувь	Хувилбарт хамрагдагсдын тоо
Хувилбар-1	0.6369048	168
Хувилбар-2	0.5905213	1,055
Хувилбар-3	0.6907012	1,251
Хувилбар-4	0.6474359	156
Хувилбар-5	0.6929926	4,847
Нийт	0.6759399	7,477

A161 Та албан бус секторын татвар төлсөн үү?

Хувилбар	"Тийм" гэж хариулагсдын хувь	Хувилбарт хамрагдагсдын тоо
Хувилбар-1	0.5963303	109
Хувилбар-2	0.6305344	655
Хувилбар-3	0.5909976	898
Хувилбар-4	0.5471698	106
Хувилбар-5	0.561185	3,478
Нийт	0.5753941	5,246

ХҮСНЭГТ 6.1-ийн үргэлжлэл

A162 Та төрийн албан тушаалтнуудад мөнгө өгч байсан үү?

Хувилбар	"Тийм" гэж хариулагсдын хувь	Хувилбарт хамрагдагсдын тоо
Хувилбар-1	0.1666667	168
Хувилбар-2	0.1488152	1,055
Хувилбар-3	0.2675456	1,251
Хувилбар-4	0.1730769	156
Хувилбар-5	0.2921428	4,848
Нийт	0.2625044	7,478

A163 Та төрийн албан тушаалтанд бэлэг өгч байсан уу?

Хувилбар	"Тийм" гэж хариулагсдын хувь	Хувилбарт хамрагдагсдын тоо
Хувилбар-1	0.2678571	168
Хувилбар-2	0.2018957	1,055
Хувилбар-3	0.1268526	1,252
Хувилбар-4	0.2115385	156
Хувилбар-5	0.1934035	4,848
Нийт	0.1855114	7,479

A164 Та татвараа хуулиар тогтоосон бүрэн хэмжээгээр төлсөн үү?

Хувилбар	"Тийм" гэж хариулагсдын хувь	Хувилбарт хамрагдагсдын тоо
Хувилбар-1	0.581749	263
Хувилбар-2	0.5993091	1,737
Хувилбар-3	0.5919496	2,048
Хувилбар-4	0.5402299	261
Хувилбар-5	0.5673019	7,855
Нийт	0.5757537	12,164

Нэг онцлог тохиолдлоос бусад тохиолдолд хос асуултын арга үр дүнтэй байгааг бид үзлээ. 158-р асуултад гаалийн ажилтанд өгсөн хахуультай холбоотой асуултад хос асуултын аргаар нэмэлт нууцлалыг хангасны дараа уг үйлдлийг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийн тоо хоёр дахин нэмэгдэж байлаа (9 хувь ба 18 хувь). Хилээр бараа хууль бусаар оруулахтай холбоотой асуулт ч үүнтэй төстэй үр дүнд хүргэж байгаа бөгөөд хоёр асуултын аргаар авахад 19 хувь нь, дугтуйн аргаар авахад 11 хувь нь энэ үйлдлийг хүлээн зөвшөөрсөн байна. Эдгээр үр дүн нь статистик ач

холбогдолтой буюу р-утга нь 0.01-с бага утгатай гарч байв. Шууд өгсөн хариултуудын хувьд дугтуйн аргаар авснаас нэг их ялгаагүй байлаа.

Патентын зөвшөөрөл олгох шаардлагыг хангах, дагаж мөрдөх байдлын тухай асуултууд ч хос асуултын аргыг ашигласны үр дүнд илрүүлэх чадвар илүүтэй байлаа. Эхний асуулт (q160) нь зөвхөн патентын зөвшөөрлийг дагаж мөрдөх байдлын тухай асуултыг асуувал зохих хүмүүсийг тогтооход зориулагдав. Энэ нь тийм ч их эмзэг байна гэж төсөөлөөгүй боловч дагаж мөрдөх шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийн тоо

хос асуултын аргад нилээд их гарч байлаа (69 хувь ба 60 хувь). Энэ нь магадгүй хүмүүс хууль журмыг дагаж мөрдөх талаар дагалдах асуулт байна гэж бодсон эсвэл ерөөсөө нэмэлт нууцлалыг хангаж өгөхгүй бол патентын зөвшөөрлийн тухай асуудлыг хөндөхөд арай бэлэн бус байсныг илтгэж байна. Түүнчлэн хууль дүрмийг сахин биелүүлэгчдийн эзлэх хувийн зөрүү харьцангуй бага байсны дотор хос асуултын аргад 57 хувь нь, дугтуйн аргад 62 хувь нь дагаж мөрддөг гэжээ. Гэвч дээр дурдсанчлан дугтуйн аргаар хариултыг авахад илүү олон тооны үл даган мөрдөгчид энэ асуултад хариулаагүй нь харагдаж байна. Аль ч арга зүйн үр дүнгээс үзэхэд патентын зөвшөөрлийг дагаж мөрдөх асуудал нэг чухал бодлогын асуудал болох нь харагдлаа.

Ерөнхийдөө хээл хахуультай холбоотой судалгааны үр дүн ч хилийн үйл ажиллагааны асуудлын нотлох баримттай ижил хэв маягтай байлаа. Хос асуултын аргаар 29 хувь нь хээл хахуулийг хүлээн зөвшөөрсөн байхад дугтуйн аргад 15 хувь нь, шууд асуултын аргад 19 хувь нь зөвшөөрсөн ба сүүлийн хоёр аргын хувьд статистикийн хувьд хоорондоо нэг их ялгаагүй утгатай байлаа. Хээл хахуулийн асуултын дараа арай эмзэг бус асуулт болох мөнгөн бус бэлэг бусдад өгөх тухай асуулт байлаа. Сонирхолтой нь энэ асуултын үр дүн эсрэгээр эргэж, хос асуултын аргаар хамгийн бага хувь нь (18 хувь), шууд асуултын аргаар хамгийн их хувь нь (26 хувь) бэлэг өгдөг болохыг илрүүлжээ. Мөнгөн хэлбэрийн хахууль ба бэлэг өгөх явдал аль аль нь нилээд газар авсан үзэгдэл мэт боловч, хүмүүст шууд асуулт тавихад мэдрэмж багатай зан байдал нь мэдрэмж ихтэй зангаар солигдож байгаад гайхах зүйл байсангүй. Сүүлчийн асуулт болох татвараас зайлсхийх явдлын тухай асуултын хувьд асуултын төрлөөс хамаарсан статистик ач холбогдолтой зөрүү харагдаагүй учраас бид энэ асуулт бол хувийн чанартай эмзэг асуулт биш байна гэж үзэхэд хүргэсэн.

ХҮСНЭГТ 6.2 Хэрэглэсэн аргын нөлөө, 2-4 ба 3-5

Хувилбар	дундаж(q158)	тоо
Шууд	0.1011905	168
Дугтуй	0.0891825	1,211
Хос асуулт	0.1786594	6,101
Нийт	0.1624333	7,480
Хувилбар	дундаж(q159)	тоо
Шууд	0.1011905	168
Дугтуй	0.1106523	1,211
Хос асуулт	0.1916329	6,101
Нийт	0.176491	7,480
Хувилбар	дундаж(q160)	тоо
Шууд	0.6369048	168
Дугтуй	0.597853	1,211
Хос асуулт	0.6925225	6,098
Нийт	0.6759399	7,477
Хувилбар	дундаж(q161)	тоо
Шууд	0.5963303	109
Дугтуй	0.6189225	761
Хос асуулт	0.5673029	4,376
Нийт	0.5753942	5,246
Хувилбар	дундаж(q162)	тоо
Шууд	0.1666667	168
Дугтуй	0.1519405	1,211
Хос асуулт	0.2870975	6,099
Нийт	0.2625044	7,478
Хувилбар	дундаж(q163)	тоо
Шууд	0.2678571	168
Дугтуй	0.2031379	1,211
Хос асуулт	0.1797442	6,100
Нийт	0.1855114	7,479
Хувилбар	дундаж(q164)	тоо
Шууд	0.581749	263
Дугтуй	0.5915916	1,998
Хос асуулт	0.5723991	9,903
Нийт	0.5757537	12,16

6.2. СУДАЛГААНЫ ХЭРЭГСЭЛ БА ДҮН ШИНЖИЛГЭЭГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ БОЛОМЖУУД

Өмнөх хэсгүүдэд танилцуулсан АБСӨС-ны дүн шинжилгээ нь уг судалгааны явцад цуглуулсан өгөгдлийн бүрэн дүүрэн шинжилсэн явдал биш бөгөөд бид энэ хэсэгт уг дүн шинжилгээг боловсронгуй болгохын тулд хийж болох нэмэлт ажлууд, уг судалгааны илүү хэрэгцээтэй дүнг гаргаж авах талаар өгүүлэх болно. Эдгээр сайжруулах арга замын заримд нь уг судалгаанаас гадуур цуглуулах өгөгдлийг ашиглах шаардлагатай байхад заримд нь зүгээр л АБСӨС-ны өгөгдөлд өөрт нь нэмэлт үзэл баримтлал буюу арга техник хэрэглэж болно. Цаашилбал, АБСӨС-г хэрэгжүүлж, дүн шинжилгээг хийх явцад хэрвээ ирээдүйд иймэрхүү судалгаа дахин хийх болвол хэрэгжүүлэлтийн зарим нэг талыг сайжруулж болох нь тодорхой болсон. Бид энэ хэсэгт эдгээр асуудлуудыг аль алиныг нь авч үзэн судалгааны хэрэгсэл, дүн шинжилгээ төдийгүй судалгааны түүврийг сонгохтой холбоотой зарим асуудлуудыг боловсронгуй болгох боломжийг тогтоох болно.

Дүн шинжилгээг боловсронгуй болгох нь

Сүүдрийн эдийн засгийн хэмжүүр ба бодлогын утга агуулгатай аль алинтай нь холбоотойгоор шинжилгээг боловсронгуй болгох боломжтой бөгөөд ингэвэл ашигтай мэдээлэл өгнө гэдэгт бид итгэж байна. Албан бус секторын сүүдрийн эдийн засгийн хэмжээг ерөнхийд нь хэмжихтэй холбогдуулан бид загварчлалд тулгуурласан тооцоо гаргаж харуулсан бөгөөд энэ нь түүвэрлэлтийн төлөвлөгөөнөөс гаргаж авсан судалгааны тархаалтын жинд үндэслэсэн байгаа. Загварчлалд тулгуурласан тооцооны үнэн зөвийг шалгах зорилгоор хэрэглэж болох өөр нэг боломжит арга бол АБСӨС-аас гадуур нэмэлт өгөгдөл ашиглан албан бус секторын сүүдрийн хэмжээг эконометрик аргаар загварчлан тооцох явдал юм. Ийм загварт тулгуурласан тооцооны хувьд хамгийн шийдвэрлэх чухал өгөгдөл бол ҮСГ-аас гаргадаг албан секторын бизнесийн бүртгэлийн тоо баримт, Сангийн яамнаас гаргадаг патентын зөвшөөрлийн бүртгэлийн хэмжээний тоо баримтууд юм. Эконометрик загварт тулгуурласан аргууд нь бидний ашигласан загварчлалд тулгуурласан хэмжилтүүдийн үнэн зөвийг шалгахын зэрэгцээ АБСӨС-ны өгөгдлүүдийг бүх аймаг, суманд бэлэн байдаг тоо баримтуудтай холбож өгснөөрөө улсын

хэмжээгээр АБСӨС-нд хамрагдаагүй бусад газруудын албан бус сүүдрийн үйл ажиллагааны хэмжээ, салбарын тархалтыг тооцох боломж олгох юм.

Үнэлгээ хийх тэргүүлэх чиглэлээ яаж тогтоосноос хамаарч загварчлах аргуудыг янз бүрийн түвшинд хэрэгжүүлж болно. Жишээлбэл, бизнесийн бүртгэлд тулгуурласан албан секторын мэдээлэл бүхий загварын хувьд АБСӨС-ны албан секторын үр дүнг нэмэлт болгон ашиглаж болох юм. Загварчлалд тулгуурласан тооцооны хувьд АБСӨС нь бизнесийн бүртгэлд байгаа аж ахуйн нэгжүүдийн ойролцоогоор 80 орчим хувийг төлөөлж буй өрхүүдийг түүвэрлэн сонгож авсан гэж үзэж байна. Албан секторын мэдээллийн энэ хоёр эх сурвалжийн уялдаа холбоог судлах замаар албан бус секторын илүү сайн загвар гаргаж авч болох юм.

Энэ тайланд өмнө дурдаж байсан загварт тулгуурласан хэмжилтүүдийг ч бас боловсронгуй болгох боломжтой. Судалгааны хэмжилтүүдийг сайжруулж болох нэг чиглэл бол албан бус секторын сүүдрийн үйл ажиллагааны хэмжээний бүс нутгийн тархалтыг үнэлэх явдал юм. Төсвийн хязгаарлагдмал байдлаас үүдэн бүс нутаг бүрээс хязгаарлагдмал тооны аймгийг сонгож судлахыг шаардлагатай байсан. Энэхүү хязгаарлалт нь бүс нутаг бүрийн хойноос урагших ялгавартай байдлыг бүрэн хэмжих явдлыг хүндрэлтэй болгосон юм. Ингэснээр тухайн үйл ажиллагааны бүс нутгийн хэмжилтүүд хазайлттай байж болно. Гэхдээ энэ судалгаа бүхэлдээ хойд болон өмнө зүгийн аймгуудын үндэслэлтэй тархалтыг агуулсан. Иймээс бид тухайн үйл ажиллагааны бүс нутгийн тархалтын тооцоог сайжруулахын тулд бусад бүсүүдийн үр дүнг ашиглан тухайн бүс нутгийн үйл ажиллагаанд дүгнэлт хийдэг "хуваарилалтын дараахь" аргуудыг ашиглаж болно. Мөн тооцооны нарийвчлал дээр цаашид ажиллах шаардлагатай. Энд авч үзэх шаардлагатай хэд хэдэн боломж бий. Юуны өмнө өгөгдлийн сангийн хэвийн бус тархалт нь цөөн тооны аж ахуйн нэгжүүд нийт сүүдрийн хэмжээнд болон түүний вариацийн тооцоонд ихээхэн нөлөө үзүүлнэ гэсэн цаад санааг агуулж байна. Энэ нь маш өндөр орлоготой цөөн тооны аж ахуйн нэгжүүд нийт аж ахуйн нэгжийн оруулж буй хувь нэмрийн жилээр тооцсон дүнгийн тархалтын дээд төгсгөлд "урт сүүл" бий болгодогтой холбоотойгоор үүсдэг. Эдгээр ажиглалтыг судалгаанаас хасч тооцох нь буруу гэж үзэж байна. Түүнчлэн сүүдрийн үйл ажиллагааны

шалтгаан, үр дагаварын талаар нэмэлт таамаглал дэвшүүлэх, мөн сонирхолтой хэмжилтийн үр дүн гаргахын тулд тэрхүү дээд хэсгийн тархалтыг болон судалгааны “их бие”-ийг бүрдүүлж байгаа 90 хувийн ажиглалт хоёрыг тус тусд нь шинжилж үзэж болох юм.

Мөн эдийн засгийн салбаруудын хүрээнд үйл ажиллагааны тархалтыг гаргахдаа загварт тулгуурласан шинжилгээний аргыг хэрэглэж болно. Загварчлалд тулгуурласан хэмжилтийн үр дүнтэй холбогдуулан ярьж байсанчлан хэд хэдэн салбарын хэмжээ бидний хүлээж байснаас өөр гарсан юм. Загварчлалд тулгуурласан хэмжилтийн арга нь судалгаанд оролцох өрхүүдийг санамсаргүй сонголтоор сонгодог учраас хазайлтгүй тооцоо гарахад хүргэдэг ч тодорхой салбарт тухайн үйл ажиллагааг ихээр явуулдаг газруудыг орхигдуулах боломжтой байдаг. Тэгвэл загварт тулгуурласан арга нь АБСӨС-д хамрагдаагүй газарт салбарын хэмжээг тодорхойлж дүгнэлт хийх боломж олгох болно.

Мөн энэхүү тооцоог сайжруулах өөр нэг багц арга нь яг энэ зорилгод зориулан авсан хариулагчдын болон тоологчдын эргэх холбооны мэдээлэл бүхий судалгааны хоёр хэсгийг бүрэн дүүрэн ашиглах явдал юм. Эдгээр асуултууд нь хариулагчдын уг судалгаанд үнэн сэтгэлээсээ, ухамсартайгаар хандаж байгаа байдал, асуусан асуулт (тоглоом)-ыг ойлгож байгаа түвшний үнэлгээ, мөн тоологчдын зүгээс хариулагчийн амьжиргааны харьцангуй түвшинг үнэлсэн байдал зэрэг мэдээллийг агуулж байгаа. Энэхүү мэдээллийг эконометрикийн тооцооны явцад тодорхой ажиглалтуудад бусдаас нь илүү их ач холбогдол өгөх, мөн үр дүнг шалгаж баталгаажуулах, тэр ч бүү хэл хариултуудыг засварлахад ч хэрэглэж болно.

Дээр дурдсанаар АБСӨС-ны албан салбарын тухай өгөгдлийг загварчлалд ашиглахаас гадна энэхүү цөөн тооны албан салбарын бизнесүүдээс албан салбарын сүүдэрт оруулж байгаа хувь нэмрийг ойролцоогоор тооцож гаргахад ашиглаж болно. Сүүдрийн эдийн засаг өөрөө ихээхэн хэмжээний албан ёсны бүрэлдэхүүн хэсэг агуулж байж болно гэж бид үздэг учраас ингэж өргөтгөх нь хэдийгээр тооцоо хийхэд нэмэлт төсөөлөл шаардлагатай нөхцөлт тооцоо байж болох ч ашигтай эхлэл ч байж болох юм. Үүний үр дүнд, дор хаяж албан салбарын үйл ажиллагааны тухай нарийвчилсан судалгаа хийхэд зарцуулвал зохих нөөц хөрөнгийн хэмжээний талаар чухал мэдээлэл

олж авч болох юм.

АБСӨС-ны шинжилгээг цаашид боловсронгуй болгох өөр нэг асуудал бол хүмүүсийн зан байдлын шинж тэмдгүүдийг холбож үзэх явдал юм. 5 дугаар хэсгийн хэлэлцүүлэгт зориулсан хүснэгтүүдэд өөр өөр ажил эрхлэлтийн байдалтай хүмүүс хэрхэн ялгаатай байдаг тухай төсөөллийг харуулахын зэрэгцээ салбарын оролцоог зан байдлаас хамаарсан байдлаар цаашид нарийвчлан шинжлэх нь шалтгаант холбоог илрүүлэн гаргах чадварын хувьд илүү их байна. Цаашилбал, зан байдал, хандлагын тухай мэдээллийг ашигласнаар янз бүрийн хувилбар аргуудын хариултуудыг багцлах боломж олгож, улмаар үнэн хэрэгтээ түүврийн хэмжээг нэмэгдүүлж, итгэмжлэх заагийг нарийсгаж болно.

Судалгааг боловсронгуй болгох нь

Судалгааг таван хувилбар буюу аргаар хийсэн бөгөөд нэг гайхалтай нь үржүүлэгчийн аргаар илрүүлсэн нэмэлт нэмэгдэл өртөг ба өрхийн орлоготой холбоотой тооцооны үр дүн хоёулаа нилээд доогуур гарсан явдал юм. Хэдийгээр энэ аргыг хувь хүмүүсийн нууцлалын эрхийг хамгаалахад тохиромжтой гэж үзсэн хэвээр байгаа ч хөдөөд энэхүү арга болон дугтуйн аргыг хэрэглэсний ялгаа их байгаагаас үзэхэд энэ аргыг эдгээр газруудад энэ хэвээр нь ашиглах хэрэггүй болох нь харагдаж байна. Харин бид уг үржүүлэгчийн аргыг бага зэрэг өөрчилж, энэ удаагийн АБСӨС-нд ороогүй нэгэн асуултыг авч үзэхэд хэрэглэж болно гэж үзэж байна. Хэдийгээр бид авилгалын үйл ажиллагаанд оролцох оролцооны талаар асуултад хариулт авсан ч хэдий хэмжээтэйг өгч авсан талаар нарийн мэдээлэл цуглуулахыг оролдсонгүй. Энэ үзүүлэлт тэг бус утгатай байх нь хувийн чанартай эмзэг мэдээллийг илрүүлэх явдал ба үүнд мэдрэмтгий ханддаг үржүүлэгчийн аргын тохиромжтой хувилбарыг боловсруулж, цаашид өгсөн хээл хахуулийн хэмжээг тооцоолж болохуйц судалгаа хийхэд ашиглаж болох юм гэдэгт бид итгэж байна.

Орлогын тайлан болон тайлан тэнцлийг дахин ашиглахын өмнө хоёр боломжийг авч үзэхийг бид санал болгож байна. Нэгдүгээрт, хүмүүсээс орлогынх нь улирлын чанартай өөрчлөлтийн тооцоог гаргаж өгөхийг хүсэхдээ тэднийг нэмэлт боломжуудаар хангаж өгөх нь чухал. Энэ нь улирлын тохируулга хийх тооцоог хөнгөвчилнө. Энэ зорилгод мөн эконометрикийн

аргыг хэрэглэж ч болно. Түүнчлэн хэд хэдэн хувилбарыг хэрэглэж байгаа тохиолдолд АБСӨС-нд цуглуулсан шиг нийлбэр дүнгээр нь биш бүрэлдэхүүн хэсэг бүрийн оруулж байгаа хувь нэмрээр нь нэмэгдэл өртгийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгч байгаа аргыг нь хэрэглэх нь ашигтай байх болно. Нийлбэр дүнгээр нэгтгэх арга нь хариулагчдад нэмэлт нууцлал байдал бий болгож байгаа ч энэ аргын явцад зарим мэдээлэл алдагдах бөгөөд орлогын болон тайлан тэнцлийн нарийн ширийнийг сайн мэддэг болсноор бодлогын шинжтэй нэмэлт утга агуулгыг гаргаж авч болох юм. Цаашилбал, хэрвээ уг судалгааг ирэх жилүүдийн албан бус салбарын сүүдрийн эдийн засгийн хэмжээг шинэчлэн тогтооход ашиглах болвол уг судалгаанд үйл ажиллагааны шилжилт хийх асуудлыг бас бодож үзэх хэрэгтэй болно. Энэхүү төслийг гүйцэтгэхдээ өрх ба аж ахуйн нэгжид суурилсан холимог судалгааны хувилбараас гадна авч үзсэн нэг боломжит хувилбар бол ҮСГ-аас хийгдэж байгаа өгөгдөл цуглуулах хүчин чармайлтад энэ судалгааг хавсарга болгох явдал байсан бөгөөд үүнд хамгийн сайн тохирох нь ҮСГ-ын Өрхийн орлого, зарлагын судалгаа (ӨОЗС) юм. Одоогийн зорилгыг хангахад бие даасан холимог судалгаа явуулах нь илүү тохиромжтой гэж шийдсэн хэдий ч АБСӨС-ны орлого ба тайлан балансын хэсгийг болон бусад сонгосон хэсгүүдийг ӨОЗС-д нэгтгэн авах бололцоотой. Цаашдын судалгаанд онцлон авч үзэх нэг асуудал бол өрхийн гишүүн бүрийн хувиараа хөдөлмөр эрхлэх ажиллагааг хамруулсан илүү бүрэн дүүрэн тооллого хийхийг оролдож үзэх эсэх тухай асуудал юм. АБСӨС-г бодвол ӨОЗС-г хийхэд цаг хугацаа харьцангуй их зарцуулагдах учраас ийм бололцоотой байж болох бөгөөд ингэснээр өрхийн доторх жижиг боловч нэмэлт хөдөлмөр эрхлэлтийн талаар илүү сайн ойлголт өгөх юм.

Тодорхой асуултуудтай холбоотой бусад асуудлууд ч гарч байна. Тайлан тэнцлийн үр дүнг шалгах байдлаар оруулсан тухайн үеийн орлогын тухай 111-р асуулт нь олон тооны аж ахуйн нэгжүүд алдагдалтай ажиллаж байгаагаа илэрхийлсэн учраас тэдний нэмэгдэл өртгийг тооцоолоход чухал ач холбогдолтой болох нь батлагдсан. Орлогын тайлан ба тайлан тэнцлээс

гарах орлогын мэдээг илүү нарийн тусган гаргахын тулд судалгаанд оролцогчдоос орлогын бусад эх үүсвэрүүдээ мэдээлэхийг хүсэх замаар 111-р асуултыг өөрийг нь ч өөрчилж болох юм. Үр дүнг анх бичиж авахдаа болон улирлын тохируулгын тархаалт хийхдээ аль алинд нь алдагдлыг суулгаж өгөх байдлаар орлогын тайлан ба тайлан тэнцэлд тохируулга хийх хэрэгтэй.

Цаашдын судалгааг сайжруулах үүднээс АБСӨС-ны төслөөс ашигтай нэмэлт мэдээлэл гарган авч болох хоёр чухал арга зам байна гэж бид бодож байна. Юуны өмнө судалгаа явуулах зардал ба оролцогчдыг түүвэрлэн сонгох төлөвлөгөө хэрхэн уялдаж байгааг задлан шинжилж үзэх, улмаар цаашдын судалгааны ажилд зориулсан оновчтой хэлбэрийг гаргаж авах явдал юм. Судалгаа хийх замын зардал болон судалгааны бусад зардлын тооцоо маш сайн ойлгогдож болох ч, түүвэр сонголтын тархалтаас болж хэмжих гэж байгаа цаад хувьсамтгай утгуудын талаар маш хязгаарлагдмал мэдээлэл ашиглахад хүргэж байна. Харин эдгээр тоо баримтуудын хувьсах байдлын тухай мэдлэгээ ашиглан түүвэр судалгааны төлөвлөгөөг зардлын үр ашигтайгаар боловсронгуй болгож болно.

Анхаарч үзэх ёстой сүүлийн асуудал бол бидний ашигласан өрхийн ба аж ахуйн нэгжийн холимог судалгааны энэ хувилбарын ерөнхий хүрээг сайжруулж болох эсэх тухай асуудал юм. Бидний хэрэглэхээр авч үзсэн боловч хэрэгжүүлээгүй бас нэг судалгааны бүтэц бол хоёр шаттай түүвэр сонголт бүхий өрх ба аж ахуйн нэгжийн холимог судалгаа байв. Хоёр шаттай түүвэрлэлтийн аргад эхлээд янз бүрийн санамсаргүйгээр сонгосон өрхийн түүврийн хүрээнд товч ярилцлага хийж, хүмүүс албан бус салбарын тухай судалгааны субъект мөн эсэхийг тогтоох ажил ордог. Эхний ярилцлагыг харьцангуй багцлаагүй хэлбэрээр, магадгүй ҮСГ-ын орон нутгийн ажилтнуудыг ашиглан явуулах хэрэгтэй. Дараа нь эхний шатны үр дүнг эцсийн судалгаанд оролцогчдын түүврийг хэсэгчлэн гаргах үед ашиглаж болно. Энэ аргын гол давуу тал бол судалгаанд бүх салбарын зохих төлөөллийг оруулах байдлаар ялгалтыг салбар салбараар хийж болоход оршино.

Хавсралт 1: Санамсаргүйжүүлсэн хариултын СТАТИСТИК ШИНЖҮҮД

Энэхүү тэмдэглэлд эдийн засгийн үйл ажиллагааныхаа тухай хувийн чанартай эмзэг мэдээллийг дэлгэхийг хүссэн асуултад хариулж байгаа судалгаанд оролцогчдын нууцлалыг хамгаалахад чиглэсэн хоёр аргыг танилцуулж байна. Санамсаргүйжүүлсэн хариултын арга нь судалгааны өгөгдлийг цуглуулах үедээ дундуур нь бага зэрэг нэмэлт оруулах замаар оролцогчдыг хамгаалдаг бөгөөд ингэснээр ямар нэг тодорхой хүн хувийн чанартай эмзэг асуултад яаж хариулсныг ярилцлага авагч эсвэл уг өгөгдлийн эцсийн хэрэглэгч мэдэх боломжгүй болгож, хариулагч илчлэгдэх аюулыг багасгаж байгаа юм. Гэхдээ уг аргууд нь сонирхсон чиглэлээр нийт олонлогийн тухай мэдээллээр хангаж өгдөг.

Санамсаргүйжүүлсэн хариултын арга нь хариултыг хувь хүмүүстэй шууд холболгүйгээр нийлбэр утгаар нь гаргадаг учраас олонлогийн тоо баримтуудыг хэмжих талаараа шууд хариултын аргаас давуу байдаг. Гэвч хувь хүний зан чанар ба хувийн зан байдлыг холбосон регресс ашиглах гэх мэт зарим нэг бодлогын шинжилгээний хувьд санамсаргүй хариултын арга ашиг тус муутай байдаг. Иймээс сүүдрийн эдийн засгийн судалгаанаас хамгийн ашигтай мэдээллийг олж авахын тулд санамсаргүй хариултын ба шууд асуултын аргуудыг хоёуланг нь ашиглах зайлшгүй шаардлагатай болно гэж бид төсөөлж байна.

Санамсаргүйжүүлсэн хариултын аргыг 1960-аад оны дунд үеэс буюу Уорнерийн суурь бүтээлийн (1965) дараа үеэс эхлэн хөгжиж байгаа бөгөөд хөгжингүй орнуудын янз бүрийн нөхцөл байдлын хүрээнд ашиглаад байна. Санамсаргүйжүүлсэн хариултын арга техникүүдийг хамгийн анх ашигласан судалгаанууд мансууруулах бодис ба согтууруулах ундааны хэрэглээ, сексийн зан байдал гэх мэт хувийн чанартай эмзэг асуудлуудыг нарийвчлан судалж байв. Одоо уг аргыг эдийн засгийн шууд утга агуулгаар хэрэглэх явдал улам бүр давамгайлж байна. Чаудхюри (1983), Энэтхэг дэх ургац тариалалтын үйлдвэрлэлийн функцийг

тооцох урьдчилсан алхам болгож томоохон хөдөө аж ахуйн судалгаа явуулахдаа орцын ашиглалтыг санамсаргүйжүүлсэн хариултыг ашиглан судласан байна. Бүр саяхан татвараас зайлсхийх явдлыг судлахад (Houston and Tran 2001), мөн Туркэд далд эдийн засгийн хэмжээг судлахад (Savasan 2003) санамсаргүйжүүлсэн хариултын арга техникийг ашиглаад байна.

Санамсаргүйжүүлсэн хариултын талаар асар олон арга боловсруулсан байдаг бөгөөд ном, сурах бичгээс үзэхэд аливаа аргыг тодорхой бэрхшээлтэй асуудал, тодорхой газарт тохируулан хэрэглэхийн тулд маш нарийн судалж үзэх нь зүйтэй байдаг байна. Ер нь санамсаргүйжүүлсэн хариултын аргын хувьд үл хариулагчдын эзлэх хувийг багасгах болон хариулагчдаас хувийн чанартай эмзэг мэдээллийг илрүүлэн олж авах талаараа тодорхой давуу талуудтай байдаг. Сүүдрийн эдийн засгийн судалгаанд зориулж хоёр төрлийн санамсаргүй хариултын аргыг дэвшүүлсэн байдлын нэг нь тийм эсвэл үгүйгээр нь заагласан хоёр сонголттой асуултууд, нөгөө нь олон хариулт бүхий асуултын арга юм. Хоёр сонголттой хариултын хувьд бид хос асуултын арга гэдэг арга техникийг хэрэглэдэг. Харин олон хариултат асуултын үед бид үржүүлэгчийн арга гэгчийг хэрэглэдэг.

Хос асуултын аргад хоорондоо холбоогүй хоёр асуулт тавих бөгөөд нэг нь "Та энэ жил татвар төлөхдөө хуурч мэхэлсэн үү?" гэх мэт хувийн чанартай эмзэг асуулт, нөгөө нь "Та сагсан бөмбөгт дуртай юу?" гэх мэт хүмүүс хариулахад төвөгтэй биш байх гэм хоргүй асуулт байх юм. Шоо хаях, зоос шидэх гэх мэт санамсаргүйжүүлэх хэрэгслийн үр дүнг зөвхөн тухайн хариулагч л ажиглана. Дор үзүүлсэн хэсэгт бид хувийн чанартай эмзэг ба гэм хоргүй асуултууд тус бүр 50 хувь асуугдах магадлалтай байхаар төсөөлөв.

᠕ нь хос асуултын аргаар асуусан асуултад "тийм" гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь байг. Бидний сонирхож буй хувийн чанартай эмзэг асуултад "тийм" гэж хариулагчдын эзлэх хувь нь

Хавсралт 3: Судалгаанд оролцогчдын нэрс

Нээлттэй Нийгэм Форум

Стефан Д. Вэнс, Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн захирал
П. Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форумын захирал
Н. Дорждарь, Форумын менежер
Б. Мөнхсоёл, Форумын менежер

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөл (АНУОУХА, Кемоникс)

Фернандо Бертоли, төслийн удирдагч
Януш Ширмер, төслийн зөвлөх
Ж. Должинсүрэн, эдийн засагч-шинжээч

Зөвлөх баг, Мэриландын их сургуулийн Институцийн шинэтгэл ба албан бус секторын төв

Клиффорд Зиннес, багийн удирдагч
Жонатан Алеви, эдийн засагч
Ч. Нарантуяа, Зөвлөх багийн гишүүн, докторант
Брэнди Сассер, туслах

Үндэсний Статистикийн Газар

П. Бямбацэрэн, ҮСГ-ын дарга
А. Дэмбэрэл, МЭЗБСГ-ийн дарга
Б. Бадамцэцэг, МЭЗБСГ-ийн орлогч дарга
Б. Лхагважаргал, МЭЗБСГ-ын мэргэжилтэн
Д. Пагмасүрэн, МЭЗБСГ-ын мэргэжилтэн

Судалгааны мэдээлэл цуглуулалтанд оролцогчид

А. Золбоо
Б. Лхагважаргал
Б. Баярмаа
Б. Баянмандал
З. Мөнхжаргал
З. Мөнхзул
Л. Мягмарсүрэн
Л. Алтанцэцэг

Б. Наранзул
Б. Хонгорзул
Б. Батбаяр
Б. Оюунцэцэг
Б. Отгонцэцэг
Б. Цэвэлсүрэн
Б. Алтангэрэл
Б. Оюунтуяа
Б. Болормаа
Б. Энхчимэг
Б. Бадамбаяр
Б. Уранбайгаль
Б. Анхтуяа
Б. Булгантамир
Г. Долгорсүрэн
Г. Сайнхүү
Г. Даваасүрэн
Г. Энхбаяр
Г. Жийдиймаа
Г. Дамдинрагчаа
Г. Хэрлэн
Г. Оюунбат
Г. Энхтунгалаг
Д. Энхтайван
Д. Бадрал
Д. Сувдаа
Д. Батчимэг
Д. Энхсайхан
Д. Одмаа
Д. Энхбаясгалан
Д. Наранцэцэг
Д. Отгончимэг
Д. Сарантуяа
Д. Энхболд
Ж. Тэрбиш
Ж. Одгийв
Ж. Батсүх
Ж. Хулан
Ж. Батболд
Ж. Саранцэцэг

Л. Өнөрнасан
Л. Туул
М. Оюун
М. Оюунчимэг
М. Мөнх-Оч
Н. Мөнхзаяа
Н. Батсүх
Н. Жавзанжаргал
Н. Отгонбаяр
Н. Энхтуяа
Н. Алтанцэцэг
Н. Арьяасүрэн
Н. Баярмаа
Н. Дагвадорж
Н. Бямбасүрэн
О. Орхонбаатар
П. Бямбадорж
П. Ганцоож
П. Оргил
П. Үнэнбат
П. Батнасан
П. Батцэцэг
Р. Ойдовданзан
Р. Эрдэнэмандал
С. Оюунцэцэг
С. Энх-Отгон
С. Нарангэрэл
С. Ариунболд
Т. Бодьгэрэл
Т. Ням-Очир
Т. Бүрэнжаргал
Ү. Батжаргал
Ц. Уранбилэг
Ц. Туяа
Ц. Мөнхцацрал
Ц. Бадрах
Ц. Өлзийбат
Ц. Дуламдорж
Ц. Оюунчимэг

Ашигласан материал

Андерсон Ж. (1998). *"Шилжилтийн үеийн Монгол Улсын албан бус салбарын хэлжээ, үүсэл, шинж чанар"*, Бодлогын судалгааны ажлын баримт бичиг, Дугаар 1916, Дэлхийн Банк, 5 дугаар сар.

Бэкер Б. (2000). Үндэсний бүртгэлд зориулсан албан бус салбарын тухай хамгийн бага багц өгөгдөл. *Өрхийн бүртгэл: Үзэл баримтлал ба нэгтгэх туриллагууд*. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн хэрэг эрхлэх департамент: Статистикийн хэлтэс, 143-52. Боть 1. Нью Йорк: Нэгдсэн Үндэсний Байгууллага.

Бикалес Б., Ч. Хүрэлбаатар, К. Шелциг (2000). *"Монголын албан бус салбар: Судалгааны үр дүн, шинжилгээ"*, АНУ-ын ОУХА/ДАИ (Эдийн засгийн бодлогыг дэмжих төсөл).

Эйлат У., С. Зиннес нар (2002). *"Шилжилтийн орнууд дахь сүүдрийн эдийн засгийн үүсэл хөгжил: Эдийн засгийн өсөлт ба донорын тусалцааны үр дагаврууд"*, Дэлхийн Хөгжил, 7 дугаар сар.

Чаудхюри А. (1983). *"Ургацын орцыг тооцоолох СХ-ын арга"*, Калкуттагийн Бюльетин 32: 208-10.

Крамер Ж.С. (1971). *Туришлтын Экономтерикс*, Амстердам: Хойд Голландын хэвлэлийн компани.

Эйчорн Б. Х. ба Л. С. Хэйер (1983). *"Эмзэг тоон мэдээлэл олж авахад зориулсан саналсаргүйжүүлсэн хариултын арга"*, Статистик төлөвлөлт ба дүгнэлтийн сэтгүүл, 7: 307-16.

Хьюстон Ж. ба А. Тран (2001). *"Хольж саналсаргүйжүүлсэн хариултын арга ашигласан татвараас зайлсхийлтийн тухай судалгаа"*, Татвар ногдуулалтын дэвшилүүд, Боть 13. Нью Йорк: Элсевиер.

Киш, Л. (1965). *Судалгааны түүвэрлэлт*, Нью Йорк: Жон Уилий ба Сонс, Корп.

Мүүр Ж. С., ба Л. С. Лүүмис (2001). *"Орлогын талаарх асуултад үл хариулах явдлыг бууруулах үүднээс алтернатив асуултын стратегийг ашиглах нь"*. АНУ-ын тооллогын судалгааны цуврал тайлан. Вашингтон, КТ: АНУ-ын тооллого.

Монгол улсын Үндэсний статистикийн газар (2000). *"Үйлдвэрлэл, орлого, зардлын аргуудаар одоогийн үнээр ДНБ ба ҮНО-г тооцох арга зүй"* Улаанбаатар, Монгол улс.

ЭЗХАХБ (2002). Далд эдийн засгийг хэмжих нь, Парис: Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага.

Савасан Ф. (2003). Туркын далд эдийн засгийг загварчлах нь: Саналсаргүйжүүлсэн хариулт ба МІМІС загварууд. Эдийн засгийн сэтгүүл, Дугаар 1: 49-76.

Уорнер С. Л. (1965). *"СХ: Зайлсхийсэн хариултын хандлагыг арилгах судалгааны арга техник"*, Америкийн Статистикийн Холбооны сэтгүүл 60 (1965): 63-69.

Нэгдсэн Үндэсний Байгууллага (1993). Үндэсний бүртгэлийн систем. Нью Йорк, НҮБ.